СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар/

| **Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт** | **Стратеги /арга зам/** | **Шалгуур үзүүлэлт** | **Суурь түвшин** | **Зорилтот түвшин /4 жилээр/** | **Санхүүгийн эх үүсвэр** | **Биелэлт** | **ХШҮХ-ийн дүн** |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ерөнхий чиг үүрэг-1: Эрүүл мэнд<br>Эрүүл мэндийн чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах; | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана. | | | | | | | |
| Зорилт-1. “Ковид-19” болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг 92 хувьд хүргэнэ. | Арга хэмжээ 1.<br>Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ. | Эмнэлгийн багаж хэрэгсэл, ариутгалын бодис, эм тарианы нөөцийн бэлэн байдлын хангалтын хувь | Эмнэлгийн багаж хэрэгсэл, ариутгалын бодис, эм тарианы нөөцийн бэлэн байдлын хангалт 70%-тай байна. | 92% | УТХО, ОНТХО, ОНХС, төсөл хөтөлбөр, хандив, 32 сая | Коронавируст халдвар /Ковид-19/-т цар тахалд хэрэглэгдэх 6 оношийн бүлгийн нийт 54 нэр төрлийн эм, 16 нэр төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, 5 нэр төрлийн ариутгалын бодисын нөөцөд тасалдал үүсээгүй. Нөөцийн бэлэн байдлын хангалт 83% байна.<br>Биелэлт 90% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа, тандалт сэргийлэлтийн ажлыг зохион байгуулна. | Зорилтот бүлгийн хамрагдалтын хувь | Хүн амын 45%-ийг хамруулах | Зорилтот бүлгийн хамрагдалт 60% | - | 2 жилийн хугацаанд давхардсан тоогоор эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлсэн 84000 гаруй иргэнийг халдвараас сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлын талаарх мэдээлэл, сурталчилгаанд хамруулж, дунджаар хүн амын 72.2%-ийг хамруулсан.<br>Биелэлт 100% | 100 |
| Зорилт-2. Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Тохиолдлын удирдлагын тогтолцоонд суурилсан хариу арга хэмжээний төлөвлөгөөг эрсдэлийн түвшин бүрээр нарийвчлан гаргаж, | Төлөвлөгөөг тодотгосон байдал, түүнтэй холбогдуулан гаргасан эрх зүйн актууд. | 15 зорилт 19 арга хэмжээ бүхий төлөвлөгөөтэй. 2020 оны А/177, А/266 захирамж | Төлөвлөгөөг тодотгож, холбогдох эрх зүйн акт, хэм хэмжээг боловсруулж ажилласан байна. | | МУЗГ-ын 2021 оны 45 дугаар тогтоолын дагуу "Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг чангатгах, эрчимжүүлэх төлөвлөгөө"-г 12 бүлэг 107 арга хэмжээтэйгээр аймгийн Засаг даргаар батлуулан, 2 удаа тодотгол хийж, бүх сум, тосгон, холбогдох байгууллага, албадад хүргүүлж, өдөр бүр сумдын эрүүл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай бүр тодотгож ажиллах | | | | | мэндийн албанаас мэдээ авч нэгтгэн ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 87.5%-тай байна. Эрсдэлийн үнэлгээг 2 удаа хийж, улбар шар түвшингээс магадлал бага эрсдэл буюу ногоон түвшинд шилжээд байна.<br>Биелэлт 50% | |
| Зорилт-3. Нийт хүн амын 65%-ийг, зорилтот бүлгийн 70%-ийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад, үзлэг, шинжилгээнд хамруулна. | Арга хэмжээ 1.<br>Жил бүр алслагдсан нутгийн иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулна. | Зорилтот бүлгийн хамрагдалтын хувь | Зорилтот бүлгийн хамрагдалт 45% | Зорилтот бүлгийн хамрагдалт 70% | ОНТХО, 80 | Алслагдсан хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөл, эмгэгүүдийг эрт илрүүлэх зорилгоор 4 бүсийн 23 сум, тосгонд НЭмнэлэг болон 3-р шатлалын эмнэлгүүдийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг жил бүр зохион байгуулж, үзлэгт зорилтот бүлгийн 14600 гаруй хүнийг хамруулж шинээр илэрсэн өвчлөлийн тохиолдлыг эмчийн хяналтад авч ажилласан. Дунджаар зорилтот бүлгийн хүн амын 58.3%-ийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан.<br>Биелэлт 80% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Зонхилон тохиолдох халдварт бус өвчний анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлийг бууруулах сургалт сурталчилгаанд нийт хүн амыг хамруулах кампанит ажил зохион байгуулах | Сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь | 53.0% | 65% | | Зонхилон тохиолдох халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр 2021 онд 11 төрлийн, 2022 онд 32 төрлийн арга хэмжээг 28 эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч зохион байгуулснаар давхардсан тоогоор 85000 гаруй иргэдийг хамруулж зорилтот бүлгийн хамрагдалтын дундаж 70.7%-тай байна.<br>Биелэлт 100% | 100 |
| | Арга хэмжээ 3.<br>Хүн амын 70 хувийг эрдэс бодис, макро элементийн (Д, кальци) оношилгоонд хамруулж, эмчилгээний хамрагдалтыг 20-с доошгүй хувьд хүргэнэ. | Хүн амын Д витамины дутагдлыг бууруулсан хувь | Иргэдийн 90%-д нь витамин Д дутагдал илэрч байна | Хүн амын Д витамины дутал 20 хувиар буурна | УТХО, Төсөл хөтөлбөр, ОНТХО, ОНХС, бусад, 32 | Нэгдсэн эмнэлэг нь Д витамин тодорхойлох аппаратаар 2021 онд хангагдсан ба уг шинжилгээг өндөр өртөгт шинжилгээний тоонд оруулж ЭМД-аас 2022 оны 8 сараас эхлэн хөнгөлөлттэйгөөр авч эхэлсэн. Нэгдсэн эмнэлэг болон хувийн лабораторид 684 иргэн (Д, кальци) оношилгоонд хамрагдаж, тэдгээрийн 581 хүн буюу 85%-д нь Д | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | витамины дутагдал илэрч эмчилгээнд хамруулсан. Мөн коронавируст халдвартай оношлогдсон 5912 иргэнийг Д-ын эмчилгээнд хамруулснаар Д-ын дутагдлыг 8.3%-иар бууруулсан. Биелэлт 40% | |
| Зорилт-4. Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, орон нутгийн анхан шатны эмч, мэргэжилтний 85 хувийг сургагч багшаар бэлтгэнэ. | Арга хэмжээ 1. УАУЭмнэлгийн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх /зүү, засал, дотор, мэдрэл, ахмад, яаралтай тусламж/ | Тусламж үйлчилгээний төрлийн тоо | 2 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. | 2 төрлийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх | | Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь хэвтэн эмчлүүлэх 51 ортой байсныг ЭМГ-ын даргын тушаалаар өдрийн эмчилгээний 6 орыг нэмж, сонгон шалгаруулалт зарлан, зүү болон засал эмчилгээний тусламж үйлчилгээг шинээр нэмэгдүүлэн ажиллаж байна. Биелэлт 100% | 70 |
| | Арга хэмжээ 2. Анхан шатны эмч мэргэжилтнийг уламжлалт анагаах ухааны сургагч багшаар үе шаттай бэлтгэх | Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний хувь | Сургалт зохион байгуулагдаагүй байна. | 85% | | ОНХСангаар 18.1 сая төгрөгийн санхүүжилтээр "Эрүүл аж төрөх Монгол ухаан" сургалтын төвийг тохижуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. 2021 онд АШУҮИС-ын МУАҮИСургуультай хамтран 4 удаагийн цахим сургалтад 130 эмч, мэргэжилтэн, 2022 онд Зүүн бүсийн хэмжээнд "Уламжлалт анагаах ухааны судлал, зүү, эмчилгээний аргачлал, тохиолдолд суурилсан" сэдэвт 2 багц цагийн танхим, практик хосолсон сургагч багшийн сургалтад 21 ЭМБайгууллагын 148 эмч, мэргэжилтнүүдийг тус тус хамруулсан. Тэдгээрийн 70 нь сургагч багшийн шалгуурыг хангаН сум, өрхийн ЭМТөвүүдэд ажиллаж байна. Биелэлт 50% | 70 |
| Зорилт-5. Хеликобактеритай тэмцэх, хянах арга хэмжээг хэрэгжүүлж нянгийн шалтгаант ходоодны архаг үрэвслийг эрт илрүүлж, | Арга хэмжээ 1. Хеликобактерийн зорилтод насны хүн амын нарийвчилсан судалгаа гаргаж, эрсдэлийг үнэлэх | Эрсдэлийг үнэлсэн хүн амын хувь | 2019 оны байдлаар 400 гаруй иргэн оношилгоонд хамрагдсан байна. | 80% | | Аймгийн хэмжээнд 30-60 насны хеликобактерийн эрсдэлт бүлгийн 12365 иргэн байгаагаас анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад 9206 иргэн түргэвчилсэн шинжилгээнд хамрагдсан. Эерэг гарсан 749 иргэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| түүнээс үүссэн өвчлөлийн хүндрэлээс сэргийлэх арга хэмжээ зохион байгуулна. | | | | | | ЭМД-аар аймгийн Нэгдсэн эмнэлэг болон хувийн лабораторид тоолуулах шинжилгээнд хамрагдан, эмчийн хяналтад орж, эмчилгээнд хамрагдсан байна. Эрсдэлт бүлгийн хамрагдалт 51.8% байна. Биелэлт 60% | |
| | Арга хэмжээ 2. Шинж тэмдэг бүхий иргэдийг үзлэг, шинжилгээнд хамруулж, эмчийн хяналтанд оруулна. | Хамрагдалтын хувь | 0 | 90% | | Нэгдсэн эмнэлгийг хеликобактери илрүүлэх шинжилгээний аппаратаар хангаж, шинжилгээнд эерэг гарсан үйлчлүүлэгчдийн 28%-ийг эмчийн хяналтад авч, эмчилгээнд хамруулж байна. Биелэлт 30% | 90 |
| Зорилт-6. Сүрьеэ, БЗДХалдварын эрт илрүүлэлтийг эрчимжүүлэн, эмчилгээний үр дүнг 90-с доошгүй хувьд хүргэнэ. | Арга хэмжээ 1. Сүрьеэгийн эрт илрүүлгийг зохион байгуулж, эмчилгээний хамрагдалт, чанарыг сайжруулна. | Эмчилгээний хамрагдалтын хувь | Сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт 85%, | сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт 93%, | УТХО, Төсөл хөтөлбөр, ОНТХО, ОНХС, 8 | 2021 онд сүрьеэгийн 82 шинэ тохиолдол, 2022 онд 102 шинэ тохиолдол бүртгэгдэж, эмчилгээний амжилт, үр дүн 92%-тай байна. Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгээр 3034 хүнийг хамруулж 670 хүний цэрний сорьцыг цуглуулан, хавьтлын 24 хүнийг далд халдварын эмчилгээнд оруулсан. Мөн сүрьеэгийн шинэ эмнэлэгт шаардлагатай байгаа 6.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. Биелэлт 90% | 100 |
| | Арга хэмжээ 2. БЗДХ-ын эрт илрүүлгийг эрсдэлт бүлгийн хүн амд зохион байгуулж, хавьтал илрүүлэлтийн эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Эмчилгээний хамрагдалтын хувь, хавьтал илрүүлэлтийн тоо | БЗДХалдварын эмчилгээний хамрагдалт 89%, хавьтал илрүүлэлт 0.5 байна. | БЗДХ-ын эмчилгээний хамрагдалт 98%, хавьтал ирүүлэлт 1 | | Бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэх үзлэгт 1157, идэвхтэй хяналтад 44, амбулаторийн үзлэгт 173 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс шинэ өвчлөл 11, хуучин 2 өвчлөл илэрсэн. Нийт 180 үйлчлүүлэгчийг эмчилгээнд хамруулсан ба эмчилгээний хамрагдалт 100%, хавьтал илрүүлэлт 0.7%-тай байна. Биелэлт 85% | 100 |
| Зорилт-7. Гуравдугаар шатлалын эмнэлэгтэй хамтран зонхилон тохиолдож буй хавдрыг эрт илрүүлэх арга хэмжээг зохион | Арга хэмжээ 1. Хавдрын эрт илрүүлэгт хамрагдах зорилт бүлгийн иргэдийн судалгааг сумдын ЗДТГазартай хамтран | Судалгаа гаргасан эсэх | - | судалгааг харьяаллын дагуу нэрсээр нь гаргаж, үзлэг зохион байгуулах бэлэн байдлыг хангана. | | Хавдрын эрт илрүүлэгт хамрагдах зорилт бүлгийн иргэдийн нарийвчилсан судалгааг гарган, хавдрын төрөл бүрээр хамрагдалтыг тооцон ажиллаж байна. Мөн аймгийн Засаг даргын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| байгуулж, 45-с дээш насны иргэдийн 70-с доошгүй хувийг хамруулна. | нарийвчлан гаргаж ажиллах | | | | | сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээний хавсралтад зорилтот насны иргэдийн хавдрын эрт илрүүлэгт хамруулах шалгуурыг тусгаж, хангалтгүй ажилласан сумдын удирдлагуудад чиглэл хүргүүлэн ажиллаж байна.<br>Биелэлт 100% | 100 |
| | Арга хэмжээ 2. Зонхилон тохиолдож буй хавдрыг эрт илрүүлэх үзлэгийг гуравдугаар шатлалын эмнэлэгтэй хамтран зохион байгуулж ажиллах. | Зорилтот бүлгийн хамрагдалтын хувь | 2019 оны жилийн байдлаар хавдрын зорилтот бүлгийн хамрагдалт 38.9%-тай байна. | 47% | УТХО, Төсөл хөтөлбөр, ОНТХО, ОНХС, бусад, 170 | Хавдрын үзлэг шинжилгээг АШУҮИС-ийн Монгол-Японы нэгдсэн эмнэлэг болон УХТЭ-ийн эмч нартай хамтран зохион байгуулж, зорилтот бүлгийн 14002 иргэнийг хамруулснаас 108 тохиолдол шинээр бүртгэгдэж, эмчийн хяналтад авсан. Зорилтот бүлгийн буюу 45-с дээш насны иргэдийн 51.5 хувийг хамруулсан. Мөн хавдрын судас бөглөх эмчилгээг 5 үйлчлүүлэгчид, зүрхний титэм судсанд стент тавих эмчилгээг 1 үйлчлүүлэгчид, тархины судасны оношилгоог 8 үйлчлүүлэгчид тус тус хийсэн.<br>Биелэлт 100% | 100 |
| Зорилт-8. "Эрүүл ирээдүй", “Эх хүүхдийн эрүүл мэнд” арга хэмжээг салбар дундын оролцоотой зохион байгуулж 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1 промилиор бууруулна. | Арга хэмжээ 1. "Эрүүл ирээдүй" арга хэмжээг зохион байгуулна. | 2-12 насны хүүхдийн хамрагдалтын хувь | - | 2-12 насны хүүхдүүдийн 100%-ийг арга хэмжээнд хамруулсан байна. | УТХО, Төсөл хөтөлбөр, ОНТХО, ОНХС, бусад, 50 | Аймгийн хэмжээнд 2-12 насны 18845 хүүхэд байна. Үүнээс "Эрүүл-ирээдүй" арга хэмжээний хүрээнд зохион байгуулж буй эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтод бүлгийн 54.0%-ийг буюу 10182 хүүхдийг хамруулсан байна. Үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 61,4%-д нь шүдний цоорол оношлогдож байгаа ба эрүүлжүүлэх арга хэмжээг төр болон хувийн хэвшлийн 8 шүдний эмнэлэгт хийж байна.<br>Биелэлт 60% | 70 |
| | Арга хэмжээ 2. "Эх хүүхдийн эрүүл мэнд" арга хэмжээг зохион байгуулж, 5 хүртэлх насны | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2020 онд 15.8 промиль. | 13.8 | УТХО, Төсөл хөтөлбөр, ОНТХО, ОНХС, бусад, 21 | Эх, хүүхдийн чиглэлээр ЭМБ-дад зөвлөмж 6 удаа, хяналт үнэлгээ 4 удаа, цахим хурал 3 удаа хийж арга зүйгээр ханган ажилласан. Жирэмсний эрт үеийн хяналт 90.1 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.2 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүүхдийн эндэгдлийг 1 промилиор бууруулна. | | | | | хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдэл 8 буюу 8.3 промиль болж өмнөх оны мөн үеэс 3.0 промилиор, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 13 буюу 13.5 промиль болж өмнөх оны мөн үеэс 0.5 промилиор тус тус буурсан үзүүлэлттэй байна.<br>Биелэлт 90% | |
| Зорилт-9. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг хэрэгжүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 55-с доошгүй хувийг эмчилгээнд хамруулна. | Арга хэмжээ 1.<br>"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний хүрээнд вирустэй иргэдийн эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Эмчилгээний хамрагдалт | Элэгний Д вирусийн эмчилгээний хамрагдалт 27.9%-тай. | 55% | | "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 11245 иргэнийг шинжилгээнд хамруулж 7670 иргэнд элэгний вирусийн халдвар оношлогдсон. Тэдгээрийн 5137 нь В болон Д вирусийн халдвартай батлагдсаныг эмчийн байнгын хяналтад авч, 1538 иргэн идэвхжил бууруулах эмчилгээнд хамрагдсан. Эмчилгээний хамрагдалт 30%-тай байна.<br>Биелэлт 50% | 90 |
| Зорилт-10. "Эрчүүдийн эрүүл мэнд" арга хэмжээг зохион байгуулж, нийт эрчүүдийн 60-с доошгүй хувьд хүрч ажиллана. | Арга хэмжээ 1.<br>Эрчүүдийн эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт болон эрт илрүүлэгт хамрагдах зан зүйлд сургах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | Арга хэмжээнд хамрагдсан эрчүүдийн хувь | Эрчүүдэд зориулсан тусгайлсан нөлөөллийн арга хэмжээ байхгүй. | нийт эрчүүдийн 90%-д нөлөөлнө. | | Аймгийн хэмжээнд 19-65 насны 23120 эрчүүд байгаагаас эрүүл мэндийн цогц үзлэг, оношилгоонд 8092 иргэнийг, нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд 17340 иргэнийг тус тус хамруулснаар зорилтот бүлгийн 45%-д хүрч ажилласан. Өссөн дүнгээр эрчүүдийн 65.1%-ийг тус арга хэмжээнд хамруулсан байна. Мөн эрсдэлт бүлгийн эрчүүдийн дунд халдварт ба халдварт бус өвчнийг илрүүлэх үзлэг, оношилгоонд 4 сумын 284 эрчүүдийг хамруулахад 12 хувьд өвчлөл илэрснийг эмчилгээнд хамруулсан.<br>Биелэлт 70% | 70 |
| | Арга хэмжээ 2.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторит "Эрчүүдийн кабинет" байгуулах | Кабинет байгуулсан эсэх | Кабинет байхгүй. | Кабинет байгуулсан байна. | УТХО, Төсөл хөтөлбөр, ОНТХО, ОНХС | Эрчүүдийн кабинет байгуулан үйл ажиллагааг тогтмолжуулан Нэгдсэн эмнэлгийн даргын тушаалаар Мэс засал 2 тасгийн эрхлэгч эмчийг томилон ажиллуулж, 256 эрчүүдийг үзлэгт хамруулж, зөвлөгөө өгч ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Биелэлт 100% | |
| | Арга хэмжээ 1. Яаралтай тусламжийн зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн стандартын хангалтыг нэмэгдүүлэх | Стандартын хангалтын хувь | Стандарт үзүүлэлттэй харьцуулахад 62% хангагдсан | 69% | УТХО, ОНТХО | Яаралтай тусламжийн эмийн нөөцийг 49 төрөл, хувийн хамгаалах хэрэгслийг 15 нэр төрөл, ариутгалын бодисын 5 нэр төрлийн нөөцийн бүрдүүлэлт хийж, хангалт 72%-тай байна.<br>Биелэлт 100% | 100 |
| Зорилт-11. Яаралтай тусламжийн бэлэн байдал, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн стандартын хангалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 2. Яаралтай тусламжийн бэлэн байдал, багаж тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | Стандарт үзүүлэлттэй харьцуулахад 45% хангагдсан | 55% | УТХО, ОНТХО, ОНХС, төсөл хөтөлбөр, 3.4 тэрбум | 2021 онд УТХО, ОНТ, ОНХС, Гамшгийн эрсдэлийн сангийн 499.2 сая төгрөгийн санхүүжилтээр 25 эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийг олгосон. 2022 онд УТХО-р яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах зорилгоор 2.1 тэрбум төгрөг, эрүүл мэндийн дэмжих төвд 1.1 тэрбум төгрөг, нийт 3.2 тэрбум төгрөгийн багаж тоног төхөөрөмжүүдээр хангаад байна. Мөн ОНТХөрөнгө оруулалтаар Дархан, Батширээт суманд шүдний тоног төхөөрөмж 39.0 сая төгрөг, Норовлин СЭМТөвд моргийн хөргүүр 8.0, Нэгдсэн эмнэлэгт хеликобактерийн шинжилгээ, ELISA аппарат 63.4 нийт 110.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр хангалт 58.5%-тай байна.<br>Биелэлт 100% | 100 |
| Зорилт-12. Эрүүл мэндийн байгууллагуудын шаардлагатай барилга, автомашин, багийн эмчийг унаажуулах асуудлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | Арга хэмжээ 1. Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийг барилгын асуудлыг шийдвэрлэж чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | Шинээр баригдсан болон өргөтгөл, засвар хийгдсэн барилгын тоо | 14 ЭМБайгууллагын барилгын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. | 2-с доошгүй ЭМБ-ийн шинэ барилга, өргөтгөл, засвар хийсэн байна. | УТХО, ОНТХО, ОНХС, төсөл хөтөлбөр, 6.6 тэрбум | 2021 онд Улсын төсвийн 0.8 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан, Өлзийт, Батширээт сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажил, шинээр баригдаж байгаа ХБУлаан, Өмнөдэлгэр, Биндэр сумын эрүүл мэндийн төвийн ажил, Гурванбаян тосгоны ЭМТ, УАУЭ, НЭмнэлгийн төрөх тасгийн их засварын нийт 4.1 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэгч нартай гэрээ байгуулан ажилласан.<br>2022 онд Баянхутаг СЭМТөвийн их засвар 300.0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлгийн халдвартын эмнэлгийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | их засваруудыг 175.3 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн. Мөн УТХОруулалтаар нийт төсөвт өртөг 4.6 тэрбум төгрөгөөр Батноров, Дадал, Галшар, Дархан, Батширээт сумын эрүүл мэндийн төвүүдийн өргөтгөлийн барилгын ажлуудыг "Си Эйч Би Жи" ХХК, “Мандалт Констракшн” ХХК, "Баян төхөмийн хурд", “Виндер Гарден” ХХК, “Төгс Буянт Өргөө“ ХХКомпаниуд хийж гүйцэтгэсэн. Барилгын ажлын явц 20-70%-тай байна. Мөн энэ онд нийт 4.3 тэрбум төгрөгийн өртөгтэйгөөр шинээр баригдаж эхэлсэн Өмнөдэлгэр, Биндэр, ХБУлааны тосгоны ЭМТөвүүдийн шинэ барилгын ажлын явц 85%-ийн гүйцэтгэлтэй байна.<br>Биелэлт 70% | |
| | Арга хэмжээ 2.<br>Авто машин нэн шаардлагатай Эрүүл мэндийн байгууллагыг авто машинаар хангах | ЭМБ-д олгосон автомашины тоо | 15 ЭМБ-ыг авто машинаар хангах шаардлагатай байна. | 2-с доошгүй ЭМБ-ийг автомашинаар хангах | УТХО, ОНТХО, ОНХС, төсөл хөтөлбөр, 1.1 тэрбум | 2021 онд 56.6 сая төгрөгийн санхүүжилтээр 3 ЭМБ-ыг, 2022 онд 382,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 6 ЭМБ-ыг шинээр автомашинаар тус тус хангасан. Автомашиныг үндсэн хөрөнгөнд бүртгэж ашиглалтад хяналт тавин ажиллаж байна.<br>Биелэлт 100% | 100 |
| | Арга хэмжээ 3.<br>Багийн эмчийг унаагаар хангах | Унаагаар хангагдсан багийн эмчийн тоо | 2019 оны жилийн байдлаар 7 багийн эмчийг унаагаар хангасан. | 3 багийн эмчийг унаагаар хангах | УТХО, ОНТХО, ОНХС, төсөл хөтөлбөр, 30 сая | Багийн эмчийг унаагаар хангах ажлыг сумдын Засаг дарга нарын гэрээний хавсралтад оруулан ажиллаж, Баянхутаг, Баян-Адарга сумдууд 14.5 сая төгрөгийн санхүүжилтээр багийн эмчийг унаажуулсан. Цаашид ОНӨГазарт хүсэлт хүргүүлж хуучин автомашинуудыг эрүүл мэндийн төвүүдийн багийн эмч нарт олгуулах хүсэлтийг уламжлахаар ажиллаж байна.<br>Биелэлт 30% | 30 |
| Зорилт-13. ЭМБайгууллагад цахим үйлчилгээг бүрэн | Арга хэмжээ 1.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн | Аймгийн НЭ-ийн амбулаторийн | Цахимжуулалтын ажлын гүйцэтгэл 55% | 100% | УТХО, ОНТХО, ОНХС, төсөл хөтөлбөр | ОНТХО, ОНХС-с нийт 24.4 сая төгрөгийн 14 ширхэг компьютерыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, 4 өрхийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| нэвтрүүлж, оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, мэдээллийн сан үүсгэнэ. | амбулаторийн үйлчилгээг бүрэн цахимжуулж, мэдээллийн сан үүсгэх | үйлчилгээг цахимжуулсан хувь | Одоогоор ЭМБайгууллагууд хур системд холбогдох эхний шатны ажил болох туршилтын шатандаа явж байна | | | ЭМТөвд олгосон ба цахим программ хангалт /ehealth/ ашиглалт 75%-тай явагдаж байна. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэгт киоск машиныг ашиглалтад оруулж иргэд үзлэгийн цаг авах болон лабораторийн шинжилгээг хүлээгдэлгүй авах боломж бүрдсэн. ЭМЯ болон бусад эрүүл мэндийн байгууллагуудтай 59 удаагийн цахим хурал, сургалтыг зохион байгуулж ажилласан. Сар бүр шинээр гарсан тушаал шийдвэртэй холбоотойгоор ЭМБайгууллагууд цахим хөгжүүлэлтийг тухай бүр хийж байна. H-info-бүх ЭМБ, e-health-2 НЭ, e-hospital-25 программыг анхан шат ЭМБ, health.gov.mn-ыг бүх ЭМБ өдөр бүр үйл ажиллагаандаа ашиглаж байна. | |
| | Арга хэмжээ 2. Алсын зайн технологи ашиглаж оношилгоо, эмчилгээг цаг алдалгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллах | Зайн оношилгоог бүрэн нэвтрүүлсэн ЭМБайгууллагын тоо | АНЭмнэлэгийн 1 тасаг одоогоор онлайнаар оношилгоо эмчилгээ, зөвлөгөө өгөх чиглэлээр ажиллаж байна. | шинээр 5 ЭМБ-д нэвтрүүлэх | УТХО, ОНТХО, ОНХС, төсөл хөтөлбөр | 6 сумын эрүүл мэндийн төв шилэн кабельд холбогдсоноор аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй цахимаар холбогдон эмнэлзүйн зөвлөгөө авах боломж бүрдсэн. Алсын зайн технологийг ашиглан аймгийн 2, 3-р шатлалын эмнэлэгтэй Бор-Өндөр нэгдсэн эмнэлэг, АНЭ эх барих яаралтай тусламжийн чиглэлээр 14, мэдрэлийн тусламж үйлчилгээний чиглэлээр 7, сэхээн амьдруулах чиглэлээр 5 удаа тус тус телемедиценээр зөвлөгөө авч ажилласан.<br>Биелэлт 75% | 100 |
| Зорилт-14. Орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эмийн бодлогыг хэрэгжүүлж, эмийн зохистой хэрэглээг сурталчилж, эрүүл мэндийн байгууллага бүр антибиотикийн хэрэглээнд хяналт | Арга хэмжээ 1. Орон нутагт эмийн бодлогыг хэрэгжүүлж, эмийн чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлнэ. | Бодлогын хэрэгжилтийн хувь | 0% | Эмийн бодлогын хэрэгжилтийн хувь 89%-д хүрсэн байна. | | Эмийн бодлогын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, 7 зорилт, 25 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө батлуулан ажилласан. Уг төлөвлөгөөнд тусгагдсан 25 үйл ажиллагаанаас хэрэгжилт хангалттай 21 арга хэмжээ, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай 4 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт 84%-тай байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| тавих ажлыг зохион байгуулна. | | | | | | Мөн орон нутагт эмийн бодлогыг хэрэгжүүлэх, сурталчлах ажлын хүрээнд Баян-Адарга суманд 200 орчим эрдэмтэн судлаач оролцсон "Эмийн ургамлын хэрэглээ, тархалт, нөөц, ач холбогдол" сэдэвт ЭШХурал зохион байгуулж, Хэнтий аймгийн ховор ургамлын лавлах, номыг хэвлүүлсэн.<br>Биелэлт 100% | |
| | Арга хэмжээ 2. ЭМБайгууллага бүр антибиотикийн хэрэглээнд хяналт тавих ажлыг зохион байгуулна. | Хяналт тавьсан эмийн сангийн хувь | ЭМБайгууллагууд антибиотикийн хэрэглээнд хяналт тавихгүй байна. | нийт эмийн сангийн 100%-ийг хамруулна. | | Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлгийг антибиотик мэдрэг чанарыг тодорхойлоход шаардлагатай 39 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. Нийт 23 ЭМТ–үүд эмийн зохистой хэрэглээ болон антибиотикийн зохистой хэрэглээ сарын аян зохиож иргэдэд эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг мэдээллийг олгосон. Мөн эмч нарын жор бичилтэд хяналт тавьж арга зүйгээр хангаж ажилласнаар антибиотик эмийн жор бичилт өмнөх оныхоос 10% буурсан. “Эмийн санд тавих нийтлэг шаардлага” MNS 5260:2015 стандарт 13.3, 14.3.4, 20.2.1 заалтын дагуу сумдын 10, Хэрлэн сумын 14 эмийн санд шалгалт хийж, нийт эмийн сангийн 50%-ийг хамруулсан байна.<br>Биелэлт 80% | 70 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Ерөнхий чиг үүрэг-1: Боловсрол- Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах; | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх; | | | | | | | |
| Зорилт-1. Бэрх хотод олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургалтын чанарын стандартыг дэлхийн жишигт нийцүүлэх зүүн бүсийн аймгуудын төв сургууль байгуулна. | Арга хэмжээ 1.<br>640 хүүхдийн суудалтай сургууль, 150 ортой дотуур байрны барилгыг ашиглалтад оруулна. | Барилга баригдсан эсэх | Барилгын ажил явагдаж байна. | Сургууль, дотуур байрны барилга баригдаж, ашиглалтад орсон байна. | УТХО | Бэрх хотод олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын зүүн бүсийн аймгуудын төв сургуулийг байгуулсан. Одоогоор Дорнод аймгаас 17, Сүхбаатар аймгаас 53, Улаанбаатар хотоос 45, Хэнтий аймгаас 93 суралцагч суралцаж байна. Аймгийн Засаг дарга болон “Шинэ эрин” ОУ-ын сургууль | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран байгуулсан дэмжлэг үзүүлэн ажиллах менежментийн гэрээний дагуу 2 удаагийн уулзалт зөвлөгөөн, туршлага судлах үйл ажиллагаа хийгдсэн. 9 дүгээр сарын 5 -ны өдөр ашиглалтад орж 208 суралцагчтай сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 150 ортой дотуур байранд олон улсын сургуулийн 161 хүүхэд, Бэрх ЕБС-ийн 31 хүүхэд нийт 192 хүүхэд амьдарч байна.<br>Биелэлт 100% | |
| | Арга хэмжээ-2<br>Хүний нөөцийг бэлтгэн шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн хангана. | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан эсэх | Автобус нийлүүлэгдсэн, сурах бичиг нийлүүлэлтийн шатанд явж байна. Хүний нөөцийн асуудал шийдвэрлэгдээгүй байна. | Шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. | ОНТХО- | Хүний нөөцийн хувьд үндсэн 43 ажилтан, албан хаагчтай үүнээс удирдах ажилтан-4, багш-17, туслах ажилтан-22 ажиллаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд Олон Улсын сурах бичиг 73 нэр төрлийн 1681 ширхэг, Үндэсний хөтөлбөрийн сурах бичиг 66 нэр төрлийн 3324 ширхэг, Бусад 233 нэр төрлийн 1053 ширхэг сурах бичгээр 100 хувь хангагдлаа. Олон улсын сургалтын стандартад нийцсэн тусгай зориулалтын физик, хими, байгалийн ухаан, дуу хөгжим, мэдээлэл зүйн кабинетэд 53 нэр төрлийн 299,178,000 төгрөгийн тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг шат дараатайгаар олгосон. АЗДТГ-аас Бэрх сургуулийн хичээл сургалтын үйл ажиллагаанд 5,000,000 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Биелэлт 40% | 50 |
| Зорилт-2. Судалгаанд үндэслэн зарим сургуулийн хэв шинжийг өөрчилнө. | Арга хэмжээ 1.<br>Судалгаа, сургалтын чанар, ажлын үр дүнгийн үзүүлэлт зэргийг харгалзан шаардлагатай сургуулийн хэв шинж, бүтцийг өөрчилнө. | Хэв шинж өөрчилсөн сургуулийн тоо, ингэснээр сургалтын чанар өөрчлөлт гарсан эсэх | 12 жилийн сургалттай 12 сургууль байна. | 3-аас доошгүй сургуулийн хэв шинжийг өөрчилж, сургалтын чанарт ахиц гарсан байна. | | Хэрлэн 5 дугаар сургуулийг шинээр байгуулах, Бор-Өндөр ЦС-ийг бага сургууль, Цогцолбор сургууль болгон салгах, Өлзийт ЕБС-ийг суурь боловсролын сургууль болгох, Хэрлэнбаян Улаан тосгоны цэцэрлэгийг бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор болгох судалгааг хийж Аймгийн Засаг | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даргын удирдлагын зөвлөлд танилцуулсан. Хурлын шийдвэрээр Өлзийт ЕБС-ийг суурь боловсролын сургууль болгох, Бор-өндөр цогцолбор сургуулийн ангилалд өөрчлөлт оруулан дунд, ахлах ангийн суралтын үйл ажиллагааг явуулахаар өөрчилж, Бор-өндөр бага сургуулийг шинээр байгуулах болгон Засаг даргын захирамж гараад байна.<br>Биелэлт 50% | |
| Зорилт-3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Чадварлаг багш, чанартай боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ | Арга хэмжээ 1.<br>Арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | Сургалтын чанарт ахиц гарсан байна. Багш нарын чадвар сайжирсан байна. | ОНТХО<br>26 сая | Гүрэн академи, бусад төрийн бус байгууллагуудтай хамтран 25 удаагийн сургалтад давхардсан тоогоор 4023 багш удирдах ажилтныг хамруулан сургалт зохион байгуулсан. Арга хэмжээнд 30 гаруй сая төгрөг зарцуулсан. БШУ-ны яам, БҮТ-тэй хамтарсан "Хэнтий аймгийн суралцагчдын сурлагын хоцрогдлыг арилгах хөтөлбөр" боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд 2 удаа 7 судлагдахууны 315 багш ЭЕШ өгөх 345 сурагчийг хамруулан сургалт зохион байгуулж Хэрлэн сумын ЕБС-ийн 12 дугаар ангийн 400 суралцагчаас ЭЕШ-ын 8 хичээлээр таблетэд суурилсан шалгалтын авч үзэхэд аймгийн дундаж 44.9%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар ахисан үзүүлэлттэй байсан. Арга хэмжээний хүрээнд 3 шилдэг сургууль, 5 цэцэрлэг, 2 мэргэжлийн хөгжлийн бүлэг, 26 багшийн 10 сая төгрөгөөр, ЭЕШ амжилт гаргасан багш, суралцагчдыг 26сая төгрөгөөр шагнаж урамшуулсан.<br>Биелэлт 50% | 70 |
| Зорилт-4. Боловсролын байгууллагын удирдах албан тушаалтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг | Арга хэмжээ 1.<br>Жил бүр удирдах ажилтнуудын сургалтыг зохион байгуулж, үр дүнг | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | Сургалтын үр дүнг тооцож байгаагүй. | Байгууллагын үйл ажиллагаа сайжирсан байна. | ОНТХО, УТХО<br>8 сая | Удирдах ажилтны зөвлөгөөнийг танхимаар 4 удаа, цахимаар 1 удаа зохион байгуулж 2022-2023 оны хичээлийн жилийн зорилго зорилтоо тодорхойлж БГҮ-нд дүн шинжилгээ | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| жил бүр зохион байгуулж, сургалтын үр дүнг ажлын гүйцэтгэл дээр тулгуурлан үнэлж дүгнэнэ. | ажлын гүйцэтгэлд тулгуурлан тооцно | | | | | хийх ойлголтоо нэгтгэн багшийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйд тулгуурлан сургалтын чанарыг сайжруулах төлөвлөгөө боловсруулагдлаа. 2021 оны элсэлтийн ерөнхий шалгалтаар улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн 7 сургууль, багш нарын хамтын ажиллагааг дэмжсэн шилдэг секц, ЗАН, мэргэжлийн бүлгийг нийт 9.5 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. Мөн БШУСайдын 803 дугаар тушаалын дагуу сургалтын байгууллагад ХШҮ хийж гүйцэтгэлийн хувиар хамгийн өндөр үнэлэгдсэн 3 сургууль, 5 цэцэрлэгийг 5.3 сая төгрөгөөр шагнаж урамшуулан тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлж байна. Биелэлт 50% | |
| Зорилт-5. Бүх насны суралцагч, иргэдэд зориулсан онлайн сургалтын сантай болж, цахим сургалт зохион байгуулж, иргэдийн 30 хувьд хүрч ажиллана. | Арга хэмжээ 1. Боловсролын салбарын цахим платформын хүрээнд ЕБС-ийн цахим хичээлийн санг нэмэгдүүлнэ. | Цахим хичээлийн сангийн тоо нэмэгдсэн байдал | Цахим шилжилтэд 2 сургууль хамрагдаж, 333 хичээлийн сан бий болсон. | 20-оос доошгүй хичээлээр нэмэгдсэн байна. | ОНТХО 1 тэрбум | 600 сая төгрөгийн санхүүжилтээр 25 сургууль, 7 цэцэрлэгт цахим багш хөгжлийн төвийг байгуулсан ба хөгжлийн төвөөр дамжуулан ЕБС-ийн багш нар хосолсон сургалтын арга зүйгээ google classroom платформтой хослуулан ашиглаж сургалтын үйл ажиллагааг удирдан явуулах боломж бүрдсэн. Сургалтын цахим платформд бүх сургууль хамрагдаж, гэрээгээ байгуулан санхүүжилтийн хуваарийн дагуу төлбөрөө төлөн үйл ажиллагаагаа эхэлсэн. Биелэлт 50% | 70 |
| | Арга хэмжээ 2. Цахим хичээлийг онлайнаар болон Фэйсбүүк, байгууллагын цахим хуудсаар дамжуулан явуулж, иргэдийн 30 хувьд хүрч ажиллана. | Хамрагдсан иргэдийн тоо | Нийт иргэдийн 24 хувьд сургалт зохион байгуулсан | Нийт иргэдийн 30 хувьд сургалт зохион байгуулсан. | | Насан туршийн боловсролын төв нь бүх насны суралцагч иргэдэд зориулсан цахим сургалтын сандаа 350 гаруй цахим сургалтын нөөцтэй болж үүний дагуу сургалтын сэдвүүдийн албан байгууллага, аж ахуй нэгжид түгээж цахим болон онлайн, танхим хосолсон захиалгат сургалтыг давхардсан тоогоор 502 сургалтыг 52178 иргэдэд зохион | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан. Мөн “Монгол бичиг –III” хөтөлбөрийн хүрээнд Монгол бичгийн сургалтыг 20 байгууллагын 482 төрийн албан хаагчдад танхимаар 74 төрийн албан хаагчдад онлайн хэлбэрээр зохион байгуулж байна.<br>Биелэлт 50% | |
| Зорилт-6. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн гарааны үнэлгээг жил бүр шинэчлэн тогтоож сургалтын чанарыг 5,5 хувиар ахиулж үр дүнг тооцно | Арга хэмжээ 1. Мэргэжлийн зэрэг ахиулах, мэргэшүүлэх, түргэвчилсэн, хөрвөх сургалтыг орон нутагт зохион байгуулж, мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлнэ. | Чанарын хувь нэмэгдсэн байдал | ЕБС сургалтын чанар 44,5 хувьтай, СӨБ-ын сургалтын чанар 80,7 хувьтай байна. | 5.4-аас дээш хувиар ахисан байна. | ОНТХО | 2022 оны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад эхний жилд – 117 багш, 5 жилд – 73 багш, 10 жилд – 63 багш нийт 253 багш хамрагдлаа. Мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувь өмнөх оноос 12.3%-иар ахисан. Багш нарын ажлын байранд нь цахимаар, орон нутагт танхимаар мэргэшүүлэх, түргэвчилсэн, хөрвөх сургалтыг 15 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1266 багшийг хамруулахаас гадна МУБИС-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд байгалийн ухааны дадлагажигч оюутан авах хүсэлт илгээх зэрэг ажлуудыг зохион байгуулсны үр дүнд СӨБ-ын үндсэн багш 100%, өмнөх оноос 1 хувиар, ЕБС-ийн багшийн хангалт 98.3% буюу өмнөх оноос 0.3 хувиар ахисан байна.<br>Биелэлт 50% | 100 |
| | Арга хэмжээ 2. Сургууль, цэцэрлэгийн багш нарын ажлын үр дүнг гүйцэтгэлд тулгуурлан тооцно. | | | | | Багш нарын онолын мэдлэг болон цахим орчинд ажиллах чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд математик, байгалийн ухааны багш нарын сургалтыг танхим цахимаар 5 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 382 багшийг хамруулсан мөн Мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажилласнаар байгалийн ухаан 9-р анги 36.7%, 12-р анги 43.8% нийт 40.3% буюу 10.7 хувиар; математик 9-р анги 38.95%, 12-р анги 33.32% нийт 36.1% буюу 4.3 хувиар өссөн байна.<br>Биелэлт 50% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ 3. Аймгийн бүх сургууль, цэцэрлэгүүдээс жил бүр гарааны үнэлгээ тогтоож, чанарын шалгалт авна. | | | | | Гүйцэтгэлд суурилсан чанарын үнэлгээг 25 сургуулийн 799 багшийн 19 судлагдахуунаар 12373 суралцагчийг хамруулан авахад сургалтын чанар 2021 онд 45,6%, 2022 онд 46.77 хувьтай шалгагдсан нь өмнөх оноос 1,17 хувиар ахисан байна. Сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгаанд үзүүлсэн дүнг үзэхэд СӨБ-ийн сургалтын чанар 2021 онд 82,5, 2022 онд 78,99 хувьтай өмнөх оноос 3,51 хувиар буурсан үзүүлэлтэй байна.<br>Биелэлт 50% | 100 |
| Зорилт-7. Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ. | Арга хэмжээ 1. "Сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлнэ. | Дэмжлэг үзүүлсэн оюутнуудын тоо | Суурь судалгаа гарсан. | Мэргэжлийн боловсон хүчний хангалт нэмэгдсэн байна. | ОНТХО, хандив 15 сая | Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж буй 11 оюутантай гэрээ байгуулан, сургалтын төлбөрт 30,333,352 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн Зөгийн үүр хөтөлбөрийн тавигдах шаардлагат мэргэжил нь нийцээгүй 9 оюутанд нийт 4,300,000 төгрөгийн сургалтын төлбөрт нь дэмжлэг үзүүлсэн. .<br>Биелэлт 50% | 70 |
| Зорилт-8. Шаардлагатай сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулж зориулалтын тоног төхөөрөмжөөр хангана. | Арга хэмжээ 1. Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгох ажлыг шат дараатай хийж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ. | Шинээр баригдсан барилгын тоо, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал | Хөрөнгө оруулалтын жагсаалт батлагдсан | Хүүхдийн сурч хөгжих орчин нөхцөл сайжирсан байна. | УТХО, ОНТХО | 2021 онд 4 сургууль /3 нь өмнөх оны дамжсан барилга/, 2 дотуур байр, 3 цэцэрлэг шинээр барьж, 4 сургууль, 1 цэцэрлэгт их засвар хийн, 8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн орчин сайжирсан. 2022 онд Баян-адарга, Батноров сумын бэрх тосгоны дотуур байр, Бэрх, Хэрлэн 1-р сургууль, Дархан, Баянмөнх сумын цэцэрлэгийн өргөтгөл нийт 6 барилга орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болсон. Суурь түвшнээс сургууль 8%, цэцэрлэг 5,8% нүхэн жорлон буурсан үзүүлэлтэй гарсан.<br>Биелэлт 40% | 70 |
| | Арга хэмжээ 2. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)- | Зарцуулсан хөрөнгө, | Хөгжлийн бэрхшээлтэй | | Олон улсын төсөл хөтөлбөр | Хан Хэнтий цогцолбор сургууль дээр тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулан 57 нэр төрлийн тоглоом, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэй хүүхэд ердийн сургуульд сурах, хөгжих орчинг бүрдүүлнэ. | авсан арга хэмжээ | хүүхэд сурах орчин бүрдээгүй. | | | 35 нэр төрлийн тусгай хэрэглэгдэхүүн, 16 нэр төрлийн тоног төхөөрөмж, 183 нэр төрлийн ном гарын авлага бүхий танхим байгуулж гэрчилгээжүүлсэн. Хэрлэн сумын 1-р сургууль Сонсгол, хэл яриа, Хан Хэнтий ЦСургууль хараа болон хавсарсан хэлбэр, Тэмүүжин цогцолбор сэтгэц, дауны хам шинж, Хэрлэн 4-р сургууль хөдөлгөөн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлээр төрөлжүүлэн сургалт зохион байгуулахад шаардагдах хүний нөөц болон сургалтын орчин бүрдүүлэхийг БСУГ-ын даргын 2021 оны А/24-р тушаалаар баталгаажуулсан. Тусгай хэрэгцээт суралцагчдад зориулан 6ш таблет, дохионы хэлний 1000 үгийн карт, гарын булчин хөгжүүлэх үзүүлэн 25 ширхэг, аутизмтэй хүүхдэд зориулсан цахим хэрэглэгдэхүүн 5аар баяжуулаад байна. Мөн Тэмүүжин ЦС-д ХБХ зориулсан АЦБ-ыг шинээр хийж гүйцэтгэлээ. Мөн дохионы хэлний багш бэлтгэх сургалтад 1 багшийг сургаж байна<br>Биелэлт 35% | |
| Зорилт-9. Хэрлэн сумын яслийн барилгыг 100 ороор өргөтгөж, шаардлагатай сумдын цэцэрлэгт яслийн бүлэг ажиллуулна. | Арга хэмжээ 1.<br>Хэрлэн сумын яслийн барилгыг өргөтгөнө. | 1-2 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалтын хувь | Яслид жил бүр 50 хүүхэд хамрагдаж байна | 1-2 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалт нэмэгдсэн байна. | УТХО, ОНТХО | Хэрлэн сумын шинэ барилгын бэлтгэл ажлын хүрээнд 120 хүүхдийн яслийн барилгын ажлын зургийг барилгын зураг төслийн “Ди Ти Би” ХХК боловсруулж, төсвийг “Юнирүүтс” ХХК хийсэн. Гадна холбоожуулалт, дулаан, цэвэр ус хангамж, бохир ус ариутгах татуурга, цахилгаан эрчим хүчээр хангах зэрэг техникийн нөхцөлүүдийн дүгнэлт, МХГ-ын дүгнэлт гарсан.<br>Биелэлт 15% | 30 |
| | Арга хэмжээ 2.<br>4-оос доошгүй сумдын цэцэрлэгт яслийн бүлэг ажиллуулна. | Яслийн бүлэг ажиллуулсан цэцэрлэгийн тоо, | 3 суманд яслийн бүлэг ажиллуулж 4 бүлэгт 77 | | | Цэнхэрмандал сумын цэцэрлэг 13, Баянмөнх сумын цэцэрлэг 15, Баян-Овоо сумын цэцэрлэг 5, Баянхутаг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүүхэд суралцаж байна. | | | сумын цэцэрлэгт 15, нийт 1 настай 48 хүүхдийг элсүүлэн сургаж байна. Биелэлт 50% | |
| Зорилт-10. “Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслийг Ерөнхий боловсролын 5 сургуульд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Арга хэмжээ 1. Төсөл хэрэгжиж байгаа 5 сургуульд орон нутгаас олгох санхүүжилтийг олгоно. | Дэмжлэг үзүүлсэн байдал, санхүүжилт | Төслийн шалгаруулалт хийгдсэн. | Тогтвортой хөгжлийн талаарх иргэдийн ойлголт нэмэгдэнэ. | Төслийн санхүүжилт, ОНТХ 37,5 сая | Хан Хэнтий ЦС: Ногоон Хан Хэнтий цогцолбор сургууль, Баян - Адарга: Цэвэр цэмцгэр бидний орчин, Тэмүүжин ЦС: Эрүүл хүнс -энх амьдрал, Галшар: Өв соёлын өргөө, Дадал: Ирээдүйн хөтөч сэдэвт төслүүд амжилттай хэрэгжиж байна. БОАЖЯ, БШУЯ, ШХА-ын "Тогтвортой хөгжлийн боловсрол-II" төслийн хүрээнд бэлтгэгдсэн сэтгэл зүйчдийн өрөөг тохижуулахад тус бүр 4 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг Дадал, Баян-Адарга, Хан Хэнтий, Тэмүүжин Цогцолбор сургуулиуд байрлуулаад байна. Төслийн хүрээнд аймгийн хэмжээнд 5 сургуульд сэтгэл зүйч ажиллахаас одоогоор 4 сургуульд сэтгэл зүйч ажиллуулж байна. Аймгийн хэмжээнд эко сургууль цэцэрлэг болох ажлын хүрээнд сургуулиуд сургуулийнхаа орчинд гоёлын мод 2718, жимсний мод 197 ширхгийг, нийтийн эзэмшлийн талбайд гоёлын мод 1178, жимсний мод 226 ширхгийг, Цэцэрлэгүүд цэцэрлэгийнхээ орчин гоёлын мод 925, жимсний мод 380 ширхгийг, нийтийн эзэмшлийн талбайд гоёлын мод 631, жимний мод 255 ширхэгийг суулгасан бөгөөд жимсний модны ургалт 85.6%, гоёлын мод 76.2% нь ургаад байна. Төслийн хүрээнд орон нутгаас санхүүжүүлэх 37.5 сая төгрөгийг бүрэн шийдвэрлэсэн. Төсөл хэрэгжиж буй Баян-Адарга, Хан Хэнтий, Тэмүүжин, Галшар, Дадал сургуулиудад 37.5 сая төгрөгийн төсөл хэрэгжсэн. Төсөл хэрэгжсэн сургуулиудын туршлагыг түгээн дэлгэрүүлж хэрэгжүүлснээр 2022 онд аймгийн хэмжээнд хүрэл | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрэгэ-4, мөнгөн гэрэгэ-11, ногоон туг -14 өөр нэмэгдээд байна.<br>Биелэлт 50% | |
| Зорилт-12. Суралцагчдын мэдээлэл технологийн чадварыг сайжруулах зорилгоор ЕБС-ийн 1 компьютерт ногдох хүүхдийн тоог бууруулж, сургуулиудын интернэт хурдыг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1. ЕБС-иудын суурин комьютерийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | Нэг компьютерт ногдох хүүхдийн тоо | 1 компьютерт ногдох хүүхдийн тоо 18 байна. | ЕБС-ийн нэг компьютерт ногдох хүүхдийн тоо буурсан байна. | ОНТХО, УТХО602 сая | 2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр Дархан сумын ЕБС-д 25 суурь компьютер нийлүүлсэн, Галшар суманд 26 сая төгрөгөөр цахим анги байгуулж 10ш таблет байрлуулсан. 2022 онд 25 сургуулиас 8 сургуулийг сургалтад хэрэглэх компьютероор хангасан. Нэг компьютерт ногдох хүүхдийн тоо 2021 онд 17, 2022 онд 16.8 болоод байна. Дархан, Баян-Овоо сумын Засаг дарга нар мэдээлэл технологийн иж бүрэн танхимыг байгуулсан. Мөн Цахим-Хэнтий төслийн хүрээнд Хэрлэн сумын 4 сургуулийн интернэтийн хурдыг 20mb нэмэгдүүлсэн. Ингэснээр тус сургуулиуд 40mb хурдаар интернэт хүлээн авч байна.<br>Биелэлт 40% | 90 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Хүн амын нийгмийн хамгааллын хөтөлбөрийг боловсруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгж байгууллагуудыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хэрхэн сахиж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулах | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Нийгмийн хамгааллыг оновчтой хүртээж, хүн амын хөгжлийг ханган хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг хүн ам зүйн чиглэлээр явуулах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэн хэрэгжилтийг хангах | | | | | | | |
| Зорилт-1. Иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын багц хуулийг даатгуулагчдад сурталчлах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | Сургалт сурталчилгаанд хамрагдах даатгуулагчдын хувь, сайн дурын даатгалд шинээр даатгуулагчдын тоо | 16277 иргэд даатгуулагчийг сургалтад, нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 4790 даатгуулагч, эрүүл мэндийн даатгалд 3195 малчин хамрагдсан | Сургалт сурталчилгаанд хамрагдах даатгуулагчийн тоог жилд 5 хувиар, сайн дурын даатгалд шинээр 1100-с доошгүй даатгуулагчийг хамруулна. | УТХО | Нийгмийн даатгалын ач холбогдол, хуулийн өөрчлөлт, хэрэгжилтийн талаар иргэд даатгуулагч, ажил олгогчдод 310 удаагийн сургалт зохион байгуулж 17202 иргэд, даатгуулагчдыг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 925 даатгуулагчаар нэмэгдсэн буюу 5,6 хувиар өссөн байна. Сайн дурын даатгалд шинээр 2021 онд 556, 2022 онд 625 малчин даатгуулагч тус тус хамрагдсан.<br>Биелэлт 70% | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ 2. Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг даатгуулагчдад сурталчлах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | ЭМДаатгалд даатгуулагчдын тоо | Эрүүл мэндийн даатгалд 3195 малчин хамрагдсан. | ЭМДаатгалд 200-с доошгүй даатгуулагчийг хамруулна. | УТХО | Сумын Засаг дарга нарын гэрээнд эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх заалтыг тусган, удирдах ажилтны зөвлөгөөнд танилцуулж, аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар 2021 онд 2538, 2022 онд 2895 малчныг шинээр эрүүл мэндийн даатгалд хамруулсан. Эрүүл мэндийн даатгалд хамруулах, насны бүлгийн үзлэгийн мэдээлэл сургалт сурталчилгааг 18 төрлийн мэдээлэл бүхий материалыг 21650 иргэнд тарааж, 41100 хүний хандалт авч, 18700 хүн хуваалцсан.<br>Биелэлт 100% | 100 |
| Зорилт-2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт болон байгууллага иргэдийн захиалгаар оюутнуудыг бэлтгэн төгсөгчдийн 50-аас доошгүй хувийг ажлын байраар хангана. | Арга хэмжээ 1. Эрэлттэй мэргэжлээр оюутнуудыг бэлтгэн төгсөгчдийн 50-аас доошгүй хувийг ажлын байраар хангана. | Ажлын байртай болсон төгсөгчдийн хувь | 68% | Политехник коллежид Эрэлттэй мэргэжлээр 2 анги шинээр нээж жил бүр төгсөгчдийн 50-аас доошгүй хувийг ажлын байраар хангана. | | 2020-2021 оны хичээлийн жилд Бор-Өндөр сумын МСҮТ-д "Уул уурхайн нөхөн сэргээгч мэргэжлийн 1 жилийн ангийг шинээр нээж 24 оюутан суралцаж төгссөн. Мөн ПТК дээр 2021-2022 оны хичээлийн жилд ойжуулагч, аяллын хөтөч, хүнсний ногооны фермер, аюулгүй ажиллагааны техникч мэргэжлийн ангийг шинээр нээн 94 суралцагч элсүүлээд нийт төгсөгчдийн 62.6 хувь, 2022 онд ойжуулагч, аяллын хөтөч, хүнсний ногооны фермер мэргэжлүүдээр оюутнуудыг бэлтгэж төгсөгчдийн 70.0%-ийг ажлын байраар хангасан.<br>Биелэлт 50% | 100 |
| Зорилт-3. Сумдын ХАБЭА-ын зөвлөлөөр дамжуулан хяналтыг сайжруулж үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ. | Арга хэмжээ 1. Сумдад ХАБЭА-ын зөвлөл, байгууллагуудад үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисстой болгож үйл ажиллагааг тогтмолжуулна | ХАБЭА-ийн зөвлөлтэй сумдын тоо, комисстой байгууллагын тоо | ХАБЭА-ын зөвлөлтэй 8 сум, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисстой 15 байгууллага байна. | ХАБЭА-н зөвлөл болон үйлдвэрийн ослыг судлан бүртгэх комиссыг 100 хувь байгуулсан байна. | ХЭДС 8.0 сая | 2021 онд 150 байгууллагыг үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисс байгуулсан. 2022 онд 18 сум, 3 тосгонд ХАБЭА-н зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжиж, шинээр 150 байгууллага үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисстой болж, хөдөлмөрийн чадвар алдалт, ажлын байран дахь осол гэмтлээс | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урьдчилан сэргийлэн ажиллаж байна.<br>Биелэлт 100% | |
| | Арга хэмжээ 2.<br>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогч болон ажилтнуудад зориулсан сургалт мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын тоо | - | Жилд 2 удаа сургалт зохион байгуулна. | ХЭДС 8.0 сая | 2021 онд 4 удаагийн сургалтаар 401 иргэнд, 2022 онд 11 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 2875 иргэнд сургалт мэдээллийг хүргэсэн. Нийт 15 удаагийн сургалтыг 3276 иргэдэд хийсэн<br>Биелэлт 50% | 100 |
| Зорилт-4. Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд шинэ ажлын байрыг 450-аар нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Улсын болон орон нутгийн төсвийн бүтээн байгуулалтын хүрээнд жил бүр 120-оос доошгүй шинэ ажлын байрыг нэмэгдүүлнэ. | Бүтээн байгуулалтын хүрээнд ажлын байртай болсон иргэдийн тоо | - | Бүтээн байгуулалтын хүрээнд жилд 120-аас доошгүй иргэнийг ажлын байраар хангана. | | 2021 онд улсын болон орон нутгийн төсвийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 286 ажлын байр бий болсон. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж байгаа 40 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, тухайн орон нутгийн нийт 305 иргэнийг улирлын болон түр ажлын байраар хангаж, нийт 591 ажлын байр бий болсон.<br>Биелэлт 50% | 100 |
| Зорилт-5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Бизнесээ эхэл" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Бизнесээ эхэл арга хэмжээний хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр сургалт, нөлөөллийн ажилд 400, төсөл хөтөлбөрт 2000 иргэнийг тус тус хамруулна. | - Сургалтад хамрагдсан иргэдийн тоо, төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо | Сүүлийн 4 жилийн хугацаанд 1749 хүнд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. | Жилд 100-аас доошгүй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад, 500 иргэнийг төсөл хөтөлбөрт хамруулна. | | 2021 онд "Бизнесээ эхэл арга хэмжээ"-ний хүрээнд аж ахуй эрхлэлтийн сургалтад 158 иргэн, хөдөлмөрт бэлтгэх сургалтад 86 ажилгүй иргэн, 40 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан ба уг арга хэмжээний хүрээнд 361 иргэнийг төсөл хөтөлбөрүүдэд хамруулан 447,7 сая төгрөгийн санхүүжилт олгож нийт 275 иргэнийг түр, 159 иргэнийг байнгын ажлын байраар хангасан.<br>"Бизнесээ эхэл" арга хэмжээний хүрээнд 2022 онд 1.3 тэрбум төгрөгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 1152 иргэнийг хамруулж, 212 байнгын ажлын байр, 940 түр ажлын байр бий болгосон. Мөн 2021 онд 284 иргэн, 2022 онд 330 иргэнийг нийт | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 614 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулсан. Биелэлт 50% | |
| | Арга хэмжээ 2. Малчдыг туслах малчинтай гэрээ байгуулан ажиллуулах | Гэрээлэн ажиллуулсан туслах малчдын хувь | 26 иргэнийг байнгын ажлын байртай болгосон. | Туслах малчнаар ажиллаж байгаа өрх, иргэдийн судалгааг гаргаж туслах малчдын 50-аас доошгүй хувийг гэрээжүүлнэ. | | 2021 онд 16 сум, 2 тосгоны 93 өрх иргэнтэй гэрээ байгуулан ажилласан. 2022 онд 7 сумын 131 туслах малчин өрхтэй хуулийн хүрээнд гэрээ хийсэн бөгөөд энэ нь судалгаанд хамрагдсан малчин өрхийн 82% байна. Нийт 224 иргэнтэй гэрээ байгуулан ажилласан Биелэлт 50% | 100 |
| Зорилт-6. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай гишүүдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангах "Халамжаас-Хөдөлмөрт" бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Арга хэмжээ 1. Халамжаас-Хөдөлмөрт арга хэмжээний хүрээнд зорилтод өрхийн 2400 иргэнийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадвар ахиулах сургалтад хамруулж хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 265 өрхийн 600 иргэнийг ажлын байраар хангана. | ХЭБ-ийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | - | 600-аас доошгүй иргэнийг сургалтад хамруулж, ХЭБ-ийн үйлчилгээнд хамрагддаг 150-аас доошгүй иргэнийг ажлын байраар хангана. | | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай гишүүдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангаж 2021 онд 605, 2022 онд 656, нийт 1261 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгөх, бүлгийн сургалт, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулж, 2021 онд 167, 2022 онд 279 нийт 446 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучлан ажилласан. Биелэлт 50% | 100 |
| Зорилт-7. Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн орчны хүртээмжийг сайжруулж, орчин бүрдүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад хүртээмжийн үнэлгээ хийн зөрчлийг арилгуулж хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байгууллагын тоог нэмэгдүүлнэ. | Хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн тоо | Аймгийн хэмжээнд 11 байгууллага орчны хүртээмжийн үнэлгээг хангасан. | 20-аас доошгүй төрийн болон ААНБ-уудад үнэлгээ хийж хүртээмжийг сайжруулна. | | 2021 онд 48 боловсролын байгууллагад хүртээмжийн үнэлгээ хийсэн. 2022 онд аймгийн хэмжээнд 23 сум, тосгоны эрүүл мэндийн төвд, Хэрлэн сумын 7 өрхийн Эрүүл мэндийн төв, нийт 28 байгууллагад орчны хүртээмжийн үнэлгээ хийж, нийт 76 байгууллагад хяналт тавьж, зөвлөмж хүргүүлж хүртээмжийг сайжруулахаар ажилласан. Биелэлт 50% | 90 |
| Зорилт-8. Ахмадын хөгжлийн төв болон ахмад настны чадамжийг дэмжиж 178 | Арга хэмжээ 1. 178 байгууллагад ахмадын сан байгуулж ахмадуудад зориулсан | Ахмадын сантай болсон байгууллагын тоо | Ахмадын сантай 6 байгууллага байна. | 178 байгууллага ахмадын сантай болсон байна. | | 2021 онд шинээр 47 байгууллага ахмадын сан байгуулан ажилласан. Аймгийн ТЕЗ-ийн хүрээний 178 байгууллага ахмадын сангийн данстай байх байснаас 2022 он | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| байгууллагад ахмадын сан байгуулна. | үйл ажиллагааг тогтмолжуулна. | | | | | гарснаар аймгийн хэмжээний ЕБС, Цэцэрлэг, Соёлын төв, ЭМТөвийн нийт 103 төсөвт байгууллага Улсын төсвийн байгууллага болж хасагдсанаар Орон нутгийн нийт 75 байгууллагаас 70 төсөвт байгууллага ахмадын сангийн данстай болж 93 хувьтай хэрэгжиж байна.<br>Биелэлт 90% | |
| Зорилт-9. Хүүхдэд ээлтэй орон нутгийн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжиж, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж Хүүхдэд ээлтэй орон нутаг болно. | Арга хэмжээ 1. Хүүхдэд ээлтэй байдлын индексийг жилд нэг нэгжээр ахиулна. | Хүүхдэд ээлтэй байдлын индекс | Хүүхдэд ээлтэй байдлын индекс 4 байна. /1-10/ | Хүүхдэд ээлтэй байдлын индекс жилд 1 нэгжээр ахисан байна. | 20 сая | Хүүхдэд ээлтэй байдлын индексийг "эрүүл мэнд, боловсрол, аюулгүй байдал хамгаалал, чөлөөт цагийн орчин, хүүхдийн оролцоо, амьдрах орчин" гэсэн 6 үндсэн үзүүлэлт бүхий 36 шалгуураар үнэлдэг. "Хүүхэд эрдэнэ хөгжлийн төв" нийгэмд үйлчлэх ТББ-аар тус индексийг үнэлүүлэхэд 2019 онд 4.9, 2020 онд 5.7, 2021 онд 6.3 гэсэн үзүүлэлттэй гарсан. 2022 оныг "Хүүхэд хөгжил, хамгааллын жил" болгон зарлаж хүүхдэд ээлтэй байдлын индекс 7.3 болж өссөн.<br>Биелэлт 50% | 90 |
| Зорилт-10. Жендэрийн чиглэлээр орон нутагт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод цогц үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | Арга хэмжээ 1. Жендэрийн тэгш байдлыг хангах салбар хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулна. | Урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдалтын хувь | 4 удаагийн нөлөөллийн ажилд 5262 гэр бүл, гэр бүлийн боловсрол олгох сургалтыг 14252 иргэнд хийсэн. | Урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа 36 удаа зохион байгуулж, нийт иргэдийн 35 хувийг сургалтад хамруулна. | 8.0 сая | 2021 онд Гэр бүлийн боловсрол олгох 17 удаагийн сургалт, 6 удаагийн подкастаар дамжуулан нийт 23.593 хүн хамруулсан. Мөн гэр бүлийн чиглэлээр 7 удаагийн нөлөөллийн ажил зохион байгуулж 4654 хүн 37 гэр бүл хамруулсан. Дээрх сургалт, нөлөөллийн ажлаар дамжуулан нийт хүн амын 33 хувь буюу 28.247 иргэн, 37 гэр бүлийг хамруулсан байна.<br>2022 онд Жендэрийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн аян 1, хэлэлцүүлэг 2, өдөрлөг 4, явуулын үйлчилгээ 1, нөлөөллийн 4 төрлийн 8 удаагийн үйл ажиллагаа, 2 төрлийн сургалтаар нийт 27,032 иргэн буюу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт иргэдийн 34.1%-ийг хамруулсан<br>Биелэлт 50% | |
| | Арга хэмжээ 2.<br>Хохирогчид үйлчилгээ үзүүлэх НЦҮТ-ийг стандартад нийцүүлэн 24 цагийн үйл ажиллагаатай болгож, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэнэ. | Шийдвэрлэсэн төсөв | - | Шаардлагатай байгаа 2 орон тоог шинээр нэмэгдүүлнэ. | 20.0 сая | 2021 онд нэг цэгийн үйлчилгээний төвд 2 орон тоог шинээр нэмж, шаардлагатай 15.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.<br>2022 онд нэг цэгийн үйлчилгээний төвийг 24 цагаар үйлчилгээ үзүүлэх боломжийг хангах хүрээнд нийгмийн ажилтан болон харуул хамгаалалтын ажилтны цалин болон эм, тариа, бусад зардалд шаардагдах 15,000,000 төгрөгийг шийдвэрлэсэн. Тус байранд 2 өрөөг нэмэгдүүлэн өргөтгөл хийж тохижуулсан. Хүний нөөцийн хувьд 2 нийгмийн ажилтан, 1 сэтгэл зүйч, 1 халамжийн ажилтан, 1 үйлчлэгч нийт 5 ажилтантай ажиллаж байна. НЦҮТөв, Түр хамгаалах байраар 11 сарын байдлаар нийт 69 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн ба үүний 59 буюу 85.5 хувь нь хүүхэд, 17 буюу 14.5 хувь нь насанд хүрэгч байна. Эдгээр үйлчлүүлэгчид нийт 8 төрлийн 308 үйлчилгээг 2-10 удаагийн давтамжтайгаар үзүүлж бодит эрсдэлийг бууруулж аюулгүй байдлыг хանган ажиллаж, 24 цагийн үйл ажиллагаатай болгож, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэхэд нийт 30,0 сая төгрөг зарцуулсан байна.<br>Биелэлт 50% | 100 |
| Зорилт-11.<br>Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаагаар дамжуулан жил тутам залуучуудын оролцоог 50 хувиар, үйл ажиллагаанд хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1<br>Залуучуудын оролцоотой сайн дурын үйл ажиллагааг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, сайн дурын үйл ажиллагаанд идэвх санаачилгатай | Сайн дурын ажилд бүртгүүлж, үйл ажиллагаанд оролцсон залуучуудын тоо | Сайн дурын залуучуудын бүртгэх, ажилд оролцуулах эхлэл тавигдаж байгаа бөгөөд Хэрлэн суманд 35 залуучуудыг сайн дурын | Залуучуудын оролцоотой сайн дурын үйл ажиллагааг 40 хувиар нэмэгдүүлж, сайн дурын залуучуудын тоо 155 болно. | 15.0 сая | 2021 онд сайн дурын ажлыг 8 хувиар нэмэгдүүлж, сайн дурын залуучуудын тоог 65 болгосон.<br>2022 онд олон нийт, иргэд, залуучуудад сайн үйлсийн үзэл санааг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор сайн үйлсийн аян зохион байгуулж 5 сум, 2 байгууллага, 6 ангийн 700 гаруй залуучууд нэгдэн оролцсон. Мөн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцсон залуучуудыг дэмжиж урамшуулах /донорууд г.м/ | | ажилтнаар бүртгээд байна | | | аймгийн залуучуудын хөгжлийн зөвлөл сайн дурын ажилд нэгдэн "Боловсон бол гоё" уриан дор хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор Эрдэмбаян 4-р сургуульд номын булан тохижуулсан гэх мэт 13 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулсан нь 2021 онтой харьцуулахад 62.5 хувиар өссөн байна. Идэвх санаачилга гарган оролцсон 3 залуу, 5 ангийг алдаршуулсан. Сайн дурын ажилтнаар 2022 онд 5 хүнийг бүртгүүлж, нийт 70 залуучууд YDC.mn -д бүртгүүлээд байна.<br>Биелэлт 50% | |
| | Арга хэмжээ 2.<br>Хэнтий аймгийн 18 сум 3 тосгоны Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн туршлага солилцох, цаашдын үйл ажиллагааг идэвхжүүлэх чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулах | Чуулга уулзалт зохион байгуулсан эсэх | - | Чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулна. | | 2021 онд цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор залуучуудын чуулга уулзалтыг цахимаар зохион байгуулсан бөгөөд 270 гаруй залуучууд оролцсон. 2022 онд Хэнтий аймгийн хэмжээнд нийт 25 залуучуудын хөгжлийн салбар зөвлөл үйл ажиллагаагаа явуулж, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн хурал, "Залуусын оролцоо зохистой хөдөлмөр эрхлэлт" чуулганы зохион байгуулсан. Чуулганд танхимаар 80, цахимаар 76 хүн оролцож залуучуудад тулгамдаж буй 6 дэд сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн ЗХЗ-ийн гишүүд аймгийн Засаг даргатай уулзалт зохион байгуулж хэлэлцүүлгээс гарсан саналыг уламжлан 2022-2023 онд 5 ажил дээр хамтран ажиллахаар хэлэлцсэн. Жил бүр зохион байгуулах чуулга уулзалтад нийтдээ 426 залуучуудыг хамруулсан.<br>Биелэлт 50% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-12. Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | Арга хэмжээ 1. ИНБ-уудын чадавхжуулах сургалт, уулзалт зохион байгуулж хамтран ажиллах | Хамтран ажилласан ТББ-ын тоо | - | 4-өөс доошгүй ИНБ-тай гэрээлэн ажиллана. | | 2021 онд 1 сургалт зохион байгуулж, 6 ТББ-тай гэрээ байгуулан ажилласан. 2022 онд Хууль эрх зүйн хэлтэс 2 ТББ, НБХ 1, ХБТХОХ 1 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-д болон залуучуудын сайн дурын клуб, ИНБ-уудын төлөөллийг 2 удаагийн сургалт, нөлөөллийн ажилд хамруулсан. Нийт давхардсан тоогоор 10 ТББ-тай гэрээ байгуулж, 3 сургалт зохион байгуулсан байна. Биелэлт 70% | 70 |
| | Арга хэмжээ 2. Улаан загалмайн байгууллагатай үндсэн 4 чиглэлээр хамтран ажиллана. | Сургалтын тоо | - | Сургалт зохион байгуулж, хамтран ажилласан байна. | | 2021 онд үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 3 арга хэмжээг хамтран зохион байгуулж 30 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, аймгийн улаан загалмайн байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж, Төр-Улаанзагалмайн хамтын ажиллагаа, Хүндэт донор алдаршуулах, Гамшгийн менежмент, Хүүхэд залуучуудын хөтөлбөр гэсэн 4 чиглэлийн дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлсэн. Биелэлт 50% | 100 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Соёл, биеийн тамир, спортын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай соёлын бүтээлийг дэмжин соёл, урлагийн байгууллагын өрсөлдөх чадвар, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх эрүүл идэвхтэй амьдрах дадал олгох нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, спортын салбарт амжилт гаргаж, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон баг, тамирчдыг дэмжинэ. | | | | | | | |
| Зорилт-1. Аймгийн музейн барилгыг ашиглалтад оруулж, үзмэрийг шинээр дэглэж, Сэцэн ханы ордон музейг хуучны загварт оруулж, сэргээн засварлана. | Арга хэмжээ 1. Аймгийн музейг ашиглалтад оруулж, үзмэрийг шинээр дэглэнэ. | Барилга ашиглалтад орсон эсэх, шинээр дэглэсэн үзмэрийн тоо | - | Барилга ашиглалтад орж үзмэрийг шинээр дэглэсэн байна. | | Аймгийн музейн шинэ барилга 2021 оны 12 сард 100% ашиглалтад орсон. 2022 онд музейн үзүүлэг дэглэлт, тоног төхөөрөмжид шаардагдах 3 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлж, улсын төсвийн хөрөнгөөр 4 багц тендер зарлагдсанаар холбогдох 3 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Үзмэрийн шилэн хоргыг нийлүүлэхээр шалгарсан "Синема оф саунд" ХХК-с BL-1 загварын 5 ширхэг шилэн хорго, тендерийн 2 болон 3 дугаар багцад шалгарсан "Голден Хоул" ХХК-аас холбогдох тавилга эд хогшил тоног төхөөрөмжийг нийлүүлэн үзүүлэг дэглэлтийн ажил хийгдэж эхэлсэн. Биелэлт: 100% | |
| Зорилт-2. Монгол үндэсний спортын уламжлалт соёлыг дээдэлж, орон нутагт зохион байгуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ. | Арга хэмжээ 1. Монгол үндэсний уламжлалт морь, бөх, сур, шагайн спортын арга хэмжээг жил бүр зохион байгуулж, хэвшинэ. | Жил бүр уламжлал болгон зохион байгуулсан эсэх | - | Монгол үндэсний спортын уламжлалт соёлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулсан байна. | | 2021 онд шинээр 2 суманд салбар холбоо байгуулагдсан. Үндэсний спортын чиглэлээр сургалт, арга хэмжээ, их хурал, уралдаан тэмцээн нийт 16 зохион байгуулж, 876 хүн хамрагдаж, 18 сум, 3 тосгонд 954 иргэн үндэсний спортын төрлөөр тогтмол хичээллэж байна. 2022 онд 13 суманд Монгол үндэсний уламжлалт соёл спортын 42 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж 13797 иргэд, хүүхэд, залуучууд хамрагдсан. Орон нутагт үндэсний сур, шагайн харвааны сургалт 8 удаа, үндэсний бөх, сур харваа, ширээний шагай, шагайн харваа зэрэг төрлүүдээр тэмцээн уралдаан 54 удаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор 2900 гаруй иргэд хамрагдсан ба 18 сум, 3 тосгонд 1012 иргэн үндэсний спортын төрлөөр тогтмол хичээллэж байна. Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-3. Хэнтий аймгийн онцлог, соёл иргэншил, үнэт зүйлийг танилцуулсан өв, соёл, урлагийн бүтээлийг дэмжин хөгжүүлнэ. | Арга хэмжээ 1. Аймгийн 100 жилийн ойн арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд “Чингис хаан дуулалт жүжиг” бүтээлийг туурвихад дэмжлэг үзүүлж, олны хүртээл болгоно. | Дэмжлэгт зарцуулсан мөнгөн дүн | - | “Чингис хаан дуулалт жүжиг” бүтээлийг туурвихад дэмжлэг үзүүлсэн байна. | | Чингис хаан дуулалт жүжгийн зохиолыг худалдан авч, судалгааны ажил хийгдэж байна. 2023 онд “Чингис хаан дуулалт жүжиг” бүтээлийг туурвихад 42 сая төгрөгийн санхүүжилтийг батлуулсан. Биелэлт: 70% | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ 2. Баян-Адарга суманд "Дуурлиг нарсны дурсгалт газрын мэдээллийн төв" байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | Мэдээллийн төв баригдсан эсэх | - | Мэдээллийн төв баригдсан байна. | | ШУА-ийн Археологийн хүрээлэн болон музейн албан хаагчдын бүрэлдэхүүн Баян-Адрага суманд ажиллаж “Дуурлиг нарсны дурсгалт газрын мэдээллийн төв”-ийг байгуулах 2га газрын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, гэрчилгээ аван зургийн даалгаврыг аймгийн ГХБХБГ-аар гүйцэтгүүлж байна.<br>Биелэлт: 50% | 50 |
| Зорилт-5. Хан Хэнтий нутгийн түүх, соёлын биет болон биет бус өвийг хадгалж, хамгаалах, өвлүүлэх цахим мэдээллийн сан бүрдүүлнэ. | Арга хэмжээ 1. Сумдын соёлын төвийг орчин үеийн зургийн аппаратаар хангаж, цахим сан бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Зургийн аппаратаар хангасан соёлын төвийн тоо | - | 6-аас дээш соёлын төвийг зургийн аппаратаар хангасан байна. | | 4 сумын соёлын төв орчин үеийн зургийн аппаратаар хангагдаж, соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах цахим сан бүрдүүлэх ажил амжилттай явагдаж байна.<br>Биелэлт: 70% | 70 |
| | Арга хэмжээ 2. Биет бус өвийг хадгалж, хамгаалах цахим мэдээллийн сан бүрдүүлнэ. | Цахимжуулсан биет бус өвийн хувь | - | Биет бус өвийн 80 хувийг цахимжуулсан байна. | | 2021 онд Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах цахим мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд энэ онд аймгийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй 704 өвлөн уламжлагчдаас 180 хүн /25,5%, 2022 онд СББӨ-ийн улсын бүртгэл мэдээллийн сан бүртгэлтэй 763 өвлөн уламжлагчаас 320 өвлөн уламжлагчийн фото болон видео мэдээллийг цуглуулан цахим мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаа. Цахим мэдээллийн сан бүрдүүлэх ажил 41.9%-ийн гүйцэтгэлтэй байна.<br>Биелэлт: 50% | 100 |
| Зорилт-6. Иргэдийг соён гэгээрүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэхэд бүх нийтийн оролцоог хангаж “Хэнтийн түүх-бидэнд чухал” арга | Арга хэмжээ 1: Угийн бичгийн хөтлөлтийг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, аймгийн Засаг даргын сумын Засаг дарга нартай байгуулах гэрээнд жил бүр тусган хэрэгжилтийг тооцон ажиллана. | Угийн бичиг хөтлөлтийн хувь | 40% | Угийн бичгийн хөтлөлтийг 60 хувьд хүргэнэ. | | Угийн бичгийн бодит судалгаа гаргаж 40 хувьтай байсан, 2012-2022 онд нийт угийн бичгийн зөвлөмж, сургалт, үзэсгэлэн зэрэг арга хэмжээг 127 удаа зохион байгуулж 3259 хүн хамруулсан. Аймгийн хэмжээнд 24215 өрх байгаагаас 10917 өрх угийн бичиг хөтөлж, аймгийн хэмжээнд хэрэгжилт 45.8%-тай байна.<br>Биелэлт: 70% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хэмжээг жил бүр зохион байгуулна. | Арга хэмжээ 2.<br>Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, Монгол бичиг, англи хэл, боловсрол, соёл, урлагийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн | Хөтөлбөрүүд 90-ээс дээш хувьтай хэрэгжсэн байна | | Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх хөтөлбөрийн хүрээнд ахлах ангийн суралцагчдын дунд олимпиад, хэлэлцүүлэг зохион байгуулж 251 хүүхдийг хамруулсан. Ахлах сургуулиудын дунд Дөл тэмцээнийг зохион байгуулж шалгарсан баг улсын уралдаанд амжилттай оролцсон. БЭЛГЭГҮЙ ҮГ ХЭЛЭЛЦДЭГГҮЙ БИЛГҮҮН МОНГОЛ УХААНААС СУРАЛЦЪЯ аныг санаачлан өрнүүлж цахим орчинд 21413 хүний хандалт аваад байна. Бичиг үсгийн баярыг Баян-Овоо суманд зохион байгуулж 6 үйл ажиллагааны хүрээнд 1950 хүнийг хамруулан шилдэг оролцогчдыг 8.8 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. Мөн “Монгол бичиг –III” хөтөлбөрийн хүрээнд Монгол бичгийн сургалтыг 20 байгууллагын 482 төрийн албан хаагчдад танхимаар 74 төрийн албан хаагчдад онлайн хэлбэрээр зохион байгуулсан.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 3.<br>Уламжлал болгон зохион байгуулдаг Санжаасүрэн, Б.Шарав, Гомбо, Дашням, Шархүүхэн багшийн нэрэмжит улсын уралдаануудыг үргэлжлүүлэн зохион байгуулж, шинээр Р.Чойномын нэрэмжит “Оюухай” яруу найргийн наадмыг 3 жил тутамд зохион байгуулна. | Уламжлал болгон зохион байгуулдаг улсын уралдаануудыг жил бүр зохион байгуулсан эсэх | Уламжлал болгон зохион байгуулдаг | Б.Шарав багшийн нэрэмжит "Сэрсэн тал"дуулаачдын улсын уралдаан, Шархүүхэн багшийн нэрэмжит зүүн Монгол дууны уралдаан зохион байгуулагдсан байна. | | Монгол Улсын Урлагийн Гавьяат Зүтгэлтэн хөгжмийн зохиолч Д.Гомбо агсны нэрэмжит мэргэжлийн хөгжимчдийн уралдаанд 10 аймгийн 11 баг оролцсон. Энэхүү цахим уралдааны тэргүүн байрт Говьсүмбэр аймаг, дэд байранд Завхан аймаг, гутгаар байранд Хэнтий аймгийн АДБ-ийн Хан Хэнтий чуулгын уран бүтээлчид шалгарч, шагналд 3,500,000 төгрөгийн зарцуулсан, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Чингис хаан одонт, Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Б.Шаравын нэрэмжит "СЭРСЭН ТАЛ-2022" дуу хөгжмийн наадам, Орчин үеийн дуу дуулаачдын улсын 2-р уралдаанд 70 уран бүтээлч оролцсон. МУУГЗ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Л.Дашнямын нэрэмжит дууны уралдааныг цахимаар зохион байгуулж, “Анир” студийн продюсер, хөгжмийн зохиолч, хөгжмийн найруулагч Бэгзсүрэнгийн Алтанхуягийн бүтээл шалгарч 5 сая төгрөгөөр шагнагдсан. Хэнтий аймгийн Р.Чойномын нэрэмжит нийтийн номын сан, Р.Чойномын - Өд сан, Хэрлэн тооно утга зохиолын нэгдэл, Дархан сумын ЗДТГ хамтран "Оюухай" яруу найргийн наадмыг амжилттай зохион байгуулж өгүүллэг уран уншлага шүлэг яруу найргийн төрлөөр 40-өөд яруу найрагчид хамрагдсан байна.<br>Биелэлт: 100% | |
| | Арга хэмжээ 4.<br>Олон улсын чанартай Алтаргана, Чингис фестиваль буюу ардын урлагийн наадмыг тогтмол зохион байгуулна | Ардын урлагийн наадмыг тогтмол зохион байгуулсан эсэх | Уламжлал болгон зохион байгуулдаг | Чингис фестиваль ардын урлагийн наадам, Алтаргана наадам зохион байгуулна. | | Алтаргана бага наадмыг аймгийн хэмжээнд удирдамжийн дагуу амжилттай зохион байгуулж 8 сумын 100 гаруй ардын авьяастнууд, спортын тамирчид хамрагдсан. Энэхүү уралдаанаас шалгарсан 61 авьяастан спортын тамирчдыг бэлтгэл хангуулан ОХУ-ын Агын тойрогт болсон "Их Алтаргана - 2022" наадамд амжилттай оролцож 2 тэргүүн байр, 1 тусгай байрын шагнал хүртсэн. Чингис фестивалийг 7 сард зохион байгуулж, 66 уран бүтээлч оролцсон.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 1.<br>Арга хэмжээ: Олимп цогцолборт их засвар хийн, орчин нөхцөлийг сайжруулна. | Их засвар хийсэн эсэх | - | Их засвар хийсэн байна. | | 2022 онд 115,0 сая төгрөгийн засварын ажил 100% хийгдсэн байна.<br>Биелэлт: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-7. "Олимп" цогцолборын орчин нөхцөлийг сайжруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | Арга хэмжээ 2. Бүх нийтийн болон нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх спорт цогцолбор байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | Дэмжлэг үзүүлсэн эсэх | - | Дэмжлэг үзүүлсэн байна. | | Улсын төсвийн 5.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянмөнх, Дадал суманд спорт цогцолбор, Биндэр, Дэлгэрхаан, Хэрлэн суманд сургуулийн спорт заал барьж байгаагаас Дадал сумын Спорт цогцолбор ашиглалтад орж, нийтийн биеийн тамираар хичээллэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 1600 хүнээр нэмэгдсэн байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-8. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спорт клубүүдийг магадлан итгэмжлэлд оруулж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих нөхцөлийг бүрдүүлэн спортоор хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1. Спортын клуб, аж ахуйн нэгж, байгууллагуудыг үе шат дараатайгаар магадлан итгэмжлэлд хамруулан, эрүүл мэндийн даатгалаар идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ авах иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | Магадлан итгэмжлэгдсэн болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авсан спортын клубын тоо, хамрагдсан хүний тоо | - | Магадлан итгэмжлэлд хамрагдах спортын клубын тоог нэмэгдүүлж, биеийн тамир,спортоор тогтмол хичээллэгч иргэдийн хүрээ нэмэгдсэн байна. | | 2020 оны “Эрүүл мэндийн даатгалын тухай” хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 9.12 дахь заалт хүчингүй болсноор Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгох нөхцөл цуцлагдсан ч "ХАДУН" фитнес клубыг БСШУС-ын сайд, ЭМСайдын хамтарсан 2019 оны А/178, А/144 тоот тушаалаар батлагдсан "Спортын клубыг магадлан итгэмжлэх журам"-ын дагуу нийтлэг шалгуур, үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуур, сургалт - дасгалжуулалтын чанарын шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаанд урьдчилсан үнэлгээ хийж шаардлага хангасан тул магадлан итгэмжлэлд оруулах тухай хүсэлтийн хамт ЗГТА-БТСУХороонд хүргүүлсэн ба холбогдох хэлтсээс эцсийн үнэлгээг хийх шинжээчийн багийг томилоод байна.<br>Биелэлт: 70% | 70 |
| Зорилт-9 Нийтийг хамарсан үндэсний болон нийтийн биеийн тамир, бүх нийтийн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг түшиглэн биеийн тамираар | Арга хэмжээ 1. Биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн спортын холбоо, клуб, иргэдийн оролцоотой төрийн болон төрийн бус байгууллагуудтай | Биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо | 23 холбоонд 3000 гаруй хүн хамрагдаж байна. | Биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдаж байгаа иргэд, хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна. | | Нийтийн биеийн тамир, арга хэмжээнүүд болон улсын хэмжээний 3 арга хэмжээ “Цахим гүйлт 2021”, “Дасгал хөдөлгөөн хийцгээе” сарын аян, “Цахим гимнастра”-г зохион байгуулж, биеийн тамирын арга хэмжээнд нийт 8200 иргэн хамрагдсан, 2022 онд биеийн тамираар хичээллэгчдийн тоо 10100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хичээллэгсдийг нэмэгдүүлнэ. | хамтран ажиллаж, нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ. | | | | | | байгаа нь 2021 оны мөн үеэс 1600-н хүнээр нэмэгдсэн байна.<br>Биелэлт: 100% | |
| | Арга хэмжээ 2. Үндэсний болон спортын их наадам зохион байгуулна. | Тэмцээнд оролцсон эсэх | - | Монголын Бүх ард түмний спортын их наадам, Хүүхдийн спортын их наадмын анхан шат, шигшээ тэмцээн амжилттай зохион байгуулж, оролцсон байна. | | | Үндэсний Спортын их наадмын анхан шатны ААШТэмцээн 8 төрлөөр явагдаж 260 тамирчин оролцсон. Үндэсний Спортын VII наадмын шигшээ тэмцээнд 74 тамирчин дасгалжуулагч оролцож 1 алт, 2 мөнгө, 6 хүрэл нийт 9 медаль хүртэж улсад 8-р байр эзэлсэн. Засгийн газрын тогтоолоор хугацаанд өөрчлөлт орж 2022 онд зохион байгуулагдсан Монгол Бүх Ард Түмний спортын XV наадамд 134 тамирчин, 18 дасгалжуулагч, 23 спортын төрөлд оролцож 23 алт, 18 мөнгө, 8 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр улсад 1-р байр эзэлж Анх удаа түрүүлсэн.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-10. Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг клубын системд шилжүүлнэ. | Арга хэмжээ 1. Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааны үр дүнг тооцож, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, байгууллагын хамтын ажиллагаанд уялдуулан санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөнө. | Үр дүнгээ хангалттай үнэлүүлсэн өсвөрийн шигшээ багийн тоо | - | Үйл ажиллагаа чанаржиж, санхүүжилтийг үр дүнд суурилан олгодог болсон байна. | | | 2021 оны Өсвөр үеийн шигшээ багийн тайланг зөвлөлийн хуралд хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын 2022 оны А/47 тоот захирамжаар шигшээ багийн үйл ажиллагааг чанартай явуулсан спортын 13 төрлөөр үргэлжлүүлэн ажиллуулж, дасгалжуулагчийн цалин 81135.0, уралдаан тэмцээн, томилолтын зардалд 15865.0, амжилт үзүүлсэн тамирчин, дасгалжуулагчдын урамшуулалд 3000.0 нийт 100 сая төгрөгийн үр дүнд суурилсан үйл ажиллагааны санхүүжилт хийгдсэн, 2022 онд спортын 13 төрөлд 367 тамирчин хичээллэж, Улс, Бүсийн 18 удаагийн уралдаан, тэмцээнд оролцож, нийт Алт-65, Мөнгө-69, Хүрэл-80 медалиудыг тус тус хүртсэн. Монгол улсын рекорд амжилтыг 1 удаа /буудлага/ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинэчилж тогтоосон ба Олон улсын хэмжээний мастер 1 /буудлага/, спортын мастер 2 /хөнгөн атлетик/, спортын дэд мастер 1 /хөнгөн атлетик/ тус тус шинээр төрсөн.<br>Биелэлт: 100% | |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Татварын хяналт тавих, орлого бүрдүүлэх | | | | | | | |
| Зорилт-1. Татварын тайлагналт, хураалт, бүртгэлийг цахим тайлангийн системд 100 хувь хамруулан, ил тод байдлыг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>"Цахим Татварын алба" болох зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд систем, программ хангамжийг шинэчилснээр Татварын албаны зүгээс иргэдэд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ цахимжсан байна. | Хувиар | 80% | Татварын албаны зүгээс иргэдэд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ цахимжсан байна. 100% | Шаардлагагүй | 1.Иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүх байцаагч нарыг 100 хувь хангасан.<br>2.ТА-ны зүгээс иргэдэд үзүүлэх бүртгэх, тайлагнах, татвар төлөх, лавлагаа тодорхойлолт гэсэн 4 төрлийн үйлчилгээ 100 хувь цахимжсан. E-mongolia системээс иргэд ТА-ны 48 төрлийн үйлчилгээ авах боломжтой болсон.<br>3.Гэрэгэ системс ХХК, сумдын ЗДТГ-тай хамтран бүх сумдын байцаагчдыг пос машинаар 100 хувь хангаж 19344 нэхэмжлэхээр 827,2 сая төгрөгийн татварыг хураан авч улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.<br>Биелэлт: 99.5% | 100 |
| Зорилт-2. Татварын орлогын төлөвлөлтийг сайжруулж, бодитой болгох. /85%/ | Арга хэмжээ 1.<br>Төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулах, төлөвлөлтийг аймаг орны эдийн засгийн байдал, инфляцын түвшинтэй уялдуулан төлөвлөсөн байна. | Хувиар | 73% | Татварын орлогын төлөвлөлтийг сайжруулна. 8% | Шаардлагагүй | Төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөний төслийг үндэслэлтэй, тодорхой тооцоо судалгаатай, мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж СЯ, ТЕГ-аар хянуулж батлуулсан. 2021 онд 16243,3 мянган төгрөгийг батлуулж байсан бол 2022 онд 27558,7 мянган төгрөгийг батлуулсан. Өмнөх оныхоос 11,3 сая төгрөгөөр илүү байгаа шалтгаан нь Төсвийн тухай хуулийн шинэчлэлтээр өмнө нь улсын төвлөрсөн төсөвт 100 хувь төвлөрч байсан Аж ахуйн нэгжийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орлогын албан татварын орлогын 40 хувь орон нутгийн төсөвт төвлөрдөг болсонтой холбоотой нэмэгдсэн болно.<br><br>Биелэлт:100% | |
| Зорилт-3. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл санхүүжилтийн цахим системийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагад нэвтрүүлнэ. | Арга хэмжээ 1.<br><br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээг цахим системд тухай бүр оруулан ажиллана | Хувиар | 100% | Төсөл арга хэмжээг цахим системд бүрэн оруулсан байна. 100% | Шаардлагагүй | Төсөл арга хэмжээг цахим системд бүрэн оруулж санхүүжилтийг олгон ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар 30 төсөл арга хэмжээний 58 удаагийн санхүүжилтээр 26,309.1 сая төгрөгийн мэдээллийг цахим системд 100 хувь бүрэн оруулсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ нь 2022 оны 5 дугаар сарын 01-ны өдрөөс цахим системд бүрэн шилжсэн тул мэдээллийг оруулж санхүүжилтийг олгож ажиллаж байна. Мөн 2022 оны 10-р сарын 11-нээс эхлэн санхүүжилтийн гүйлгээг цахимаар баталгаажуулан ААН байгууллага руу шилжүүлж байна.<br><br>Биелэлт: 100% | 100 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Төсвийн болон аж ахуй нэгж байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг эрсдэлийн удирдлагаар хангах | | | | | | | |
| Зорилт-1. Санхүүгийн хяналт шалгалтыг чанаржуулан Төрийн аудитаар илэрдэг зөрчлийг бууруулна. | Арга хэмжээ 1.<br><br>Шилэн дансны дотоод хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлснээр төсөвт байгууллага шилэн дансанд мэдээллээ бүрэн оруулсан байна. | Хувиар | 87,9% | Шилэн дансанд мэдээллээ бүрэн оруулсан байна. 98% | Шаардлагагүй | Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны "админ"-д улирлын тайлан илгээлт хянагддаг байдал 172 байгууллага байснаас 2 дугаар улирлаас хойш бүх шатны боловсролын байгууллага хасагдаж 117 байгууллага болсон. 2022 оны 4-р улирлын байдлаар нийт 19825 талбар мэдээлэл мэдээлэхээс 18078 талбар мэдээллийг хугацаандаа мэдээлж мэдээллийн иж бүрэн байдал 92%-тай хэрэгжиж байна.<br>2022 оны 4-р улирлын байдлаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улирлын тайлан илгээлт 100%, сарын мэдээлэл хугацаандаа 92% гээд дундаж 96%-тай хэрэгжиж байна.<br>Биелэлт 96% | |
| | Арга хэмжээ 2.<br>Эрсдэлд суурилсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг тогтмолжуулж мэргэжлийн зөвлөмж, зөвлөгөө өгч, эрсдэлийг бууруулж ажиллана. | Эрсдэлийн буурсан хувь | 17% | Эрсдэлийг 13%-д хүргэж бууруулах | Батлагдсан төсвийн хүрээнд | 2021 онд Төрийн аудитын хяналт шалгалтаар 28 байгууллага хязгаарлалттай дүгнэлт гарсан тул эдгээр байгууллагуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласны үр дүнд 25 байгууллага "Бага" эрсдэлтэй, 3 байгууллага "Дунд" эрсдэлтэй гарч эрсдэлийн түвшин 10.8%-д хүрч буурсан байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, тайлагнах. | | | | | | | |
| Зорилт-1. Орон нутгийн төсөвт бүх байгууллагууд дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан тохирлын баталгаатай барааны жагсаалтад заасан барааг худалдан авах шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж хэрэгжүүлэн ажиллана. | Арга хэмжээ 1.<br>Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан тохирлын баталгаатай барааны талаар болон хэрхэн тендерийн баримт бичигт оруулах талаар төсвийн байгууллагуудад сургалт зохион байгуулна. | Сургалт зохион байгуулсан эсэх | | Төрийн байгууллагуудад сургалт зохион байгуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хэнтий аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 2021 онд төрийн байгууллагуудад холбогдох сургалтыг зохион байгуулахаар тусгасны дагуу сургалтыг зохион байгуулсан. Тус арга хэмжээ нь 2021 онд нэг удаа сургалт зохион байгуулахаар төлөвлөгдсөн тул хэрэгжиж дууссан.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч сумдын төсвийн ерөнхийлөн | Хувиар | 100% | Биелэлтийг 100% дүгнэж ажиллана. | Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд | Сумдын Засаг дарга нарын 2022 оны гэрээнд холбогдох заалтуудыг тусгаж ажилсан. Мөн засгийн газрын 90-р тогтоолын дагуу чанар стандартын шаардлага хангасан 3,666,650,953 төгрөгийн дүн бүхий | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | захирагчийн хамтран ажиллах гэрээнд жил бүр худалдан авах дотоодод үйлдвэрлэсэн барааны нэр төрөл үнийн дүнг тусгаж биелэлтийг дүгнэж ажиллана. | | | | | бараа, бүтээгдэхүүнийг аймгийн хэмжээнд худалдан авсан байна. Биелэлт: 100% | |
| Зорилт-2. Худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулж аймгийн хэмжээнд цахим худалдан авах ажиллагааг 100 хувьд хүргэнэ. | Арга хэмжээ 1. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн сургалтыг төрийн албан хаагчдад зохион байгуулна. | Сургалт зохион байгуулсан эсэх | | Сургалт зохион байгуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтыг Тогтвортой амьжиргаа төсөлтэй хамтран 2022.04.23-наас эхлэн зохион байгуулж 60 төрийн албан хаагч, төрийн бус байгууллага, иргэний төлөөлөл хамрагдсанаас 41 нь буюу нийт сургалтад хамрагдсан хүмүүсийн 80% нь тэнцсэн. Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2. Сургалт зохион байгуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран худалдан авах ажиллагааны сургалтыг зохион байгуулж анхан шатны мэргэшсэн гэрчилгээ /А-3/ бүхий төрийн албан хаагч, иргэд олон нийтийн тоог нэмэгдүүлж үнэлгээний хороонд ажиллах боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлнэ | А-3 гэрчилгээтэй иргэдийн тоогоор | 237 | Анхан шатны мэргэшсэн гэрчилгээ /А-3/ бүхий төрийн албан хаагч, иргэд олон нийтийн тоог нэмэгдүүлнэ. /320/ | Батлагдсан төсвийн хүрээнд | Худалдан авах ажиллагааны сургалт зөвлөгөө өгөх төв ТББ-тай хамтран 2022.11.24-с 3 өдөр зохион байгуулж 70 хүн хамрагдсанаас 50 хувь нь тэнцсэн. Хэнтий аймагт А3 гэрчилгээтэй 332 албан хаагч, иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөл байна. Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 3. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч сумдын төсвийн ерөнхийлөн захирагчийн хамтран ажиллах гэрээнд цахим худалдан | Хувиар | 51% | 70% | Шаардлагагүй | 2022 оны жилийн эцсийн байдлаар Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд давхардсан тоогоор Хэнтий аймгийн ТЕЗ-н харьяа байгууллагуудын 437 төсөл арга хэмжээний урилга нийтлэгдэж 100 хувь цахимаар зарлагдсан. 100%. Биелэлт: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авалтын хүрэх түвшинг жил бүр тусгаж биелэлтийг дүгнэж ажиллана. | | | | | | |
| Зорилт-3. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой нийт байгууллагуудын өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэж, хяналт шалгалт зохион байгуулах. | Арга хэмжээ 1. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудын гэрээг жил бүр бүрэн дүгнэж, эд хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалтын байдлын талаарх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | Хяналт шалгалтын ажлыг зохин байгуулж гэрээ байгуулсан эсэх | | Орон нутгийн өмчит байгууллагуудын өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэж, дараа оны гэрээг байгуулсан байна. /100% | Батлагдсан төсвийн хүрээнд | 2022 оны жилийн эцсийн байдлаар 182 байгууллагын гэрээг дүгнэж, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой 182 байгууллагатай дараа оны гэрээг байгуулсан. Энэ онд улсын тооллоготой холбоотойгоор 5 удаа нэр бүхий сумдаар хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан. Хэрэгжилт 100%<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-4. Улс болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр бий болсон эд хөрөнгийн эзэмшигч байгууллагыг тодруулан тухайн байгууллагын данс бүртгэлд тусгуулах ажлыг зохион байгуулах | Арга хэмжээ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон эд хөрөнгийг харьяа яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын дагуу ашиглагч байгууллагын дансанд бүртгүүлэх, Орон нутгийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон эд хөрөнгийн ашиглагч байгууллагыг тогтоон данс бүртгэлд тусгах ажлыг тухай бүр зохион байгуулж ажиллах. | Хувиар | 95% | Төсөл арга хэмжээний хүрээнд шинээр бий болсон эд хөрөнгүүдийг эзэмшигч байгууллагын дансанд бүртгүүлсэн байна. /100%/ | Шаардлагагүй | ОНӨГ-ын 2022 оны 1 дүгээр сарын 17-ны 11 дугаартай албан тоотоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон 20 ажлын 6,534,915,877 төгрөг, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон 83 ажлын 1,473,481,251 төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон 263 ажлын 13,886,587,437 төгрөгийн үнэлгээтэй хөрөнгийн эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгах чиглэл өгч, хэрэгжилтийг тооцон хяналт тавин ажилласан. Хэрэгжилт 100%<br>Биелэлт: 100% | 100 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Сангуудыг нэгтгэн эргэн төлөлтийг сайжруулах. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Сум хөгжүүлэх сан, жижиг дунд бизнесийг дэмжих сангуудыг нэгтгэн хугацаа хэтрэлттэй авлагыг барагдуулах. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-1. Сум хөгжүүлэх болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангуудыг нэгтгэн, сангуудын эргэн төлөлтийг сайжруулж, авлагын 60 хувийг барагдуулан “Бусдад боломж олгох” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Сангуудын зээлийн эргэн төлөлтийг сайжруулж, 6.9 тэрбум төгрөгийн авлагын 60% буюу 4.1 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулж, зээл авах хүсэлтэй хувиараа бизнес эрхлэгч болон ААНэгжүүдэд олгоно. | Авлага барагдуулалтын хувиар | | Авлагыг барагдуулсан байна. 50% | Батлагдсан төсвийн хүрээнд | СХСангийн эргэн төлөлт 2673.8 сая, ЖДБДСангийн эргэн төлөлт 805.8 сая төгрөгийн зээл төлөгдөж нийт 3479.6 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдээд байна. Авлагыг 50.1 хувиар барагдуулсан. Энэ онд Хоршоо ХСангаас 2 сум 211.5 сая төгрөгийн зээл олгосон байна. Авлагыг 50 хувь барагдуулах зорилт тавьснаас 50.1 хувь барагдуулаад байна<br>Биелэлт: 100 % | 100 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлыг төсөвт тусгах. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах, цар тахлаас урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах | | | | | | | |
| Зорилт-1. Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор гамшгийн эрсдэлийн нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу “Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусган хэрэгжүүлэн ажиллана | Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулахад зориулан төсөвлөсөн хөрөнгийн хэмжээ | 247,5 сая төгрөг | Жилийн төсвийн 1%-ийг гамшгийн эрсдэлийн санд тусган ажиллана | Орон нутгийн төсөв | 2022 онд эрсдэлийн сангийн нөөц хөрөнгийг гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд 395,8 сая төгрөгийг зарцуулахаар тооцон төсөвт тусган батлуулсан. 4-р улирлын байдлаар 131.7 сая төгрөгийг зарцуулаад байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-2. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Цар тахлаас урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ авахад зориулан Засаг даргын нөөц хөрөнгийг нэмэгдүүлэн санхүүжүүлнэ. | Төсөвлөсөн хөрөнгийн хэмжээ | 410,0 сая төгрөг | Орон нутгийн нөөц хөрөнгийн санхүүжилтийг нэмэгдүүлэн ажиллана. | Зорилт-2. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийг нэмэгдүүлнэ. | 2022 онд Орон нутгийн нөөц сангийн хөрөнгийн зардлыг нэмэгдүүлэн 833,1 сая төгрөгөөр Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан ажилласан. Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлын 30-аас доошгүй хувь буюу 238.3 сая төгрөгийг санхүүжүүлэн ажиллаж байна. Оны эцсийн байдлаар 175.0 сая төгрөгийг зарцуулаад байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууц, олон нийтийн барилга түүнтэй холбогдох дэд бүтэц байгуулах, үйлчлэх хүрээг өргөтгөх бодлого боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, газрыг үр ашигтай, зохистой ашиглуулах, хяналт тавих, зөрчлийг арилгуулах, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулах | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-1. Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр батлуулан мөрдүүлж хүрээлэн буй орчинд ээлтэй суурьшлын болон үйлдвэрлэлийн бүсчлэлийг тогтоон хөгжүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж батлуулна. | Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг баталсан эсэх | Ерөнхий төлөвлөгөөний хугацаа дууссан | Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг баталсан байна. | ОНТ 342870 | Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан Вектор мэп ХХК-тай ХЭАЗДТГ/202111006, ЗҮ-2022/01 тоот гэрээг байгуулж ажлыг эхлүүлсэн, хээрийн судалгааны ажил хийгдэж, эхлэлийн тайлан баталгаажсан. Нийт ажлын гүйцэтгэл 50%<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах | Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан сумдын тоогоор | 10 сумын төлөвлөгөөтэй | 7 сум | ОНТ, ТХ | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Баян-Адарга, Баян-Овоо, Норовлин сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажил-г гүйцэтгэх ХЭАЗДТГ/202111006, ЗҮ-2022/01 тоот зөвлөх үйлчилгээний гэрээг Вектор мэп ХХК-тай байгуулж ажлыг эхлүүлсэн, хээрийн судалгааны ажил хийгдэж, эхлэлийн тайлан баталгаажсан. Нийт ажлын гүйцэтгэл 50%<br>Биелэлт: 100% | 90 |
| | Арга хэмжээ 3.<br>Хэрлэн, Бор-Өндөр, Дадал, Галшар, Батширээт, Норовлин, Биндэр, Өмнөдэлгэр сумдад иргэнд өмчлүүлэх боломжтой газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байрзүйн зураглал хийх, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулна. | Сумдын тоогоор | 13 сум, 1 тосгон | 8 сум | УТ, ОНТ | Монгол Улсын иргэнд өмчлүүлэх боломжтой газрыг сумын төвийн суурьшлын бүсэд оруулах, сумдын төсвийн тэг гортигийг шинэчлэх ажлын хүрээнд улсын Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан сумдын төвийн тэг гортигийн зураглалыг сумдад хүргүүлж саналыг авсан. Сумдаас ирүүлсэн саналыг нэгтгэн аймгийн хэмжээний 18 сумын төвийн тэг гортигийг шинэчлэх саналыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлэн ажилласан.<br>Биелэлт: 100% | 70 |
| | Арга хэмжээ 4.<br>Хаягжуулалтын мэдээллийн нэгдсэн системийг бий болгож | Сумдын тоогоор | 10 сум, 2 тосгонд хаягийн тэмдэг суурилуулах ажил хийгдсэн. | 8 сум, 2 тосгон | ОНТ | Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг стандартын дагуу хаягжуулах ажлын хүрээнд Батширээт сум орон нутгийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | улсын болон орон нутгийн чанартай авто зам, гудамж талбай, газар нутаг, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулах /Хэрлэн, Батширээт, Норовлин, Галшар, Мөрөн, Дархан, Жаргалтхаан, Баян-Адарга сум, Гурванбаян, Өлзийт тосгон/ | | | | | хөгжлийн санд 18.4 сая төгрөгийг тусгуулж "Нью хэйд лайн" ХХК-тай ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулан ажиллаж байна. Жаргалтхаан сум 20 сая, Мөрөн сум 10 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн санд тусгуулан хаягжуулалтын ажлыг хийх, хаягийн тэмдгийг газарт суурилуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулахаар ажиллаж байна.<br>Биелэлт: 100% | |
| | Арга хэмжээ 5.<br>Газар зүйн нэрийн тодруулгын ажлыг хийж газар зүйн нэрийн мэдээллийн санг байгуулах, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах | Газар зүйн нэрийн мэдээллийн санг байгуулсан эсэх | - | Газар зүйн нэрийн мэдээллийн санг байгуулсан байна. | ОНТ | Газар зүйн нэрийн тодруулга хийх, газар зүйн нэрийн мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд 2022 онд Дадал, Өмнөдэлгэр сумд орон нутгийн хөгжлийн санд тус бүр 19 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд эхний хагас жилтийн байдлаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулахаар ажиллаж байна.<br>Биелэлт: 100% | 30 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууц, олон нийтийн барилга түүнтэй холбогдох дэд бүтэц байгуулах, үйлчлэх хүрээг өргөтгөх бодлого боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, иргэдийг орон сууцаар хангах бодлого тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавина. | | | | | | | |
| Зорилт-1. Анх удаа орон сууц худалдан авч байгаа холбогдох шаардлагыг хангасан 300-аас доошгүй иргэдийг хөнгөлөлттэй зээлд хамруулна. | Арга хэмжээ 1.<br>Орон нутгийн арилжааны банкуудтай хамтран ажиллах талаар баримт бичгийг батална. | Хамтын ажиллагааны хүрээнд зээл олголтыг нэмэгдүүлсэн эсэх | - | Хамтын ажиллагааны хүрээнд зээл олголтыг нэмэгдүүлсэн байна. | | 2022 оны 05 дугаар сарын 1-ний байдлаар нийт 28 иргэнд зээл олгосон.<br>Биелэлт: 40% | 30 |
| | Арга хэмжээ 2.<br>Шаардлага хангасан иргэдийг зээлд хамруулна. | Иргэнд олгосон зээлийн тоогоор | - | 300-аас доошгүй иргэдийг хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна. | ОНХС, Бусад | 2022 оны 05 дугаар сарын 1-ний байдлаар нийт 28 иргэнд зээл олгосон.<br>Биелэлт: 100% | 30 |
| Зорилт-2. 120-оос доошгүй айлын түрээсийн орон сууцны барилгын ажлыг эхлүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>ТОСК-той хамтран ажиллах | Ашиглалтад орсон ТОС-ны тоогоор | 120 айлын түрээсийн орон сууцтай. | Барилга ашиглалтад орсон байна. | УТ, ОНТ | Шинэ Өндөрхаан хороололд 1 блок 60 айлын, 4 дүгээр багт Хэрлэн хорооллын урд талд 1 блок 30 айлын түрээсийн орон сууц барихаар газрын асуудлыг шийдвэрлээд байна. Барилгын ажлыг эхлүүлэхээр ТОСК-той | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран ажиллах санамж бичгийг баталгаажуулаад байна.<br>Биелэлт: 100% | |
| | Арга хэмжээ 2.<br>Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон сууц барих аж ахуйн нэгжүүдийг дэмжиж ажиллана. | Дэмжиж ажилласан эсэх | | Дэмжлэг үзүүлсэн байна. | ХХХО, ОНТ | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээд нийт 644 айлын орон сууцны барилга баригдахаар төлөвлөгдсөнөөс Хэнтий орон сууц ОНӨҮГ-ын захиалгаар барьж байгаа 60 айлын 3 блок орон сууцны барилга угсралтын ажил 35%-тай байна. 2022 онд шинээр Хэрлэн сум 3 дугаар багт Хаан тауер 9 давхар 32 айл, Батноров суманд иргэн Баатарцогтын 3 давхар 30 айл орон сууцны барилга угсралтын ажил эхлээд байна. Баригдахаар төлөвлөгдсөн Хэрлэн сумын 1 дүгээр багийн 16 давхар 4 блок 80 айлын орон сууц, дахин төлөвлөлтийн хүрээнд 174 айлын 5 давхар 4 блок баригдахаар зураг төсөл хийгдсэн байна.<br>Мөн Биндэр суманд 20 айлын 2 давхар, Цэнхэрмандал суманд 4 айлын 1 давхар, Дэлгэрхаан, Мөрөн суманд 18 айлын 3 давхар орон сууц тус тус баригдахаар төлөвлөгдөн ажлын зураг хийгдэж байна. Мөн Баян-овоо суманд 8 айлын орон сууцны барилга угсралтын ажил явагдаж байна. Норовлин суманд 24 айлын 3 давхар орон сууцыг “Их Монгол констракшн”, Баянхутаг суманд 30 айлын 5 давхар орон сууцыг “Содчавон” ХХКомпаниуд барихаар гэрээ байгуулаад байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-3: Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон сууцны барилга барих санал санаачилгыг дэмжинэ. | Арга хэмжээ 1.<br>Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж 500-аас доошгүй айлын орон сууц ашиглалтад оруулна. | Ашиглалтад орсон орон сууцны тоогоор | 2020 онд ХХХО-аар 12 айлын орон сууц ашиглалтад орсон. | 500 -аас доошгүй айлын орон сууцны барилгын ажил дуусч, ашиглалтад орно. | ХХХО | Хэнтий орон сууц ОНӨҮГ-ын захиалгаар барьж байгаа 60 айлын 3 блок орон сууцны барилга угсралтын ажил 35%-тай байна. Хэрлэн сум 3 дугаар багт Хаан тауер 9 давхар 32 айлын орон сууцны | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барилга угсралтын ажил 10%-тай үргэлжилж байна.<br>Биелэлт: 100% | |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууц, олон нийтийн барилга түүнтэй холбогдох дэд бүтэц байгуулах, үйлчлэх хүрээг өргөтгөх бодлого боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, Орон нутагт дахь эрчим хүч, цэвэр, бохир усны болон зам, замын байгууламж, тээвэр, харилцаа холбооны шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламж бүхий “инженерийн дэд бүтэц”-ийг өргөтгөх, шинэчлэн байгуулах, найдвартай, хүртээмжтэй байдлыг хангаж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | | | | | | | |
| Зорилт – 1: Чингис хотын ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэн өргөтгөх, шинээр худаг гаргах замаар баталгаат ундны усны тоог нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Эх үүсвэрийн худагт шаардлагатай засвар, шинэчлэл хийж, шинээр эх үүсвэрийн худаг гаргана. | Худаг гаргасан эсэх | - | Эх үүсвэрийн шинэ худаг гаргасан байна. | УТ, ОНТ | Цэвэр усны сангаас түгээж байгаа цэвэр усны өргөх станц дээр хлоржуулах төхөөрөмж шинээр суурилуулсан. Эх үүсвэрийн худгуудад программын шинэчлэл хийж усны алдагдлыг 25% хүртэл бууруулсан. Хэрлэн сумын 7, 2, 5, 4 дүгээр ус түгээх байруудыг ухаалаг төхөөрөмжид холбосон Мөн эх үүсвэрийн худгуудын камержуулалтыг шинэчилж нэмэгдүүлсэн.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Нөөц усны сан байгуулна. | Нөөц усны сантай болсон эсэх | - | - | УТ | 2023 оноос хэрэгжинэ. | - |
| Зорилт-2: Чингис хотын үерийн байгууламжийг ашиглалтад оруулж, хот доторх ус зайлуулах сувгийг бий болгоно. | Арга хэмжээ 1.<br>Үерийн байгууламжийг ашиглалтад оруулна. | Бүрэн ашиглалтад орсон эсэх | Үерийн далангийн ажил эхэлсэн. | Хэрлэн суманд үерийн байгууламжийн ажил дуусна. | УТ, ОНТ | Хэрлэн сумыг үерийн уснаас хамгаалах ажлын хүрээнд нийт 9669 м урт үерийн далан хотын төв зам дээр ус зайлуулах сувагчлал хийгдэхээс 2021 онд 1009 метр урт даланг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан бол 2022 онд нийт 3464 метр урттай үерийн хамгаалалтын далангийн ажлыг гүйцэтгэж, тус оны төлөвлөгөөт ажлыг бүрэн хэрэгжүүлсэн.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Хотын доторх гадаргуугийн ус зайлуулах систем байгуулна. | Бүрэн ашиглалтад орсон эсэх | - | Хотын доторх гадаргуугийн ус зайлуулах системийн барилгын ажил дуусна. | УТ, ОНТ | Хотын доторх гадаргуугийн ус зайлуулах системийн зураг төслийн ажил хийгдэж дууссан. Магадлалын шатанд байна.<br>Биелэлт: 90% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-3: Чингис хотын гэр хорооллын худгуудыг төвлөрсөн цэвэр усанд холбож, ухаалаг систем суурилуулна. | Арга хэмжээ 1. Чингис хотын гэр хорооллын худгуудад ухаалаг систем суурилуулж, төвлөрсөн цэвэр усны шугамд холбоно. | Ухаалаг систем суурилуулсан худгийн тоогоор | Чингис хотын гэр хорооллын 5 худагт ухаалаг систем суурилуулсан. | Жил бүр Чингис хотын гэр хорооллын 1 худагт ухаалаг систем суурилуулж төвлөрсөн цэвэр усны системд холбоно. | ОНТ 60.5 | 60.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баялаг Говь ХХК Хэрлэн сумын 2,3,4,5,6 дугаар багуудын 5 худгуудад ухаалаг систем суурилуулсан. Хэрлэн сумын 2 дугаар багт ухаалаг худаг, худгийн байр, төвлөрсөн шугамд холбох зураг төсөв бэлэн болсон.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-4: Сумдын ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлж, худгуудыг төвлөрсөн цэвэр усанд холбож, ухаалаг систем суурилуулна. | Арга хэмжээ 1. Сумдын гэр хорооллын худгуудыг төвлөрсөн усан хангамжид холбоно. | Төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон худгийн тоогоор | - | Төвлөрсөн усан хангамжийн системтэй сумдын худгийг холбох ажлыг үргэлжлүүлнэ. | ОНТ 50.0 | 2022 онд шинээр ундны усны худаг Батширээт 2, Баян-Овоо 1, Хэрлэн 1 нийт 3 худаг гаргаад байна. Мөн хэрлэн сумын 2 дугаар багийн гэр хорооллын худгийг төвлөрсөн шугамд холбох ажлын зураг төсвийг хийлгэж 2023 оны төсөвт суулгаад байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2. Сумдын гэр хорооллын худгуудад ухаалаг систем суурилуулна. | Ухаалаг систем суурилуулсан худгийн тоогоор | 3 сумын ус түгээх худаг ухаалаг системд холбогдсон. | 10-аас доошгүй ус түгээх худагт ухаалаг систем суурилуулна. | ОНТ 50.0 | Дэлгэрхаан сум 3, Батширээт 3, Баян-Адрага 1, Биндэр 2, Норовлин 3, Өмнөдэлгэр 2, Баян-Овоо 1 нийт 15 худаг ухаалаг системд холбогдоод байна.<br>Биелэлт: 80% | 100 |
| Зорилт-5: Шилэн кабелийн сүлжээг өргөтгөж, хурдыг сайжруулна. | Арга хэмжээ 1. Тахилгат тосгонд үүрэн телефоны хамрах хүрээг өргөтгөнө. | Шинээр интернэтэд холбогдсон өрхийн тоогоор | Өлзийт тосгоныг шилэн кабельд холбосон. | ХБУ тосгонд шилэн кабель татна. | УТ | "Бүх нийтийн үүргийн сан"-ийн хөрөнгө оруулалтаар 2021 онд G Mobile сүлжээнд хамрагдсан.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2. Хурх, ХБУ тосгонд шилэн кабель татна. | Шинээр интернэтэд холбогдсон өрхийн тоогоор | - | Хурх, ХБУ тосгонд шилэн кабель татсан байна. | УТ 80.0 | Гурванбаян, Хэрлэнбаянулаан тосгоныг өндөр хурдны шилэн кабельд холбох ажил хийгдэж дууссан.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 3. Чингис хотын гэр хороололд шилэн кабель татна. | Шинээр интернэтэд холбогдсон өрхийн тоогоор | - | Чингис хотын гэр хороололд шилэн кабель татсан байна. | УТ | Үүрэн холбооны Unitel Group Чингис хотын 60%-ийг шилэн кабельд холбосон.<br>Биелэлт: 100% | 90 |
| Зорилт-6: Дулааны станцыг ашиглалтад оруулна. | Арга хэмжээ 1. станцыг ашиглалтад оруулна. | Бүрэн ашиглалтад орсон эсэх | - | Дулааны станц ашиглалтад орсон байна. | УТ, ГХО | МУ-ын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулагдсан хөнгөлөлттэй зээлийн гэрээний хүрээнд 10 сая ам долларын хөрөнгө оруулалтаар | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дулааны станцын барилга угсралтын ажил хийгдэж байна. Биелэлт: 100% | |
| Зорилт-7: Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох нар, салхины сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ ашиглалтыг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1. Сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаа хийж, үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана. | Судалгааны ажлын явц, үр дүнгээр | - | Сэргээгдэх эрчим хүчний ТЭЗҮ төсөл хийгдэнэ. | УТ, ХХХО | Дадал сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга нь 10кВт нарны цахилгаан үүсгүүртэй ба НЦҮ-ийн систем нь 300Вт-ын 34ш панель, 10кВт-ын 1ш ухаалаг инвертер, 10ш батарейгаас бүрдэнэ. НЦҮ-ээсээ барилгын аваарын болон ослын гэрэлтүүлгүүд мөн галын станц, хяналтын камерууд тэжээгдэж байхаар хийгдсэн. Мөн илүүдэл эрчим хүчээ нэгдсэн ЦЭХ рүү өгч байхаар төлөвлөгдсөн байгаа. Биелэлт: 100% | 70 |
| Зорилт-8: Шаардлагатай багийн төвүүд болон шинээр олгогдсон өмчлөлийн газруудад 04 кв-н цахилгааны шугам тавина. | Арга хэмжээ 1. Шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангана. | ЦЭХ-ээр хангагдсан нэгж талбарын тоогоор | 6200 нэгж талбар ЦЭХ-ээр хангагдаагүй байна. | Шинэ суурьшлын бүсийг үе шаттай ЦЭХ-ээр хангана. | УТ | ОНХС-ийн 89.6 сая төгрөгийн санхүүжилтээр Жаргалтхаан сумын 2 км ЦДАШ байгуулсан бол, 181.6 сая төгрөгийн санхүүжилтээр Батноров сумын шинэ суурьшлын бүсэд 0.4-ийн агаарын шугам байгуулаах ажилд тендер зарлаж “АНАРЗОНЕ” ХХК шалгарч, тухайн оны хуваарьт ажлаа гүйцэтгэсэн. Үүнээс гадна Өмнөдэлгэр суманд 50 кВа, 30 кВа-гийн 2 дэд станцын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн 650 сая төгрөгийн санхүүжилтлээр Баянхутаг, Батширээт, Дадал, Норовлин, Өмнөдэлгэр, Хэрлэн сумдад шинэ суурьшлын бүсэд цахилгаан хангамж татах ажил хэрэгжиж байна. Баян-Овоо сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн ажил бүрэн дууссан. Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-9: Дулааны станцын гадна инженерийн хангамжийн ажлыг гүйцэтгүүлнэ. | Арга хэмжээ 1. Дулааны станцыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангагдана. | Ажлын гүйцэтгэлээр | - | Дулааны станцын гадна хангамжийн ажил дууссан байна. | УТ, ОНТ | Дулааны станцын УХАТ-ын зураг төслийн гүйцэтгэгчээр “Гидродизайн инноваци” ХХК гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 70%, Дулааны станцын гадна | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахилгаан хангамжийн зураг төслийг Мастерпойнт ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 70 хувьтай байна.<br>Биелэлт: 70% | |
| Зорилт-10: Чингис хотын 2-р хэлхээний шугам сүлжээг үе шаттай гүйцэтгэнэ. | Арга хэмжээ 2.<br>2-р хэлхээний засвар, шинэчлэлийн ажлыг үе шаттай гүйцэтгэнэ. | Ажлын гүйцэтгэлээр | 2-р хэлхээний 1300 м шугамыг шинэчилсэн. | 2-р хэлхээний засвар, шинэчлэлийн ажил дуусна. | УТ | Хэнтий-Ус ХХК-ний 3 болон 9-р зуух, Нямодо трейд ХХК-ийн уурын зуухны 2 хэлхээний шугам сүлжээ шинэчлэгдэж, зуухны тоноглол нэмэгдсэн.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-11: Чингис хотын 110/35/10-ын дамжуулах станцаас ЦТСС хүртэлх ЦДАШ-ыг газарт буулгах ажлыг хэрэгжүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Төслийн хэрэгжилтийг хангуулна. | Ажлын гүйцэтгэлээр | - | ЦДАШ-ын модон тулгуурыг төмөр бетон тулгуураар солих, ЦДАШ-ын дамжуулагчийг газрын кабелиар солих ажил хийгдсэн байна. | Дэлхийн банк | Дэлхийн банкны "Эрчим хүчний төсөл 2" төслийн хүрээнд Хэрлэн сумын 1, 4-р багт байрлах цахилгаан дамжуулах агаарын шугамын 500 модон тулгуурыг төмөр бетон тулгуураар сольсон. ЦДАШ-ын дамжуулагчийг газрын кабелиар солих ажил хийгдэж байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-12: Хэрлэн гол болон бусад голуудад шаардлагатай гүүрийг шинээр барьж, сэргээн засварлана. | Арга хэмжээ 1.<br>Ашиглалтын шаардлага хангахгүй гүүрийг үе шаттай засварлана. | Засварласан гүүрийн тоогоор | Модон гүүр 6 ш, төмөрбетон гүүр 1 ш засварласан. | Ашиглалтын шаардлага хангахгүй гүүрийг үе шаттай засварласан байна. | УТ, ОНТ | Батширээт сумын Баян гол, Эгийн голын модон гүүрийг засварлаж, Амгалантын голд шинээр модон гүүр барьсан.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Хэрлэн гол болон бусад голуудад шинээр гүүр барина. | Шинээр баригдсан гүүрийн тоогоор | Баян-Адарга сумын Онон голын төмөрбетон гүүр ашиглалтад орсон. Биндэр сумын төмөрбетон гүүрийн ажил үргэлжилж байна. | Батширээт, Хэрлэн голд шинээр баригдах гүүрийн ажил дуусна. | УТ | Улсын төсвийн 6.3 тэрбум төгрөгийн санхүүжилтаар "Тэргүүн саруул зам"ХХК Батширээт сумын Онон голын 209 метр төмөр бетон гүүрийний барилгын ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад хүлээлгэж өгсөн. Бархын голын төмөрбетон гүүр, 121.3 у/м, хайрган зам, 1.2 км төсөл арга хэмжээний барилгын ажил эхлээд явж байна. Хэнтий аймгийн Чингис хотыг тойрон гарах авто зам, шинээр барих гүүрийн зураг төсөл /Хэнтий/ төсөл арга хэмжээний зураг төслийн ажлын тендерийг Барилга Хот Байгууллатын Яаманд зарлаж "ХЗТ автозам"ХХК шалгарч зураг төслийн ажлыг гүйцэтгэж бүрэн дуусгасан.<br>Биелэлт: 100% | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-13: Хот хооронд болон орон нутагт агаарын, авто тээвэр, шуудан үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1. Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ өргөжүүлнэ. | Нийтийн тээврийн үйлчилгээ тогтмолжсон сумын тоогоор | Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ тогтворжсон. | Бүх сумдад нийтийн тээврийн үйлчилгээ тогтмолжсон байна. | - | Улаанбаатар-Өмнөдэлгэр, Улаанбаатар-Дадал чиглэлд хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ явуулах зөвшөөрлийн материал АТҮТөвд хянагдаж байна. Хот хоорондын болон орон нутгийн нийтийн тээвэр, шуудан үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд нийтийн тээвэр болон такси үйлчилгээнд цагийн зохицуулалт хийж зохион байгуулж эхлээд байна. Орон нутгийн зорчигч тээвэрлэлтийг Шуудан үйлчилгээний газартай хамтран зохион байгуулах талаар судалж байна.<br>Биелэлт: 100% | 30 |
| | Арга хэмжээ 2. Орон нутгийн нийтийн тээврийн үйлчилгээг хүрээг өргөтгөнө. | Шинээр бий болсон зорчигч тээврийн үйлчилгээгээр | - | Орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээг өргөжүүлсэн байна. | ОНТ | Улаанбаатар-Батноров-Улаанбаатар чиглэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг 2022 оны 5 сараас эхлүүлэн 7 хоногт нэг удаа зохион байгуулж байна. Улаанбаатар-Бор-Өндөр-Улаанбаатар чиглэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг явуулах аж ахуйн нэгжийг судалж байна.<br>Биелэлт: 100% | 90 |
| Зорилт-14: Чингис хотод цэцэрлэгийн барилга-өргөтгөл 2, сургуулийн барилга-өргөтгөл 1, дотуур байрны барилга 2, эрүүл мэндийн төвийн барилга-өргөтгөл 1, спорт заал, талбай 2, соёлын төвийн барилга 1, залуучуудын сургалт, хөгжлийн төв 1, иргэдэд үйлчлэх төрийн байгууллагын барилга 4-ийг тус тус барьж байгуулна. | Арга хэмжээ 1. Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу сургууль, цэцэрлэг, дотуур байрыг шинээр барьж, өргөтгөл хийж, их засвар хийнэ. | Хийгдсэн ажлын тоо, гүйцэтгэлээр | Хөрөнгө оруулалтын жагсаалт батлагдсан. | Төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд бүрэн хийгдсэн байна. | УТ | Хэрлэн 3 дугаар цэцэрлэгийн 200 хүүхдийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 87%-тай Тэмүүжин цогцолбор сургуулийн Дотуур байрны барилга угсралтын ажил 65%-ийн гүйцэтгэлтэй. Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгын ажил 15%-тай, 5-р цэцэрлэгийн барилга 65%-тай үргэлжилж байна. 1500 суудалтай 1-р сургуулийн барилга угсралтын ажил 100 дууссан.<br>Биелэлт: 100% | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-15: Сургуулийн барилга-өргөтгөл 6, дотуур байрны барилга 5, соёлын төвийн барилга 5, спорт заал, талбай 6, эрүүл мэндийн төвийн барилга-өргөтгөл 6, залуучуудын сургалт, хөгжлийн төв 2, ахмадын байр 1, иргэдэд үйлчлэх төв 10-ийг тус тус барьж байгуулна. | Арга хэмжээ 1. Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу сургууль, цэцэрлэг, дотуур байрыг шинээр барьж, өргөтгөл хийж, их засвар хийнэ | Хийгдсэн ажлын тоо, гүйцэтгэлээр | Хөрөнгө оруулалтын жагсаалт батлагдсан. | Төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд бүрэн хийгдсэн байна. | УТ | Батлагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилтийн бүтэн жилийн хэрэгжилт хангагдсан<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-16: Сумын төвийн гэр хорооллын инженерийн, ариутгал татуургын шугам сүлжээ болон цэвэрлэх байгууламж, сум доторх зам, төмөр бетон модон гүүрийг шинэчлэх, засварлах ажлыг гүйцэтгэнэ. | Арга хэмжээ 1. Сумын төвийн гэр хорооллын инженерийн болон ариутгах татуургын шугам сүлжээг байгуулна. | ИШСүлжээнд холбогдсон сумын тоогоор | 7 сум ус хангамжийн системд холбогдсон. | Сумын төвийн гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажил үргэлжилнэ. | УТ 1500.0 | Баянмөнх сумын гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил бүрэн хэрэгжиж дууссан. Мөн 9 Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч шалгарч тухай оны төлөвлөгөөт ажлыг хийж дуусгаад байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2. Шаардлагатай сумдын цэвэрлэх байгууламжийг засварлана. | Ажлын гүйцэтгэл, тоогоор | - | Бор-Өндөр сум, Бэрх тосгоны цэвэрлэх байгууламжийг шинэчлэн засварласан байна. | УТ 200.0 | Бор-Өндөр сум, Бэрх тосгоны ариутгах татуургын шугам сүлжээ цэвэрлэх байгууламжийг шинэчилж засварлах ажил хийгдсэн.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 3. Сумын төвийн замыг сайжруулна. | Ажлын гүйцэтгэл, тоогоор | Өмнөдэлгэр, Биндэр сумдын төвийн замыг сайжруулсан. | Аялал жуулчлалын маршрутын дагуух сумын төвийн замыг сайжруулах ажил үргэлжилнэ. | УТ | Чингис хотын замын нөхөөс, явган хүний гэрлэн дохио, Баян-Адарга сумын төв, баруун даваа, шинэсийн авто замыг тэгшилж нягтруулах ажил бүрэн хэрэгжиж дууссан. 4-н зам-Хишигийн уулзвар-Хэрлэн зоогийн уулзвар хүртэлх замын шинэчлэлтийн ажил үргэлжилж байна. Хэрлэн сумын 4-р цэцэрлэгийн гаднах зам талбай, төв замаас орох хэсгийн замын зургийг дахин хийлгэж байна.<br>Биелэлт: 90% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ 4. Аялал жуулчлалын маршрутын дагуух сумдыг хатуу хучилттай авто замаар холбоно. | Ажлын гүйцэтгэлээр | Шинээр | авто замын ажил үргэлжилнэ | УТ | Чингис хот - Бэрх тосгон хүртэлх 70 км, Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын ажил дуусаж ашиглалтад оруулсан. Бэрх-Норовлин чиглэлийн 130 км, Жаргалтхаан-Өмнөдэлгэр чигэлэлийн 52.5 км тус тус хатуу хучилттай авто замын ажлууд хийгдэж дунджаар 35%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Үүнээс гадна Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн 68.3 км хатуу хучилттай авто замын энэ жилийн төлөвлөгөөт ажил хэрэгжээд байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-17. Аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрут бүхий сумдад нисэх буудал зориулалттай газрын нөөцийг тогтоож, Чингис хот-Дадал сум-Чингис хот, Чингис хот-Улаанбаатар хот-Чингис хот чиглэлд тогтмол нислэгтэй болгоно. | Арга хэмжээ 1. Биндэр, Бор-Өндөр, Батширээт, Норовлин сумдад агаарын хөлгийн хөөрч буух зурвас, аэродромын газрын байршлыг тогтоон орон нутгийн тусгай хэрэгцээнд авна. | Ажлын гүйцэтгэлээр | Хэрлэн, Дадал сумын агаарын хөлгийн хөөрч буух зурвас, аэродромын газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. | Биндэр, Бор-Өндөр, Батширээт, Норовлин сумдад агаарын хөлөг хөөрч буух зурвасын газрыг орон нутгийн хэрэгцээнд авсан. | - | Биндэр, Галшар сумдад хөлгийн хөөрч буух зурвас, аэродромын газрын байршлыг тогтоож хамгаалалтад авсан. Бор-Өндөр, Биндэр, Норовлин сумдад агаарын хөлгийн хөөрч буух зурвас, аэродромын газрын байршлыг тогтоон орон нутгийн тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулж байна. Батширээт суманд ажилласан боловч талбай сонгох газрын байршил тохиромжгүй /боломжгүй/ байна. | 90 |
| | Арга хэмжээ 2. Өндөрхаан, Дэлүүн Болдог нисэх буудлын барилгыг ашиглалтад оруулна. | Ажлын гүйцэтгэлээр | Өндөрхаан, Дэлүүн болдог нисэх буудлын ажил эхэлсэн. | Өндөрхаан, Дэлүүн Болдог нисэх буудал ашиглалтад орсон байна. | УТ, ГХО | Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Өндөрхаан нисэх онгоцны буудлын Аэродромын 98%, Зорчигч үйлчилгээний барилга байгууламж 35%-ийн гүйцэтгэлтэй байна<br>Биелэлт: 50% | 70 |
| | Арга хэмжээ 3. Ерөнхий зориулалтын нислэг үйлдэнэ. | Ажлын гүйцэтгэлээр | - | Өндөрхаан, Дадал, Биндэр, Бор-Өндөр, Батширээт, Норовлин сумдад ерөнхий нислэг үйлдэж эхэлсэн байна. | ХХХО | Ерөнхий зориулалтын нислэг эхлэх талаар 2 компаний саналыг хүлээн авч судалсан ба 1 компанийг сонгож УБ-Чингис хот чиглэлийн Ерөнхий зориулалтын нислэг эхлэх талаар тохироод байна.<br>Биелэлт: 50% | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-18: Хэрлэн суманд хэрэгжиж байгаа гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг дуусгана. | Арга хэмжээ 1. Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | Шинээр ашиглалтад орсон орон сууцны тоогоор | Дэд бүтцийн ажил бүрэн хийгдсэн. | Дахин төлөвлөлтийн ажил дуусч шинээр орон сууц ашиглалтад орсон байна. | ХХХО 2000.0 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 90 айлын орон сууцны БУА эхлэх бэлтгэл ажил хангагдаж байна.<br>Биелэлт: 100% | 90 |
| Зорилт-19: Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зочид буудал, худалдааны төв, малын гаралтай түүхий эд болон боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж, төвийн болон гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, хотын доторх хатуу хучилттай авто зам, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажлыг гүйцэтгэнэ. | Арга хэмжээ 1. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зочид буудал, худалдааны төв байгуулах ажлыг дэмжиж газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгана. | Ажлын гүйцэтгэлээр | - | Зочид буудал, худалдааны төв шинээр баригдсан байна. | ХХХО | I-IV Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний санал авах ажлыг нээлттэй, хүртээмжтэй зохион байгуулан, хувийн хэвшлийн үйлчилгээний зориулалтаар газар эзэмших саналыг хүлээн авч 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган ажиллах чиглэлийг сумдын Засаг дарга, тосгоны Захирагч нарт хүргүүлсэн. Дадал суманд Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 19.89 га газрыг аялал жуулчлалын зориулалтаар төсөл сонгон шалгаруулах журмын дагуу эзэмшүүлж "Исун мод тур" ХХК барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. 2022 оны сумдын ГЗБайгуулалтын төлөвлөгөөнд үйлдвэр үйлчилгээний зориулалтаар 40 нэгж талбар төлөвлөснөөс 18 нэгж талбар, 1.3 га газрыг эзэмшүүлээд байна.<br>Биелэлт: 100% | 70 |
| | Арга хэмжээ 2. Малын гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрийг байгуулна. | Ажлын гүйцэтгэлээр | - | Анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр ашиглалтад орно. | УТ, ХХО | Баян-Овоо суманд "Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төсөл" нэмэлт санхүүжилтээс 2022 онд мах төхөөрөх бага оврын үйлдвэр барихад 750.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Одоогоор ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдаад байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 3. Чингис хотын гэр хорооллын | Ажлын гүйцэтгэлээр | Чингис хотын гэр хорооллын инженерийн шугам | Чингис хотын гэр хорооллын инженерийн шугам | УТ 29500.0 | Чингис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэл, өргөх станцын ажил удаашралтай, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | инженерийн шугам сүлжээг байгуулна. | | сүлжээний зураг төсөл боловсруулсан. | сүлжээний ажил дуусна. | | гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлж дулаан хангамжийн ажил 20%-тай бохир усны шугам сүлжээний ажил 80%-тай үргэлжилж байна.<br>Биелэлт: 100% | |
| | Арга хэмжээ 4.<br>Саарал усны технологийг нэвтрүүлж, хэрэглээнд оруулна. | Ажлын гүйцэтгэлээр | | Саарал усны хэрэглээ нэмэгдсэн байна. | УТ 100.0 | Цэнхэрмандал, Баян-Адарга, Норовлин, Галшар суманд 95% хүртэл цэвэршүүлэх хүчин чадалтай Microfast технологийн цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлын гэрээ байгуулагдан ажил эхлээд байна.<br>Биелэлт: 90% | 70 |
| | Арга хэмжээ 5.<br>Чингис хотод цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулна. | Ажлын гүйцэтгэлээр | Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил эхэлсэн. | Цэвэрлэх байгууламж ашиглалтад орно. | УТ | 95% хүртэл цэвэршүүлэх, 3000 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 6.<br>Хотын доторх хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлнэ. | Ажлын гүйцэтгэлээр | 6.8 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсон. | Хотын доторх хатуу хучилттай авто замын ажил дуусна. | ОНТ 420.0 | 4 замын уулзвараас Хэрлэн голын гүүр хүртэлх авто замын шинэчлэлт, Аймгийн төвийн автозамын засвар, шинэчлэлт, 3-р багийн автозам, явган замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлууд бүрэн хийгдэж дууссан.<br>Биелэлт: 100% | 100 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууц, олон нийтийн барилга түүнтэй холбогдох дэд бүтэц байгуулах, үйлчлэх хүрээг өргөтгөх бодлого боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Орон нутгийн хөгжлийн санг хуульд заасан эх үүсвэрээс бүрдүүлж, хуулиар хориглосон зүйлд зарцуулахгүй байхад хяналт тавьж, үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангах. | | | | | | | |
| Зорилт-1. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, сангийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулахад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулан сангийн үйл ажиллагааны үр дүнг жил бүр үнэлж дүгнэнэ. | ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэсэн эсэх | ОНХС-ийн тайлагналт хангалтгүй | ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэсэн байна. | - | ОНХС-ийн 2021 оны тайланг 6 сум ирүүлсэн. Бусад сумдыг тайланг яаралтай ирүүлэх чиглэлийг аймгийн Засаг даргын 9/1418 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Биелэлт: 40% | 30 |
| | Арга хэмжээ 2.<br>ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, | 2019 онд иргэдийн оролцоо нэмэгдсэн эсэх | 2019 онд иргэдийн оролцоо 75 хувь | Иргэдийн оролцоо 90 хувьд хүрсэн байна. | - | Иргэдийн оролцоот Хэтийн Хэнтий төслийн хүрээнд 2022 онд иргэдийн оролцооны хувь 92 хувьд хүрсэн байна.<br>Биелэлт: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ил тод байдлыг сайжруулна. | | | | | | |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход хууль тогтоомжид заасны дагуу санал өгөх, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах; | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Ашигт малтмалын болон ТТАМ-ын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;<br>Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар гэрээ байгуулж ажиллана. | | | | | | | |
| Зорилт-1: Аймгийн нутаг дэвсгэрт шинээр уул уурхайн лиценз нэмж олголгүй, хяналт мэдээллийг олон нийтэд ил тод болгож, хууль бус зөвшөөрлийг хүчингүй болгуулна. | Арга хэмжээ 1.<br>Уул уурхайн хууль бус зөвшөөрлийг хүчингүй болгуулна. | Тусгай зөвшөөрлийн тоогоор | хайгуулын 120, ашиглалтын 95, нийт 215 тусгай зөвшөөрөл байна. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл буурсан байна | | Ашигт малтмалын хүчин төгөлдөр бүхий нийт тусгай зөвшөөрлийн тоо 210 байгаа нь 2021 оны 4-р улирлаас 3 тусгай зөвшөөрлөөр буурсан үзүүлэлттэй байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Бичил уурхайн үйл ажиллагааг хууль, эрх зүйн орчинд нийцүүлэн ил тод, нээлттэй зохион байгуулж, "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох" журмын хэрэгжилтийг 80-аас дээш хувьд хүргэнэ. | Хувиар | Журмын хэрэгжилт хангалтгүй. | Журмын хэрэгжилт 80 хувьд хүргэсэн байна. | ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх зардал | Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” нь Засгийн газрын 2019 оны 355 дугаар тогтоолоор түр хязгаарлагдсан ба түүний хүрээнд хяналт тавьж хууль тогтоомжийн шаардлага хангахгүй 20 орчим нөхөрлөлүүдийн гэрээг цуцлах саналыг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 296 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан журмын танилцуулга сургалтыг Сумдын Засаг дарга, БОХУБайцаагч нарт зохион байгуулсан ба шинэ журмын дагуу гэрээ байгуулж үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөл байхгүй байна.<br>Биелэлт: 100% | 90 |
| Зорилт-2: Уул уурхайн компаниудын /“Нийгмийн хариуцлага”-ын хүрээнд/ нийт бараа бүтээгдэхүүн, ажил | Арга хэмжээ 1.<br>“Нийгмийн хариуцлага”-ын гэрээг хийж, гэрээний хэрэгжилтийг дүгнэж хэвшүүлнэ. | Хувиар | - | гэрээний хэрэгжилт 100 хувь | - | Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах 3 талт гэрээг 165 аж ахуйн нэгжид хүргүүлсэн. 2022 оны 3 дугаар сард тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тайлант уулзалтыг | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| үйлчилгээний худалдан авалтын 30-аас доошгүй хувийг орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс авах ажлын зохион байгуулалтыг хийж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | Улаанбаатар хотод зохион байгуулж, 2021 оны гэрээний хэрэгжилтийг дүгнэж хэлэлцүүллээ. Гэрээний хэрэгжилт 78.3 хувьтай дүгнэгдсэн. 2022 оны гэрээний хэрэгжилтийг дүгнэх хугацаа болоогүй.<br>Биелэлт: 78,3% | |
| | Арга хэмжээ 2.<br>Уул уурхайн компаниудад бараа, ажил үйлчилгээ нийлүүлэх боломжтой жижиг дунд үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалт, үйл ажиллагааг дэмжих замаар орон нутагт оруулах эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | Хувиар | - | Уул уурхайн компаниудын нийт бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний дотоодын худалдан авалтыг 30 хувьд хүргэсэн байна. | - | Уул уурхайн салбарын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, томоохон аж ахуйн нэгжүүдээс худалдан авалтын төлөвлөгөөгөө ирүүлэх хүсэлт хүргүүлж, хамтран ажилласнаар 8 суманд үйл ажиллагаа явуулж буй 14 аж ахуйн нэгж, уурхай дотоодын үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдээс хүнс, ахуйн бараа бүтээгдэхүүн, шатахууны болон бусад ажил үйлчилгээнд 190 гаруй сая төгрөгийн худалдан авалт хийж орон нутгийн иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж ажилласан байна. Энэ нь тухайн аж ахуйн нэгжүүдийн 2022 оны нийт худалдан авалтын 14 хувийг эзэлж байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-3: Жоншны баяжмал, шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Мэргэжлийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран төсөл хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ. | Төслийн хэрэгжилтээр | - | Үйлдвэрийн барилгын ажил эхэлсэн байна. | - | Бор-өндөр, Баян-Овоо сумдад хайлуур жонш баяжуулах үйлдвэр, Бор-Өндөр суманд төмрийн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн төслүүдийг дэмжиж, төр хувийн хэвшилтэй хамтран ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн, ашиглалтад оруулан ажиллаж байна. Бор-өндөр, Дархан сумдад хайлуур жонш баяжуулах, олборлох үйлдвэр, Бор-Өндөр суманд төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн төслүүдийн хэрэгжилттэй танилцаж, уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр хувийн хэвшил хамтран ажиллах талаар хэлэлцлээ. Мөн "Шинэ сэргэлтийн бодлого"-д | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тусгагдсаны дагуу аж үйлдвэрийг хөгжүүлэх, төв суурын газрын төвлөрлийг сааруулах хүрээнд "Аж үйлдвэрийн нэгдсэн парк бүхий шинэ Бор-Өндөр хот байгуулах" төслийг Засгийн газрын түвшинд хэлэлцүүлж, холбогдох хууль эрхзүйн зохицуулалтыг бий болгох, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх санал хүсэлтийг хүргүүлээд байна.<br>Биелэлт: 50% | |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Нутаг дэвсгэрийнхээ байгалийн баялгийг ашиглах, байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, цэцэрлэгт хүрээлэн, зүлэгжүүлсэн талбай байгуулах, мод, бут сөөг тарьж ургуулах, газар нутгийнхаа тодорхой хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах, бусад арга хэмжээний цогцолбор хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; | | | | | | | |
| Зорилт-1: Чингис хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Чингис хотын агаарын чанарын бүс тогтоож, бүсэд мөрдөх журам батлуулж, агаарын бохирдлыг бууруулах менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. | Хэрэгжилтийн хувиар | Чингис хотын агаарын бохирдлын төлөв байдлын суурь судалгаа хийгдсэн. | Төлөвлөгөөний 1 дүгээр үе шатны хэрэгжилт 100 хувь хангагдсан байна. | БХНСЗ, Төсөл хөтөлбөр | Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Аймгийн Засаг даргын 2022 оны А/492/А/557 дугаар хамтарсан шийдвэрээр Чингис хотын агаарын чанарын 1, 2 дугаар бүсийг тогтоож, бүсэд мөрдөх журмыг баталсан. Журмын дагуу бүс тус бүрд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд тусгагдсан ба хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Чингис хотын хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хөрсний бохирдлыг бууруулна. | Хэрэгжилтийн хувиар | Хөрсний бохирдлын төлөв байдлын суурь судалгаа хийгдсэн. | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт 60 хувь хангагдаж, хөрсний бохирдол буурсан байна. | БХНСЗ, Төсөл хөтөлбөр | Аймгийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагууд, сумдад хүргүүлж санал авч, ажлын хэсгээр хэлэлцүүлж, 12 дугаар сарын 05-нд аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулсан. Аймгийн төвийн ил задгай хог хаягдлыг 2 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээгээр цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулах ажлыг зохион байгуулснаар, 3600 га газрын хөрсний бохирдлыг бууруулсан.<br>Биелэлт: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ 3. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллого зохион байгуулж, агаарын чанарын мониторинг хяналтыг тогтмолжуулна. | Ажлын үр дүнгээр | Жил бүр хийгдэж, суурь мэдээллийн сан бий болсон. | Тооллогын ажил зохион байгуулагдаж, үр дүнд анализ хийгдсэн байна. | ОНТ | 2022 оны агаарын бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг 18 сум 5 тосгоны хэмжээнд зохион байгуулж нэгтгэл үр дүнг хуулийн хугацаанд багтаан БОАЖЯаманд хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт 7024 айл өрх тоологдсоноос ердийн галлагаатай айл өрх 6007 /89%/, сайжруулсан зуухтай айл өрх 1017 /11%/ байна. Мөн байшингийн ердийн галлагаатай зуухтай айл 81%, сайжруулсан зуухтай айл өрх 19% эзэлж байна. Хүчин чадлаар ангилбал 4200кВт -2, 100-4200кВт зуух 34, 15-100кВт зуух 3335 зуух тоологдсон. Сумын төвүүд төвлөрсөн инженерийн шугам сүлжээ, дэд бүтцэд холбогдсон тул 15-100кВт зуухны тоо 23%-иар буурсан үзүүлэлттэй байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-2: Шахмал түлшний хэрэглээг нэвтрүүлж, "Эко өрх", “Өрх бүр ногоон төгөл” аяныг өрнүүлж гэр хорооллын айл өрхүүдийн 50 хүртэл хувийг хамруулснаар агаар хөрсний бохирдлыг тус тус 30 хүртэл хувиар бууруулна. | Арга хэмжээ 1. "Эко өрх", "Өрх бүр ногоон төгөл" аяны төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хамрагдсан өрхийн эзлэх хувиар | - | нийт өрхийн 20-аас доошгүй хувийг аянд хамруулна. | ОНТ, БХНСЗ, Төсөл хөтөлбөр | Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд "Өрх бүр ногоон төгөл" аяныг сум бүрт зохион байгуулахыг уриалж, нийт гэр хорооллын өрхийн 28 хувь болох 3418 айл өрх хашаандаа 10.0 мянга гаруй мод бут тарьж оролцсон байна. Хэрлэн сумын хэмжээнд "Эко өрх" аяныг өрнүүлж, хашаандаа мод бут, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарьсан, хог хаягдлаа ангилсан зэрэг шалгуураар "Эко өрх" шошгыг 170 өрхөд гардуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах нөлөөллийн ажлыг зохион байгуулж байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2. Шахмал түлш үйлдвэрлэх, худалдаалах иргэн, аж ахуйн нэгж байгууллагын санал санаачилгыг дэмжиж, | Хувиар | - | Шахмал түлшийг борлуулах, худалдаалах цэг бий болгож, хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн байна | БХНСЗ, ХХХО | Батширээт, Өмнөдэлгэр, Биндэр сумдын ЗДТГ-аас тус бүр 1 албан хаагчийг Сэлэнгэ аймагт шахмал түлшний зуухыг ажиллуулах чиглэлээр туршлага судлуулсан. Налайх дүүргэт үйлдвэрлэгдэж буй шахмал түлш нь одоогоор УБ хотын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | түүхий нүүрсний хэрэглээг бууруулна. | | | | | гэр хорооллын айл өрхийн хэрэглээг дөнгөж хангахуйц хүчин чадалтай ажиллаж байгаа тул орон нутаг руу нийлүүлэх, худалдах борлуулах цэг байгуулах боломжгүй талаар хариу ирсэн.<br>Биелэлт: 70% | |
| Зорилт-3: Хогны менежментийг үр дүнтэй хэрэгжүүлж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд хэвшүүлж, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар төвлөрсөн хогийн цэгт очих хог хаягдлын хэмжээг 40 хүртэл хувиар бууруулна. | Арга хэмжээ 1.<br>Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд хэвшүүлэх, сургалт, мэдээлэл, нөлөөллийн ажлуудыг жил бүр зохион байгуулна. | Арга хэмжээний тоогоор | - | Сургалт, нөлөөллийн ажлыг 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан байна. | БХНСЗ, Төсөл хөтөлбөр | Сумдын Засаг дарга, БОХУБ нарт Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоотой хамтран хог хаягдлын менежментийн 5 модуль сургалтыг зохион байгуулсан. 3 суманд "Эко хот-эрүүл орчин" аян зарлаж айл өрхүүдийн дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг цуглуулж, модны суулгац, хүнсний ногооны үр үрсэлгээгээр солих "Хогоо мод болгоё" нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 700 гаруй өрх хамрагдаж дахин боловсруулах боломжтой нийлэг уут, хуванцар сав, лааз, шил, цаас, баттерей зэрэг 3 тонн орчим хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, цуглуулсан. Мөн ЕБС-ын сурагчдын дунд "Аюулыг авдарлая" сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 313ш сав буюу 117375 ширхэг тамхины ишийг цуглуулж устгасан. Баялаг хурах ХХК нь 10тн хуванцар, 1тн лаазыг TML ХХК-ын үйлдвэрт, 3тн гялгар уутыг Пластик центр ХХК-д тушаагаад байна. АПУ ХХК 50000ш буюу 22.2тн архи пивоны шилийг буцаан авч дахин ашигласан.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Сумдад хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана. | Хамрагдсан сумын тоогоор | - | 2-оос доошгүй суманд хогны менежментийг хэрэгжүүлж, техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, дахивар хог хаягдлын хэмжээ | ОНТ | Баян-Адрага сумын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор "Дахивар хог хаягдал цуглуулах цэг" байгуулаад байна. Мөн Дархан сум хог хаягдал пресслэгч тоног төхөөрөмж, Дэлгэрхаан сум хог тээврийн автомашин шинээр авсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 20 хүртэл хувиар буурсан байна. | | ТАЖХТөслийн санхүүжилтээр Дадал суманд 2-р зэрэглэлийн ландфилл цэг байгуулагдаж байна. Баянмөнх сум хуучин хогийн цэгийг дарж булшлан шинээр ландфил хогийн цэг бий болгосон. Баялаг хурах ХХК нь 10тн хуванцар, 1тн лаазыг TML ХХК-ын үйлдвэрт, 3тн гялгар уутыг Пластик центр ХХК-д тушаагаад байна. АПУ ХХК 50000ш буюу 22.2тн архи пивоны шилийг буцаан авч дахин ашигласан. Энэ нь 2021 оны хог хаягдлын бүтцийн судалгаатай харьцуулахад нийт дахивар хог хаягдлын 19.3 хувийг эзэлж байна.<br>Биелэлт: 100% | |
| Зорилт-4: Төв суурин газрын ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлж, нийт 65 га-д хүргэнэ. | Арга хэмжээ 1.<br>"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг жил бүр зохион байгуулж, аймгийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг 20 га талбайгаар нэмэгдүүлж нийт 65 га-д хүргэнэ. | Талбайн хэмжээгээр /га/ | Аймгийн нийт ногоон байгууламжийн талбайн хэмжээ 45 га | 15000 ш мод тарьж ногоон байгууламжийн талбайн хэмжээг 5 га -аар нэмэгдүүлнэ. | БХНСЗ, ААНХ, Төсөл хөтөлбөр | Хавар, намрын “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийн хүрээнд аймгийн хэмжээнд төв суурин газарт нийт 148.7 мянган мод таригдаж, ногоон байгууламжийн хэмжээ 29.5 га талбайгаар нэмэгдсэн. Дээрх ажилд давхардсан тоогоор 20.5 мян иргэн, 905 ААН, байгууллага 3418 өрх хамрагдаж, 595 хүнийг түр ажлын байраар хангаж ажилласан.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Чингис хотын нийтийн эзэмшлийн талбайд зүлэгжүүлэлт хийж хөл газрын ургамлын талбайн хэмжээг бууруулж, ногоон байгууламжид арчилгаа хийнэ. | Талбайн хэмжээгээр /га/ | 2020 онд 0.3 га талбайг зүлэгжүүлсэн. | Нийтийн эзэмшлийн 1 га талбайд зүлэгжүүлэлт хийж ногоон байгууламжийг арчилна. | БХНСЗ, ААНХ, Төсөл хөтөлбөр | Чингис хотын нэгдсэн эмнэлгийн урдуур байрлах явган хүний зам дээгүүрх 0.05 га, олимп цогцолборын хойд талаас Эрдэнэ буудал хүртэл Нарс тарьсан хайсны 0.06 га, Чойномын хөшөөтэй гэрэлт гудамжны 0.8 га нийт 0.9 га талбайн хөл газрын ургамлыг устгаж, ногоон байгууламжийн арчилгааг хийсэн.<br>Биелэлт: 90% | 100 |
| Зорилт-5: Аймгийн хэмжээнд 1000 га талбайд ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж, нийт ойн сангийн ойгоор бүрхэгдсэн | Арга хэмжээ 1.<br>Жил бүр ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. | Талбайн хэмжээгээр /га/ | Ойжуулалтын ажлыг 150 га талбайд хийсэн. | Ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 250 га талбайд хийнэ. | УТ, БХНСЗ ААНХ, Төсөл хөтөлбөр | Аймгийн хэмжээнд нийт 222.5га талбайд ойжуулалт хийгдэж, 442.6 мянган ширхэг нарс, шинэсний тарьц таригдсан байна. Дээрх ажилд 21 ААН оролцож, 211 хүнийг түр ажлын байраар хангасан.<br>Биелэлт: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| талбайн хэмжээг 0.05 хувиар нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 2.<br>Ойн хөнөөлт шавжийн идэвхжилээс шалтгаалан голомт үүссэн талбайн 50-аас доошгүй хувьд нь тэмцлийн ажлыг зохион байгуулж ойг доройтлоос хамгаална. | Талбайн эзлэх хувиар | Ойн хөнөөлт шавьжийн тэмцлийн ажлыг 2000 га талбайд хийсэн | Тухайн жилийн голомт үүссэн талбайн 50-аас доошгүй хувьд тэмцлийн ажлыг зохион байгуулна. | УТ, БХНСЗ ААНХ | Улсын төсвийн хөрөнгөөр "Ойн судалгаа хөгжлийн төв" УТҮГ-аар хийлгэсэн 2021 онд намрын судалгаагаар ойн хөнөөлт шавж 5187га-д тархалттай, 3378 га-д ойн хөнөөлт шавьжийн голомттой гэсэн дүн гарсан. Цэнхэрмандал сумын Хөх нуур нэртэй газарт 376га талбайд Цэнхэрмандал сумын ойн анги орон нутгийн төсвийн хөрөнгийн БХНСАХЗ-аар, Биндэр сумын 1500га талбайд Биндэр-Ой СДОА өөрийн хөрөнгөөр Яковсоны төөлүүрч эрвээхэйн тэмцлийн ажлыг хийж гүйцэтгэснээр нийт голомттой талбайн 55.5%-д тэмцлийн ажлыг хийлээ.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-6: Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх, түүний ай сав газар, ховор ан амьтан, ургамлын тархац нөөц бүхий байгалийн унаган төрхийг хадгалж хамгаалах, экосистемийн ач холбогдол бүхий газруудыг улсын болон аймаг, орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулж, нийт нутаг дэвсгэрийн 47 хувьд хүргэнэ. | Арга хэмжээ 1.<br>Усны ай сав бүхий болон экосистемийн ач холбогдол бүхий газрыг улсын болон орон нутгийн хамгаалалтад авна | ТХГН-ийн эзлэх хувиар | 43.03% | 47% | УТ, Төсөл хөтөлбөр | Улсын тусгай хамгаалалттай 9 газрын 1071460 га, орон нутгийн хамгаалалттай 452 газрын 2513846,4 га, нийт 461 газрын 3585306,4 га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 44,6 хувийг тусгай хамгаалалттай газар нутаг эзэлж байна. Өмнөдэлгэр сумын Тэнүүн гол орчмын газрыг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах судалгааны ажил хийгдэж байна.<br>Биелэлт: 100% | 90 |
| Зорилт-7: Амьтны нөөцийг хамгаалах, өсгөж үржүүлэх, ашиглах менежмент зохион байгуулалтыг зохистой хийж, ховор амьтдын тоо толгойг 3 хүртэл хувиар өсгөнө. | Арга хэмжээ 1.<br>Ховор, нэн ховор амьтдыг хамгаалах, идэш тэжээлээр хангах био техникийн арга хэмжээ авна. | Хамрагдсан сумын тоогоор | ОББЦГазар, 9 суманд био техникийн арга хэмжээ авсан. | Жилд 4-өөс доошгүй суманд био техникийн арга хэмжээ авсан байна. | БХНСЗ | Дархан сумын Дархан ан нөхөрлөл, Бор-Өндөр сумын 6-р багийн малчин Г.Далайбаяр нартай гэрээ байгуулж нэн ховор, ховор амьтад нутагладаг 2 сумын 8 газарт байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлын 3.0 сая төгрөгөөр 200 боодол өвс, 8тн хужир шүүг тавьж биотехникийн арга хэмжээ авч | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | амьтны нөөцийг өсч үржих боломжоор хангаж байна.<br>Биелэлт: 100% | |
| | Арга хэмжээ 2.<br>Амьтны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх зорилгоор агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | Агнуур зохион байгуулалт хийсэн тоогоор | 13 агнуур зохион байгуулалтын менежмент төлөвлөгөө хийгдсэн. | Жил бүр 1-ээс доошгүй агнуур зохион байгуулалтын менежмент төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна. | БХНСЗ | Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнтэй гэрээ байгуулж Өмнөдэлгэр сумын Элгэнжаргалант агнуурын бүс нутагт нарийвчилсан агнуур зохион байгуулалтын менежмент төлөвлөгөөг хийлгүүлж сумын ИТХ-ын 2022 оны А/26 дугаар тогтоолоор дэмжигдсэн. “Эко-Үйлчилгээ” төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, Хэнтий аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт менежмент төлөвлөгөөг хийлгэж хүлээж авч байна. Монголын анчдын нийгэмлэг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж Хэнтий аймгийн хэмжээнд Монгол тарваганы нарийвчилсан агнуур зохион байгуулалт менежмент төлөвлөгөөг мөн хийлгээд байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-8: Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж, 80-аас доошгүй булаг, шандын эхийг хашиж хамгаална. | Арга хэмжээ 1.<br>Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 120-оос доошгүй тэмдэг тэмдэгжүүлэлт хийнэ. | Тэмдэгжүүлэлтийн тоогоор | Усан сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсээр 124 тэмдэг байршуулсан. | 30-аас доошгүй тэмдэгжүүлэлт хийгдсэн байна. | БХНСЗ | Баянмөнх, Баянхутаг сумдын нутаг дэвсгэрт Хэрлэн голын онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг сурталчлан, таниулах 50 ширхэг тэмдэг байршуулж, орон нутагт хүлээлгэн өгсөн.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2.<br>Шаардлагатай булаг шандын эхийг хашаажуулах, сэргээн засах ажлыг зохион байгуулна. | Хашиж, сэргээсэн булаг шандын тоогоор | Аймгийн хэмжээнд 907 булаг шанд байгаагаас 75 булгийн эхийг хашиж хамгаалсан. | 20-аас доошгүй булгийн эхийг хашиж, сэргээн зассан байна. | БХНСЗ, төсөл хөтөлбөр | Хэрлэн голын сав газарт хамаарах сумдад 10 булаг, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт хамаарах сумдад 5, Онон-Улз голын сав газарт хамаарагдах 3 суманд 5, нийт 20 булгийн эхийг хашиж, хашааг сэргээн засаж хамгаалсан.<br>Биелэлт: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-9: Элэгдэл, эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газар, түүний хэвлийд техникийн нөхөн сэргээлт ажлыг 80 га газарт хийнэ. | Арга хэмжээ 1. Эзэнгүй орхигдсон газрын хэвлийг нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулна. | Талбайн хэмжээгээр /га/ | 38.4 га газарт нөхөн сэргээлт хийсэн. | Уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн орхигдсон 25 га-талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байна | БХНСЗ | 2022 онд 48.3 га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Орон нутгийн төсвийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан суманд хууль бус гар аргаар байгалийн өнгөт чулуу түүсэн иргэдийн нөлөөгөөр эвдрэлд орсон 10га талбайг 10 сая төгрөгийн өртгөөр “Шижир тэмүүлэл” ХХК, Бор-Өндөр суманд хууль бус жонш олборлолтоос үүсч эвдрэлд орсон 10га талбайг 20 сая төгрөгийн өртгөөр “Итгэлт буман эрдэнэ” ХХК, Баян-Адарга суманд хууль бус жонш олборлолтоос үүсч эвдрэлд орсон 10га талбайг 20 сая төгрөгийн өртгөөр “Адарга тохижилт” ОНӨҮГазар тус тус техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгээд байна. Бор-Өндөр суманд аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлт 18.3га талбайд хийсэн.<br>Биелэлт: 100% | 90 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Төрийн бодлого, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, газар тариалангийн болон жижиг, дунд, хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг боловсруулж Хуралд өргөн мэдүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалтыг дэмжих, тариалангийн бүс нутгийг тогтоох, тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, хөрсийг хамгаалах, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх. | | | | | | | |
| Зорилт-1: Тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулан эргэлтэд оруулж, хөрсний үржил шимийг хамгаалах, хашаажуулах, сэлгээнд үр тарианы тариалалтыг нэмэгдүүлэх замаар тариалангийн тогтвортой хөгжлийг хангана. | Арга хэмжээ 1. Атрын 4 дахь аян, тариалангийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | Төлөвлөгөө батлуулан, хэрэгжүүлнэ. | Атрын 3 дахь аян хэрэгжиж дууссан. | Атрын 4 дахь аяны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлнэ. | - | 2022 оны тариалалтад 18 сум 5 тосгоны 40 гаруй аж ахуйн нэгж, 700 гаруй иргэн үр тариа, төмс, хүнсний ногоо, тосны ургамал, ногоон тэжээл, эмийн ургамал зэрэг таримлуудыг нийт 32.1 мянган га-д тариалсан. Үр тариа шууд хураасан 11849 га, Ангилан хадсан 3790 га, Цайруулсан 3940 га нийт 17283 тн буюу нэгжээс 11 цн, үүнээс улаан буудай 14342 га-с 15793 тн, төмс 285 га-аас 2536 тн, хүнсний ногоо 271.5 га-аас 3231 тн, ногоон тэжээл 2845 га-аас 4269.5 тн, тосны | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ургамал 5858 га-аас 2153 тн, хунчир 80 га-аас 50 тн тус тус байгаагаас үр тариа 92 хувь, төмс 96.3 хувь, хүнсний ногоо 78.9 хувь, ногоон тэжээл 86 хувь, тосны ургамал 57.5 хувьтай тус тус хураан аваад байна. Атрын 4 дахь аян, тариалангийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг газар тариаланчид болон холбогдох иргэдээр хэлэлцүүлсэн ба 12 сард багтаан батлуулахад бэлэн болоод байна. Биелэлт: 100% | |
| | Арга хэмжээ 2. Тариалалт хийхгүй байгаа эзэмшлийн газар болон атаршсан 20.0 мянган га тариалангийн талбайг 100 хувь эргэлтэд оруулна. | Тариалангийн талбайгаа ашиглахгүй байгаа иргэн, ААН судалгааг гарган арга хэмжээ авсан байх, иргэдийн атаршсан эзэмших хүсэлтийг үндэслэн 5000 хүртэл га газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлсэн байх | Нийт 91 мянган га тариалангийн талбайн 31.0 мянган га талбайд 2 жил ба түүнээс дээш хугацаагаар тариалалт хийгдээгүй, атаршсан 7.2 мянган га талбай байна. | Тариалангийн талбайгаа ашиглахгүй байгаа иргэн, ААН судалгааг гарган арга хэмжээ авч, иргэдийн атаршсан эзэмших хүсэлтийг үндэслэн 5000 хүртэл га газрыг тариалангийн зориулалтаар эзэмшүүлнэ. | - | 5 сумын нийт 2638.3га атаршсан талбайг шинээр эргэлтэд оруулахаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган эзэмшүүлээд байна. Биелэлт: 100% | 70 |
| | Арга хэмжээ 3. Тариалангийн талбайг хашаажуулах ажлыг эрчимжүүлнэ | Хашаажуулсан талбайн хэмжээ нэмэгдсэн байх. | 200 га тариалангийн талбайг хашаажуулсан. | Хашаажуулсан талбайн хэмжээ нэмэгдсэн байна. | УТ, ОНТ | Баян-Адарга сумын “Идэр-Онон” ХХК 139га, “Мөнхийн дуурлиг” ХХК 126га нийт 265га тариалангийн талбайг "Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал" төслийн 152.0 сая төгрөгийн хөрөнгөөр хашаажуулсан. Мөн Хэрлэн сумын Өлзийт тосгоны “М-АГРО” ХХК 8255га тариалангийн талбайг өөрийн 4.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр, иргэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | А.Лувсандавга 450га тариалангийн талбайг өөрийн 258.1 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус хашаажуулсан. Биелэлт: 100% | |
| Зорилт-2: Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулж, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэн, хүлэмж, зоорийн аж ахуйн хангамжийг сайжруулна. | Арга хэмжээ 1. Төмс, хүнсний ногооны тариалалт, үйлдвэрлэлд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ. | Шаардлагатай сум, тосгонд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн байх. | Нийт сумдын тариалалтад тоног төхөөрөмж дутагдалтай байна | Шаардлагатай сум, тосгонд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн байна. | ОНТ | Энэ онд Хэрлэн, Мөрөн сумдад Монгол улсын Засгийн газрын хөнгөлөлттэй нөхцөлөөр 50 морины хүчин чадалтай трактор 2ш, 80 морины хүчин чадалтай трактор 1ш, хор цацагч 2ш, сийрүүлэгч, манагч кон 1.4А 1ш, нарийн ногооны үрлэгч 1ш, чиргүүл 1ш, 3 корпустай плуг 1ш тус тус олгосон. Мөн ОНТөсвийн 85.0 сая төгрөгийн хөрөнгөөр Цэнхэрмандал суманд 120 морины хүчин чадалтай 1 трактор тус тус шийдвэрлэсэн. Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2. Хэрлэн суманд услалтын систем шинээр байгуулна. | Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулсан байх. | Төслийн судалгааны ажил дууссан. | Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж дууссан байна. | АХБ-ны хөрөнгө оруулалт | "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны 100 хувийн санхүүжилтээр Хэрлэн суманд 700 га-д услалтын систем шинээр байгуулах зураг төсөл хийгдэж, хашаажуулалтын ажлыг эхлүүлээд байна Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 3. Стандартын шаардлага хангасан 50-100 тн багтаамжтай төмс, хүнсний ногооны төрөлжсөн зоорь барина. | Мөрөн суманд зоорь барина. | Нийт сумдад одоо ашиглаж байгаа зоорины 60-70% нь ашиглалтын шаардлага хангахгүй байна. | Мөрөн суманд зоорь барьсан байна. | УТ, ОНТ, ЗЗББУХТ | “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт” төслийн 120.0 сая төгрөгийн хөрөнгөөр төмс, хүнсний ногоо хадгалах зоорь шинээр барих тендерт “ЭН БИ ЖИ” ХХК шалгарч Мөрөн суманд 100 тонны багтаамжтай төмс, хүнсний ногооны төрөлжсөн зоорь шинээр барьж ашиглалтад оруулсан. Хувийн хэвшлийн өөрийн хөрөнгө оруулалтаар Бэрх, Дархан суманд 50 тн багтаамжтай зоорийг тус тус барьж ашиглалтад оруулсан. Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 4. Төмс хүнсний ногооны худалдан борлуулах | Хэрлэн, Өмнөдэлгэр суманд | Төрөлжсөн худалдааны цэг байхгүй. | Хэрлэн, Өмнөдэлгэр суманд борлуулалтын цэг | ОНТ, ЗЗББУХТ | “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт” төслийн 240.0 сая | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрөлжсөн худалдааны цэгийг ногоочдын үүсгэл санаачлагд тулгуурлан Чингис хотын төвд байгуулах ажилд дэмжлэг үзүүлнэ. | борлуулалтын цэг шинээр байгуулсан байх. | | шинээр байгуулсан байна. | | төгрөгийн хөрөнгөөр Хэрлэн, Өмнөдэлгэр сумдад төмс, хүнсний ногоо худалдан борлуулах төрөлжсөн худалдааны цэгийг шинээр барьж ашиглалтад оруулан үйл ажиллагаа явагдаж байна.<br>Биелэлт: 100% | |
| | Арга хэмжээ 5.<br>Хүнсний ногоо, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх сургалт, зөвлөгөөн зохион байгуулна. | 100 хүртэл үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулж, ХААЗД нэвтрүүлсэн ААН-ийн тоог нэмэгдүүлсэн байх. | Аймгийн хэмжээнд 2020 онд 2 удаагийн онлайн сургалт зохион байгуулж, 3 аж ахуйн нэгжид ХААЗД-ын зөвлөх үйлчилгээг үзүүлэн ХААЗД нэвтрүүлэн гэрчилгээ авсан. | Хүнсний ногоо, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, ХААЗД нэвтрүүлсэн ААН-н тоог нэмэгдүүлсэн байна. | ОНТ | Хүнсний ногоо, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх сургалт, аймгийн "Тариаланч, ногоочдын зөвлөгөөн" арга хэмжээг жил бүр зохион байгуулж, 18 сумын газар тариалан эрхлэгч 20 аж ахуйн нэгж, 61 ногоочид, мөн сумын газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд нийт 100 орчим оролцогчдод хаврын тариалалтын ажлыг оновчтой зохион байгуулах талаар техникийн зөвлөмж зөвлөгөөг өгч ажиллаж байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Үндсэн чиг үүргийн нэр: Аймгийн нутаг дэвсгэрт мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, малын генетик нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах, сайжруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн үзлэг, лабораторийн шинжилгээ, мал эмнэлгийн үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавих. | | | | | | | |
| Зорилт-1: Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж, “Монгол мал-II” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан үе шаттай хэрэгжүүлнэ. | Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн байх. | - | Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн байна. | - | “Монгол мал-II” арга хэмжээг хэрэгжүүлэх 14 арга хэмжээг төлөвлөж, 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг 90 хувьтай хэрэгжүүлж ажилласан.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-2: Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, оношилгоо шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэн малын гаралтай халдварт, гоц халдварт | Арга хэмжээ 1.<br>Мал эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулж, үйлчилгээ, оношилгооны чанар, хүртээмжийг дээшлүүлнэ. | Элиза аппарат, голомтод ажилласан эмчийн багаж, тоног төхөөрөмжийг ариутгах Автоклав худалдан авсан байх. | 2017 онд 5 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмж худалдан авсан. | Элиза аппарат, голомтод ажилласан эмчийн багаж, тоног төхөөрөмжийг ариутгах Автоклав худалдан авсан байна. | ОНТ | Орон нутгийн төсөвт Мал эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмж болох Элиза аппарат, голомтод ажилласан эмчийн багаж тоног төхөөрөмж, ариутгах автоклавын хөрөнгийг суулгаж худалдан авч өгсөн.<br>Биелэлт: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| өвчний гаралтыг бууруулна. | Арга хэмжээ 2. Сумдын МЭТасагт шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ. | Сумдад шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргах. | - | Сумдад шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, тоног төхөөрөмж олгосон байх. | ОНТ | 6 суманд 16.8 сая төгрөгөөр зөөврийн компьютер, бар код уншигч, хэвлэгч төхөөрөмж, мал тарилгын хашааны зардлыг шийдвэрлэсэн.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 3. Голомтлон гардаг 5 төрлийн халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, малаас хүнд халдварладаг халдварт, гоц халдварт өвчнүүдийн голомтуудыг жил бүр ариутгах ажлыг зохион байгуулна. | Халдварт өвчний гаралт өмнөх жилээс буурсан байх. | 2020 онд халдварт өвчний гаралт 47 голомтод байсан. | Халдварт өвчний гаралт өмнөх жилээс буурсан байна. | ОНТ 409.8 | 2021 онд 3-н төрлийн халдварт өвчний голомт 21 бүртгэгдсэн бол 2022 онд 15-н голомтод бүртгэгдэж халдварт өвчний гаралт өмнөх жилээс 28.6 хувь буурсан байна.<br>Биелэлт: 70% | 100 |
| Зорилт-3: Бэлчээр хамгаалалт, ашиглалтыг сайжруулан, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, усан хангамжийг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг тогтмол явуулах тоног төхөөрөмжөөр хангана. | Цаг агаарын нөхцөл бүрдсэн үед хур тунадасны хэмжээг нэмэгдүүлж ажилласан байх. | Жил бүр тогтмол зохион байгуулдаг. | Цаг агаарын нөхцөл бүрдсэн үед хур тунадасны хэмжээг нэмэгдүүлж ажилласан байна. | Аймгийн Засаг даргын нөөц сан 10,0 | Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг 2 хөдөлгөөнт экспедици 14 удаа зохион байгуулж ажилласан. Хур тунадсыг 51,2%-иар нэмэгдүүлсний дүнд зуншлагын байдал нийт нутгийн 87,3% нь сайн, 12,7%-д дунд зэрэг байсан. Бэлчээрийн зуны дээд ургац 2.8-19.4ц/га. 2020-2021 оны мөн үетэй харьцуулахад 1.2-9.6 ц/га-р илүү байна. Өвөл хаврын бэлчээрийн даац багтаамж 60 гаруй хувьд нөөцтэй болон хүрэлцээтэй, 40 орчим хувьд хэтэрсэн байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2. Үлийн цагаан оготно устгалын ажлыг зохион байгуулж, бэлчээрийг хамгаална. | 6 сумын 30 мянган га-л үлийн цагаан оготно устгалын ажил хийх. | жил бүр 60.0 мянган га-д устгалын ажил хийгдсэн. | Үлийн цагаан оготно устгалын ажил хийгдсэн байна. | УТ, | 7 суманд малын тоо, толгойн албан татварын 42.2 сая төгрөгийн хөрөнгөөр 25.2 мянган га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготнотой тэмцэх, Баянхутаг сум малын тоо, толгойн албан татварын 6.0 сая төгрөгийн хөрөнгөөр 500 га бэлчээрт царцаатай тэмцэх арга хэмжээг технологийн дагуу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтан дор зохион байгуулж ажилласан. Биелэлт: 100% | |
| | Арга хэмжээ 3. Тал хээрийн бүсийн сумдад инженерийн хийцтэй худаг, хөв цөөрөм бий болгоно. | 3-аас доошгүй инженерийн хийцтэй худаг гаргасан байх. | 2019 онд 28 гүн өрмийн худаг гаргасан | 3-аас доошгүй инженерийн хийцтэй худаг гаргасан байна. | УТ, ОНТ, Төсөл хөтөлбөр | Энэ онд 8 суманд орон нутгийн төсвийн 347.0 сая төгрөгийн хөрөнгөөр 20 гүн өрмийн худаг, малчдын санаачилгаар 14 суманд 340.0 сая төгрөгийн хөрөнгөөр 34 гүн өрмийн худаг, төсөл хөтөлбөрийн 192,0 сая төгрөгийн санхүүжилтээр 6 гүн өрмийн худаг, нийт 60 худаг шинээр гаргаж 90.0 мянган га бэлчээрийг усжуулсан. Биелэлт: 100% | 100 |
| Үндсэн чиг үүргийн нэр: Орон нутагт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдгээрийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэх. | | | | | | | |
| Зорилт-1: Гарааны бизнес эрхлэгчид, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хувийн хэвшлийн санал санаачилгыг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж, борлуулалтын сүлжээг нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1. Чингис хот дахь гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулах "Бизнес инкубатор төв"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ. | 2-с доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг бойжуулах. | 7 үйлдвэрийн 25 ажлын байрыг бий болгосон. | Бизнес инкубаторын үйл ажиллагааг сайжруулж, 2-с доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг бойжуулсан байна. | - | Гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулах Бизнес Инкубатор төвд 2022 онд мах дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, утсан тахиа, алаг салат, кимчи үйлдвэрлэх цех, хэрчсэн гурил, талхны цех 2, ааруул цагаан идээ боловсруулах цех, ноос ноолууран хувцас үйлдвэрлэл зэрэг 6 бойжигчийг бойжуулахаар хамтран ажиллах гэрээ хийгдээд байна. Одоогийн байдлаар мах дайвар бүтээгдэхүүн боловсруулах цех нь 4 төрлийн хиам, элэгний нухаш, борц зэрэг бүтээгдэхүүнийг гаргаж шинжилгээнд өгч худалдаанд гаргахад бэлэн болоод байна. Тус үйлдвэр бий болсноор байнгын 3 ажлын байрыг шинээр бий болгоод байна. Хөгжлийн шийдэл ТББ-ийн Бест хөтөлбөртэй хамтран Бизнес инкубатор төвийн бойжигч нарт “Албан ба албан бус бизнесийн ялгаа”, “Компаний дүрэм ба анхаарах асуудлууд” зэрэг сэдэвт сургалт өгч чадавхжуулсан. Биелэлт: 70% | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ 2. "Хэнтийн намрын ногоон өдрүүд", "Цагаан сар-Цагаан идээ" үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулна. | 18 сум, 5 тосгоны үйлдвэрлэгчдийг хамруулах. | Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг. | "Хэнтийн намрын ногоон өдрүүд", "Цагаан сар-Цагаан идээ" үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан байна. | ОНТ | "Цагаан сар-Цагаан идээ" үзэсгэлэн худалдаа сум тус бүрт зохион байгуулж 18 сумын 143 иргэн, 34 аж ахуйн нэгж оролцож, 370.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. “Хэнтийн намрын баяр - 2022” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж 18 сум, 5 тосгоны 123 иргэн, 40 аж ахуйн нэгж, 2 нөхөрлөл, 8 хоршоод 270 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 55.0 сая төгрөгийн борлуулалт хийж төв суурин газрын хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, нөөцлөх худалдан авах боломжийг бүрдүүлэн ажиллалаа.<br>Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 3. Төрийн байгууллагууд, томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчдээс худалдан авах ажлыг зохион байгуулна. | Дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийн хэмжээг нэмэгдүүлж, борлуулалтыг сайжруулах. /тоогоор/ | Жил бүр төрийн 80 гаруй байгууллага дотоодын үйлдвэрлэгчдээс хүнсний үйлдвэрлэл бүтээгдэхүүн худалдан авдаг. | Төрийн байгууллагууд, томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчдээс худалдан авах ажлыг зохион байгуулсан байх, дотоодын үйлдвэрлэлийн борлуулалт өссөн байх. | - | Хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэл эрхлэгч 64 аж ахуйн нэгжээс Бор-Өндөр сум болон Бэрх тосгонд үйл ажиллагаа явуулдаг 5 уурхайд 32.0 сая төгрөгийн хүнсний ногоо, 18 сум, 5 тосгоны 23 сургууль, 21 цэцэрлэг, 1 яслийн үдийн цайнд 606.2 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 18 сумын ЭМТөвд 540.0 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, аймгийн ШШГГазарт 55.0 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, нийт 1.2 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг тус тус нийлүүлээд байна.<br>Биелэлт: 70% | 70 |
| | Арга хэмжээ 4. Хаврын улиралд шаардлагатай махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжид урамшуулал олгох замаар махны үнийн тогтвортой байдлыг хадгална. | 30 тн-оос багагүй махны нөөц бүрдүүлж, үнийн тогтвортой байдлыг хадгалсан байх. | 2020 онд 33.4 тн махны нөөц бүрдүүлсэн | 30 тн-оос багагүй махны нөөц бүрдүүлж, үнийн тогтвортой байдлыг хадгалсан байна. | ОНТ | Хаврын улиралд үүсч болзошгүй махны хомсдол, үнийн хэт өсөлтөөс урьдчилан сэргийлж нөөцийн махны судалгаа гаргахад аймгийн хэмжээнд 6 аж ахуйн нэгж арилжааны зориулалттай 518тн, дотоодын нөөцөд 2 аж ахуйн нэгж 100тн мах нөөцөлсөн байна. Нөөцийн махыг зах зээлийн үнээс хямд үнээр худалдаалах аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарлаж, “Дээдсийн сүрэг” ХХК шалгарсан, Тус аж ахуйн нэгж нь Чингис хотод үйл ажиллагаа явуулж буй 12 хүнсний дэлгүүртэй хамтран ажиллаж төв суурин газрын айл өрхөд зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгийн хямд үнээр хонины мах 20тн, үхрийн мах 10.9тн нийт 30.9тн нөөцийн мах нийлүүлсэн. Аймгийн Засаг даргын нөөц сангийн 50 сая төгрөгийн үнийн хөнгөлөлтийн урамшуулал олгосон.<br>Биелэлт: 100% | |
| | Арга хэмжээ 5. Анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр дэмжинэ. | 5-с доошгүй иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, 15-с доошгүй ажлын байр бий болгосон байх. | 104 иргэн аж ахуйн нэгжид 1480.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. | Анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр дэмжсэн байна. | СХС, ЖДҮДДСан, Төсөл хөтөлбөрүүд | 1. Баян-Овоо суманд “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн 750.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Мал төхөөрөх цогцолбор”-ыг шинээр барьж хоршоонд хариуцуулахаар ажиллаж байна. 2. Мөрөн, Биндэр сумдад европын холбооны дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй "Хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах нь “ИМПАКТ" төслийн 100 хувийн санхүүжилтээр түүхий эдийн агуулах шинээр барьж, Биндэр сумын “Өгөөж баян Биндэръяа”, Мөрөн сумын “Мөнх мандах Мөрөн” хоршоонд тус тус хүлээлгэн өгсөн. 3. Биндэр суманд 16*9 хэмжээтэй түүхий эдийн агуулах 44 сая төгрөг, Мөрөн суманд 12*8 хэмжээтэй түүхий эдийн агуулахыг 37 сая төгрөг, нийт 81 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжүүлээд байна. Мөн тус 2 хоршоонд төслийн 100 хувийн санхүүжилтээр 72 ширхэг Галшар үүлдрийн ухна хүлээлгэн өгснөөр нийт 15 ажлын байрыг бий болгоод байна. 4. Дадал суманд ХХСангаас 2 хоршоо, 1 иргэнд 45 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож 10 ажлын байр хадгалагдан үлдэж, шинээр 11 ажлын байрыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдүүлсэн. 5. Өмнөдэлгэр суманд ЖДҮХСангаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 8 аж ахуй нэгжид 880.000.000 төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдэгдээд байна. Тухайн төслүүд дэмжигдсэнээр шинээр 25 ажлын байрыг нэмэгдүүлнэ.<br>Биелэлт: 50% | |
| Зорилт-2: Төр, хувийн хэвшлийн дэмжлэгээр сумдын халуун усны болон нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулна. | Арга хэмжээ 1. Стандартын шаардлагад нийцсэн ахуйн үйлчилгээний төвийн барилгыг сум, тосгодод шинээр барьж, ашиглалтад оруулна. | Ашиглалтад орсон ахуй үйлчилгээний төвийн тоогоор | 2 суманд ахуйн үйлчилгээний төв ашиглалтад орсон. | 10-аас доошгүй сумдад ахуйн үйлчилгээний төв байгуулна. | ОНТ 600.0 | Мөрөн суманд шинээр 1 ахуйн үйлчилгээний төвийг ашиглалтад оруулсан бөгөөд тус ахуйн үйлчилгээний төвд 3 чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж нийт 5-н иргэнийг ажлын байраар хангаад байна. Мөн Батноров суманд ахуйн үйлчилгээний төвийг ОНХС-ийн хөрөнгөөр төвийн шугамд холбон засвар үйлчилгээ хийх 5.0 төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>Биелэлт: 100% | 50 |
| | Арга хэмжээ 2. Нийтийн халуун усны төвгүй сум, тосгодод халуун усны төв барина. | Нийтийн халуун усны барилга баригдсан сумдын тоогоор | 4 суманд халуун усны барилга шинээр баригдаж ашиглалтад орсон. | 7-оос доошгүй сумдад нийтийн халуун усны барилга барина. | ОНТ | Батноров сум ОНХС-аас 90.0 сая төгрөгийн санхүүжилтээр шинэ халуун усыг барьж ашиглалтад оруулсан.<br>Биелэлт: 100% | 50 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж, аялал жуулчлалыг хөгжүүлэх. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж, аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, зохион байгуулах, аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөтөлбөр, төсөл боловсруулж, зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал оруулах, батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх. | | | | | | | |
| Зорилт-1: Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрутын дагуух сумдад байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэд /өрх/-ийг түшиглэсэн тогтвортой, эко аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1. Нутгийн брэнд, эко бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулж, тогтвортой, эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | Хувиар | Сумдад аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нутгийн иргэд 83, ААН 36 байна. | Шинээр аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоог 3-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ. | ОНТ, төсөл хөтөлбөр 6.5 | 2022 онд 3 удаагийн сургалтад 72 бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хамрагдлаа. Аялал жуулчлал, үйлчилгээний салбарт нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон шинээр үйлчилгээ эрхлэгч иргэдийн хоршоо 1, бүлэг нөхөрлөл 2, өрх 16, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн 4 аж ахуй нэгж нэмэгдэж нийт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэдийн тоо | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өмнөх оноос 12%, аж ахуйн нэгж 9.7%-аар тус тус нэмэгдсэн. Биелэлт: 100% | |
| Зорилт-2: Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн чадавх, орлогыг нэмэгдүүлж, ажлын байрыг 30 хувиар нэмэгдүүлнэ. | Арга хэмжээ 1. Аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэд болон ААН-үүдийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх санал санаачилгыг дэмжиж, ногоон санхүүжилт, бусад хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамруулна. | Хувиар | Аялал жуулчлалын салбарт 808 ажилтан ажиллаж байна. | Ажлын байрыг 10 хүртэл хувиар нэмэгдүүлнэ. | ХХХО, төсөл хөтөлбөр | Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн чадавх орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Гурван голын нүүдэлчид” аялал жуулчлалын холбооны Тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүдийн хамт Хаан банкны удирдлагатай уулзаж, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх ногоон зээлийн үйлчилгээнд хамтран ажиллах зорилгоор уулзалтыг хийж одоогийн байдлаар 2 аж ахуй нэгж материалаа өгч судлуулж байна. 2020 онд байнгын болон түр ажлын байр 808 байсан бол 2021 онд ажлын байр 868, 2022 онд 891 болж 10.2 хувиар нэмэгдсэн байна. Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-3: Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд “Мянганы суут хүн Чингис хаан” цогцолборуудын ажлыг /Дадал сум “Чингис хаан”, Биндэр сум “Их Хуралдай”, Батноров сум “Хүлэг Боорчи-Андлалын өргөө”, Норовлин сум "Шихихутаг-Их засаг”, Бэрх тосгон “Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв”, Дэлгэрхаан сум “Монголын нууц товчоо”/ дуусгаж, дэд бүтцээр холбох ажлыг эхлүүлнэ. | Арга хэмжээ 1. “Мянганы суут хүн Чингис хаан” цогцолборуудын ажлын үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллана. | Хувиар | 6 цогцолборын гүйцэтгэлийн дундаж 40% | 6 цогцолборын гүйцэтгэлийн дундаж 80%-д хүрсэн байна. | УТХО-16769.6 | Түүхэн аялал жуулчлалын бүс нутгийн хүрээнд баригдаж буй цогцолборуудын ажлын явц 77 хувьтай үргэлжилж байна. Биндэр суманд баригдаж буй Их хуралдай цогцолборын гадна болон интерьерийн ажил дууссан. "Шихихутаг-Их засаг” цогцолборын Барилга угсралтын ажил 70%, гадна инженерийн шугам сүлжээний ажил 100%, гадна тохижилт 50%, дотор интерьерийн ажил 20%-тай тус тус үргэлжилж байна. “Монголын нууц товчоо” цогцолборын Барилга угсралтын ажил 60%-тай цогцолборын гадна цахилгаан хангамжийн ажлыг “АЭБОО” ХХК гүйцэтгэж ажил 70%-тай хэвийн үргэлжилж байна. Мөн цогцолборын интерьер, гадна шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр “Ди Эс Ти” ХХК шалгарч 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулан барилгын ажлыг хийж байна.<br>Түүхэн цогцолборуудыг ашиглалтанд оруулах бэлтгэл ажлыг хангаж, дэд бүтцэд холбох ажлууд хийгдэж байгаа бөгөөд холбогдох газруудтай хамтран тогтмол хяналт тавьж ажиллаж байна.<br>Биелэлт: 95% | |
| Зорилт-4: Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрутын дагуу түр буудаллах цэг, мэдээлэл, үйлчилгээний төвийг байгуулж, эдийн засгийн эргэлтэд оруулна. | Арга хэмжээ 1.<br>Дэлгэрхаан, Батноров, Өмнөдэлгэр, Норовлин сумдад түр буудаллах цэгүүд барьж, Хэрлэн суманд аялал жуулчлалын мэдээллийн төвтэй байгуулж ашиглалтад оруулна. | Тоогоор | 4 суманд түр буудаллах цэг байгуулах зураг төсөв хийгдсэн. Мэдээлэл үйлчилгээний төв байхгүй. | 4 суманд түр буудаллах цэг байгуулагдаж, мэдээлэл үйлчилгээний төв ашиглалтад орсон байна. | УТ, ОНТ | Аймгийн төвд Аялал жуулчлалын мэдээллийн төвийг нээж, үйл ажиллагааг жигдрүүлэн иргэд, жуулчдад мэдээлэл өгч ажиллаж байна. Энэ хугацаанд гадаадын 6, дотоодын 35 иргэн үйлчлүүлээд байна. Мөн цахимаар 80 орчим иргэнд түүхэн дурсгалт газар болон аяллын маршрутын мэдээллийг хүргэж үйлчиллээ. Өмнөдэлгэр суманд түр буудаллах цэг байгуулахаар төлөвлөж 2021 онд зураг төсөв хийлгэж батлуулсан бөгөөд тухайн зураг төсвийн дагуу түр буудаллах цэг байгуулах саналыг хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн боловч санал ирүүлээгүй, харин улсын чанартай автозамын трассын дагуу Жаргалтхаан суманд түр буудаллах цэг байгуулах саналыг "Исун мод тур" ХХК-аас ирүүлж, орон нутагтай хамтран ажиллаж "Өртөө 240" түр буудаллах цэгийг барьж ашиглалтад оруулан 10 орчим иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-5: "Монгол хатад", "Ёохор наадаан", "Чингис фестиваль", "Тогорууны баяр", "Талын түмэн адуу", "Галшар адууны баяр", | Арга хэмжээ 1.<br>"Монгол хатдын наадам", "Ёохор наадаан" эвент арга хэмжээг зохион байгуулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ. | Тоогоор | 2019 онд зохион байгуулсан. | 2 жилд 1 удаа зохион байгуулагдсан байна. | ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх зардал 2.0 | 2 жил тутамд 1 удаа зохион байгуулагддаг “Монгол хатдын наадам” арга хэмжээг 2021 онд “Хатдын өргөө” цогцолборын 10 жилийн ойтой уялдуулан зохион байгуулж, Монголын түүх, археологийн судлаачид, өв соёл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| "Талын тайга нохой" наадам зэрэг эвент арга хэмжээнүүдийн цар хүрээг өргөжүүлэн тогтмол зохион байгуулж, гадаад, дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлнэ. | | | | | | өвлөн тээгч оюутан залуусын дунд эрдэм шинжилгээний нээлттэй хурал зарлаж, 10 гаруй илтгэл хэлэлцүүлж иргэд, олон нийтэд мэдлэг түгээж ажиллалаа. “Ёохор наадаан” эвент арга хэмжээ нь ковид-19 цар тахалтай холбоотой УОК-ийн шийдвэрээр цуцлагдсан. Ү.Б | |
| | Арга хэмжээ 2. "Тогорууны баяр", "Талын түмэн адуу", "Галшар адууны баяр", "Талын тайга нохой" наадам зэрэг эвент арга хэмжээнүүдийг жил бүр тогтмол зохион байгуулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ. | Тоогоор | 2019 онд зохион байгуулсан. | Жил бүр зохион байгуулсан байна. | ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх зардал 9.5 | Хэнтий аймгийн хэмжээнд албан ёсны бүртгэлтэй 6 эвент арга хэмжээний 2 нь хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг. Энэ онд зохион байгуулсан "Тогорууны баяр", "Талын гөрөөчин-тайга нохой", "Галшар адууны баяр", "Талын түмэн адуу" эвент арга хэмжээнүүдэд гадаадын 109, дотоодын 2410-н жуулчин, тур оператор 20 гаруй ХХК оролцож үзэж сонирхсон байна. 2020 онд дотоодын жуулчид 48.6 мянга, гадаадын жуулчид 0, 2021 онд дотоодын жуулчид 53.7 мянга, гадаадын жуулчид 0 байсан бол 2022 онд дотоодын жуулчид 54.8 мянга гадаадын жуулчид 719 болж нэмэгдсэн. Дотоод жуулчдын тоо 12.7 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.<br>Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-6: Аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил, цахим орчныг ашиглан дотоод, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ. | Арга хэмжээ 1. Аялал жуулчлалын Олон Улсын үзэсгэлэн /ITM/-д жил бүр оролцож аймаг орон нутгаа сурталчилна. | Оролцоогоор | ITM-2020 үзэсгэлэнд оролцож, дотоод, гадаад сурталчилгааг өргөжүүлсэн. | ITM ОУ-ын үзэсгэлэнд жил бүр оролцож, дотоод, гадаад сурталчилгааг өргөжүүлсэн байна. | ОНТ, Төсөл хөтөлбөр | Ай Ти Эм аялал жуулчлалын үзэсгэлэн Улаанбаатар хотын Мишээл экспо төвд зохион байгуулагдсан. Энэхүү үзэсгэлэнд аймгаас 4 жуулчны бааз 2 зочид буудал, дадал сумын Засаг даргын тамгын газар, Онон балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа хамтран оролцож орон нутгаа болон өөрсдийн аж ахуй нэгжийг давхардсан тоогоор 5000 гаруй иргэнд сурталчилж оролцлоо.<br>Биелэлт: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ 2. Аймгийн аялал жуулчлал, түүх соёл, зан заншил, онцлог давуу талуудыг иргэд, олон нийт, жуулчдад сурталчлан таниулах ном, сэтгүүл, зураг альбом хэвлүүлж, аялал жуулчлалын хөтөч аппликэйшнийг Монгол, Англи хэлээр ашиглалтад оруулна. | Тоогоор | - | 1-ээс доошгүй танилцуулга ном, сэтгүүл хэвлүүлж, хөтөч аппликейшний хандалтыг нэмэгдүүлсэн байна. | ОНТ, Төсөл хөтөлбөр | Хэнтий аймгийн аялал жуулчлал, түүх соёл, зан заншил, онцлог давуу талуудыг иргэд, олон нийт, жуулчдад сурталчлан таниулах, цахим орчинд гадаад дотоод сурталчилгааг нэмэгдүүлэх зорилготой “Khentii guide” гар утасны аппликейшний бар кодыг үйлчилгээний төв болон тээврийн хэрэгслүүд, зочид буудал, зоогийн газруудад болон цахимаар сурталчлан хандалтын тоог 150-аар нэмэгдүүлэн ажиллаж байна. Мөн аймаг орон нутгаа сурталчлах, таниулах зорилгоор "Хэнтий аймагт тавтай морил сэтгүүл"-ийн мэдээллийг шинэчилж 1000 ширхэг, Аяллын газрын зургийг 1500 ширхгийг шинээр хэвлүүлээд байна. Биелэлт: 100% | 100 |
| Зорилт-7: Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадваржуулах, үйлчилгээний байгууллагуудын чанар, стандартыг сайжруулах сургалт, зөвлөгөөнийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан жил бүр зохион байгуулж, зочид буудлуудын зэрэглэлийг 1 шатаар ахиулна. | Арга хэмжээ 1. Иргэдэд мэргэжил олгох сургалтыг жил бүр зохион байгуулж, 1000 хүртэл хүнийг хамруулна. | Тоогоор | Жил бүр 200 - 300 хүнийг сургаж сертификат олгосон. | Жил бүр 200-300 иргэн хамруулсан байна. | УТ, Төсөл хөтөлбөр | Биндэр сумын ЗДТГ, Гурван голын нүүдэлчид аялал жуулчлалын холбоо хамтран Аялал жуулчлалаас хэрхэн орлого олох, хариуцлагатай аялал жуулчлалын менежмент сургалтад 45 хүн, Дадал суманд зохион байгуулагдсан. Аялал жуулчлалын мэргэжил олгох сургалтад 128 иргэн, Баян-Овоо суманд Монголын Зочид буудлуудын холбоотой хамтран зохион байгуулсан. Үйлчилгээний салбарын ажилчдын харилцаа хандлага сургалтад 70 иргэн хамрагдаж, нийт 3 удаагийн сургалтад 243 иргэнийг хамруулаад байна. Биелэлт: 100% | 100 |
| | Арга хэмжээ 2. Зочид буудал, жуулчны бааз, рестораны 400-с доошгүй удирдлага, үйлчилгээний ажилтныг сургалтад | Тоогоор | Аймгийн хэмжээнд 3 одтой зочид буудал 1, энгийн зочид буудалд 15, дэн буудал 50, жуулчны бааз 36 | Мэргэжлийн сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулж, стандартыг хангуулж, үйлчилгээний чанарыг | ОНТ | 2022 онд Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадваржуулах, үйлчилгээний байгууллагуудын чанар, стандартыг сайжруулах чиглэлээр 6 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 500 гаруй зочид | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамруулж, зочид буудал, жуулчны баазуудын зэрэглэлийг тодорхойлон үнэлгээ хийж ангилан батлагдсан стандартыг хангуулна. | | | сайжруулан,1-ээс доошгүй зочид буудал, жуулчны баазын зэрэглэлийг ахиулна. | | буудал, үйлчилгээний салбарын ажилтан, албан хаагчид, иргэдийг хамрууллаа. 11 сарын 18, 19-нд Зүүн бүсийн аялал жуулчлалын зөвлөгөөн, мэргэжлийн сургалт зохион байгуулагдаж зөвлөгөөнд 180 гаруй төрийн болон хувийн хэвшлийн салбарын төлөөлөгчид, сургалтад 70 гаруй үйлчилгээний салбарын ажилтан албан хаагч, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид оролцлоо. Аймгийн төвийн "КН"-зочид буудлыг од зэрэглэлийн стандартыг хангуулах зорилгоор Монголын Зочид буудлуудын холбоотой хамтран стандартын үнэлгээг хийлгэж байна. Жуулчны баазуудын үйлчилгээнд стандартын дагуу хяналт тавьж, анхан шатны үнэлгээ хийхэд одоогоор 4 улирлын турш тогтмол үйл ажиллагаа явуулдаг жуулчны бааз байхгүй тул зэрэглэлийн шаардлага хангахгүй байна.<br>Биелэлт: 100% | |
| Зорилт-8: Түүх, соёлын өв, байгалийн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газрууд, орон нутгийн онцлогт тохируулан аялагч, амрагч, жуулчдыг татах төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн /морин аялал, завь, агнуур, дугуйн, цанын, уулын спорт г.м/-ийг бий болгож, хөгжүүлнэ. | Арга хэмжээ 1.<br>Жуулчны баазуудыг түшиглэн орон нутгийн онцлог, байгалийн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газруудад төрөлжсөн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно. | Тоогоор | - | Жилд 2-оос доошгүй төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгосон байна. | - | Жуулчны баазуудыг түшиглэн орон нутгийн онцлог, байгалийн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газруудад төрөлжсөн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож хөгжүүлэх зорилгоор Биндэр сумын Чингисийн тоонот жуулчны бааз "Тогорууны баяр" шувуу ажиглах тусгай аяллыг зохион байгуулж байна.<br>“Эзэн Чингис хааны өлгий нутгаар 100 км” сэдвийн дор Хэнтий аймаг дахь явган алхалтын холбоотой хамтран түүх соёлын дурсгалт газруудаар дамжин Өндөрхаан хайрхан руу аялах алхалтын маршрут чиглэлийг гаргаж тусгай аялал 1 удаа зохион байгуулж, 8 аймаг, 9 дүүргийн 70 орчим алхагчдыг хамруулаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Биелэлт: 100% | |
| | Арга хэмжээ 2.<br>Хил залгаа аймаг, сумдтай хамтран аяллын маршрут бий болгоно. | Хэрэгжилтийн явцаар | - | Бүсийн аяллын батлагдсан маршрутыг сурталчилж, цахим орчинд байршуулна. | ОНТ | Хил залгаа Дорнод, Сүхбаатар аймгуудыг холбосон аяллын маршрут зураглал боловсруулж хянуулаад байна. Уг маршрутад 3 аймгийн 84 түүхэн дурсгалт газрууд бүхий нийт 4200 километр замын 15 шөнө 16 өдөр /Зүүн аймгууд нийлсэн/-ийн аялал тусгагдсан. Энэхүү маршрутыг зүүн бүсийн аялал жуулчлалын зөвлөгөөнд танилцуулж, батлуулах бэлтгэл ажлыг хангаад байна.<br>Биелэлт: 90% | 70 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Нутгийн захиргааны байгууллагын манлайллыг хэрэгжүүлж боловсон хүчний бодлогыг тодорхойлох тэдгээрийг сургах давтан сургах, төрийн үйлчилгээний чанар, төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах, иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх хууль тогтоомжийн биелэлтийг тооцон дүгнэх. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Төрийн байгууллага, төрийн албан хаагч хоорондын харилцах дотоод үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, иргэд төрийн үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлэх. | | | | | | | |
| Зорилт-1. Дотоод удирдлагын нэгдсэн систем www.erp.e-mongolia.mn-ийг төрийн байгууллагуудад нэвтрүүлэх баг байгуулж тус багаар дамжуулан холбох ажлыг зохион байгуулна. | Арга хэмжээ 1.<br>Багийн гишүүдийн ажлын чиг үүргийг тодорхойлон төрийн 187 байгууллагад нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | Системд холбогдсон байгууллагын тоо | - | 187-н төрийн байгууллагын 1129 албан хаагчид"erp.e-mongolia.mn" системд холбогдсон байна. | - | 187-н төрийн байгууллагын 1129 албан хаагчид"erp.e-mongolia.mn" системд бүрэн холбогдсон байна.<br>Биелэлт 100% | 100 |
| Зорилт-2. Дотоод удирдлагын нэгдсэн систем www.erp.e-mongolia.mn-ийг нэвтрүүлсэн төрийн байгууллагуудын албан хаагчдын хэрэглээг тогтмолжуулах хяналт тавих ажлыг зохион байгуулна. | Арга хэмжээ-1<br>"erp.e-mongolia.mn" системийг нэвтрүүлэх багийн гишүүдээр дамжуулан хуваарилагдсан байгууллагуудад сар, улирал тутам цахимаар болон биечлэн хяналт тавьж, хэрэглээг тогтмолжуулна. | Системийг хэрэглэж хэвшсэн албан хаагчдын тоо | - | 187 төрийн байгууллагын 1129 албан хаагчид 100 хувь хэрэглэж хэвшсэн байна. | | 187 төрийн байгууллагын 1129 албан хаагчид 100 хувь нь хэрэглэж хэвшсэн.<br>Биелэлт 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-3. “E-MONGOLIA” системийн ач холбогдлыг цахимаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, төрийн байгууллагуудаар дамжуулан иргэд олон нийтэд сурталчлан таниулна | Арга хэмжээ-1 Иргэдэд биечлэн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын албан хаагчдад тулгуурлан сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна. | Төрийн үйлчилгээг биечлэн авсан иргэдийн тоо | 2019 онд төрийн байгууллагаар биечлэн үйлчлүүлсэн иргэд /давхардсан тоогоор/ 316740 | Төрийн үйлчилгээг биечлэн авсан иргэдийн тоог 20 хувиар бууруулна. | ОНТ 35 сая | Төрийн үйлчилгээг биечлэн авсан иргэдийн тоог 15 хувиар бууруулж 21 аймгаас E-mongolia хэрэглэсэн иргэдийн тоогоор 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 5 дугаарт эрэмбэлэгдсэн. Биелэлт 100% | 100 |
| Зорилт-4. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 187 төрийн байгууллагын 4500 төрийн албан хаагчид болон 120 чиглүүлэгч 791 аравт, хэсгийн ахлагч нарт E-MONGOLIA системийг танилцуулах сургалт зохион байгуулж, ашиглаж хэвшүүлэх ажлыг зохион байгуулна. | Арга хэмжээ-1 Жилд 2 удаа сургалт зохион байгуулж, ашиглаж хэвшүүлэх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулна. | Сургалт зохион байгуулсан тоо | | 8 удаа сургалт зохион байгуулсан байна. | ОНТ | 2022 онд E-mongolia системийн ашиглалтын талаарх танилцуулга сургалтыг 18 сумын 88 багт аймгийн удирдлагууд ажиллахад болон сумын е хөтөч хариуцсан албан хаагчид багийн иргэдийн нийтийн хурал дээр тус тус аймгийн хэмжээнд баг бүрт 2 удаагийн сургалт зохион байгуулж 14000 гаруй иргэнийг хамруулсан. Биелэлт 100% | 90 |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Нутгийн захиргааны байгууллагын манлайллыг хэрэгжүүлж боловсон хүчний бодлогыг тодорхойлох тэдгээрийг сургах давтан сургах, төрийн үйлчилгээний чанар, төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах, иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх хууль тогтоомжийн биелэлтийг тооцон дүгнэх. | | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах. | | | | | | | |
